

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2024 оны 12 сарын 11

Д/д	Стратеги төлөвлөгөө	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2024 онд хүрэх зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл хувь
ЗОРИЛГО: НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ӨРГӨЖҮҮЛЭХ, ХОРТ ХАВДРААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЭРТ ИЛРҮҮЛГИЙН ТОГТОЛЦООГ БҮРДҮҮЛЭХ, ХОРТ ХАВДРЫН ЛАВЛАГАА ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ							
ЗОРИЛТ 1: ХОРТ ХАВДРЫН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ, ЭРТ ИЛРҮҮЛГИЙН АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЖ, СУРГАЛТ СУРТАЛЧИЛГАА, УХУУЛГА НӨЛӨӨЛЛИЙН АРГА ХЭМЖЭЭ ХЭРЭГЖҮҮЛНЭ.							
1.1	Хавдрын эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд “Умайн хүзүүний хорт хавдрын цогц заавар” танилцуулах сургалт зохион байгуулна.	70.0	– Зохион байгуулсан сургалтын тоо – Оролцогчийн тоо – Сургалт зохион байгуулсан аймгийн болон дүүргийн тоо	2023 онд 10 аймаг, 9 дүүрэгт сургалт зохион байгуулагдаж, 642 эмч, мэргэжилтэн хамрагдсан.	– Зохион байгуулсан сургалтын тоо-5 – Оролцогчийн тоо-150 – Сургалт зохион байгуулсан аймгийн болон дүүргийн тоо-4-5	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн дархлаажуулалтын албатай хамтран “Хүний папиллома вирусын дархлаажуулалтыг Монгол улсад нэвтрүүлэх” ажлын хүрээнд 21 аймаг, 9 дүүргийн засаг даргын тамгын газар, эрүүл мэндийн газар, нэгдсэн эмнэлгийн дарга удирдлагууд, Баянзүрх дүүргийн өрхийн 200 гаруй эмнэлгийн эмч мэргэжилтнүүдийг хамарсан сургалт зохион байгуулсан. Мөн 2024 оны 11 сарын 25-наас эхлэн улс орон даяар ХПВ-ын вакцин хийж эхлэхтэй холбоотой ЭМЯ, ДЭМБ, ХӨСҮТ-тэй хамтран 21 аймаг, 9 дүүргийн нийт 2000 гаруй эрүүл мэндийн ажилтан сургуулийн захирал, нийгмийн ажилтан, вакцинаторуудыг хамруулсан сургалт зохион байгуулсан. “Хүний папиллома вирусын эсрэг вакцинаар дархлаажуулах” бэлтгэл ажлыг хангах хүрээнд Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Төв аймаг, Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй дүүрэгт зохион байгуулсан сургалтанд ХСҮТ-ийн эмч нар “Умайн	100%

						хүзүүний хорт хавдрын өвчлөл, нас баралтын өнөөгийн байдал, эрсдэлт хүчин зүйл” сэдвээр хичээл зааж хамтран оролцлоо.	
1.2	БСТ-1.1.1 Хавдрын эрт үеийн шинж тэмдэг болон анхдагч эрсдэлт хүчин зүйлсээс сэргийлэх чиглэлээр мэдээлэл сургалт сурталчилгаа, нөлөөллийн ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.	10.0	- Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	2023 онд төлөвлөгөөний хэрэгжилт- 80%. Байгууллагын нүүр хуудасны хандалтын тоо -60 000 байсан. Үйл ажиллагаанд 1500 хүн хамрагдсан.	- Тухайн жилд төлөвлөсөн ажлуудыг бүрэн хэрэгжүүлсэн байна.	2024 оны МСС-ны ажлын батлагдсан төлөвлөгөөнд 9 чиглэлийн дагуу ажил төлөвлөгдсөн. Үүнээс: – Хавдраас урьдчилан сэргийлэх мэдээлэл сурталчилгаа, видео шторк хийх, олон нийтэд зориулсан сургалт, төвийн үйл ажиллагааг сурталчлах, ажил мэргэжлийг сурталчлах, төвийн ажилтнуудад зориулсан сургалт, кампанит зэрэг 6 үйл ажиллагаа 100%-гүйцэтгэлтэй бүрэн хэрэгжсэн. – ЕБС-ийн эмч, нийгмийн ажилтан, ерхийн эмч нарт зориулсан сургалт, дэмжих тусламж үйлчилгээний сэдвээр гарын авлага материал боловсруулах, үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн боловсролын цагаан толгой боловсруулах зэрэг 3 үйл ажиллагаа 85-90%-ийн гүйцэтгэлтэй үргэлжлэн хийгдэж байна. МСС-ны жилийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Нэгдүгээр хавсралтаар хавсаргав. <u>Хэрэгжүүлсэн зарим ажлуудаас дурдвал:</u> – Зонхилон тохиолдох хорт хавдруудаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн сэдвээр 20-н төрлийн цуврал постер зөвлөмжийг НЭМҮТ-тэй хамтран боловсруулж цахим хэлбэрээр түгээсэн. – Зонхилон тохиолдох хавдрын урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээ, хавдрыг даван туулах болон сэтгэл зүйн сэдвээр нийт 12 удаагийн лайв зөвлөгөөг ХСҮТ дангаараа болон НЭМҮТ-тэй хамтран хийсэн. – Хавдрын эрсдэлт хүчин зүйлс ба хавдрын эрт илрүүлэг сэдвээр 2 төрлийн видео шторк хийж олон нийтийн цахим сүлжээ болон МҮОНТ, UBS,	100%

					<p>Малчин, С1, ТВ5, Ийгл ТВ-ээр давтамжтайгаар түгээсэн.</p> <ul style="list-style-type: none"> - “Эмчийн нэг өдөр” 3-н цуврал баримтат киног толгой хүзүүний нөхөн сэргээх мэс засал, улаан хоолойн хавдрын дурангийн мэс засал, элэгний хавдрын үеийн элэг шилжүүлэн суулгах мэс засал зэрэг зөвхөн ХСҮТ-д хийгддэг мэс засал эмчилгээний сэдвээр бэлтгэн МҮОНТ, UBS TV, ТВ-5, ТВ-9, Малчин ТВ-ээр олон нийтэд цацаж хавдрын мэс заслын эмчийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний онцлогийг сурталчилсан. - Цаг үеийн үйл явдал болон хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний талаарх ярилцлага, мэдээ зэрэг 200 гаруй мэдээллийг 20 гаруй телевиз, Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ сонин болон сайтууд зэрэг 20 гаруй хэвлэл мэдээллээр дамжуулан хүн амд хүргэсэн. - Олон нийтэд зориулсан сургалтыг Тайваны хүүхэд гэр бүлийн хөгжлийг сан-68 хүн, 84-р сургуулийн 7-р ангийн 60 сурагч, УБ театрын 100 ажилтан, хэвлэл мэдээллийн сэтгүүлч 20 хүн, өрхийн эмч, ЕБС-ийн эмч 150 хүн, Угсаатны соёл, хэл хуурын холбооны 200 гаруй хүн зэрэг 600 гаруй хүнд 7 удаагийн сургалт хийсэн. - Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил, Дэлхийн тамхигүй өдөр, Хавдрын эсрэг Дэлхийн өдөр, Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын Дэлхийн өдөр, Хөхний хавдрын сард зориулсан 5-н удаагийн кампанит ажлыг зохион байгуулж, 1500 гаруй хүнийг хамрууллаа. - МҮОНР-той хамтран элэг, ходоод, умайн хүзүү, хөх, уушигны хорт хавдрын сэдвээр 5-н цуврал зөвлөгөө өгөх нэвтрүүлгийг мэргэжлийн эмч нарыг оролцуулан хийсэн. 	
--	--	--	--	--	---	--

						<ul style="list-style-type: none"> – Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, ХПХВ-ын эсрэг дархлаажуулалтын сэдвээр телевизийн хэлэлцүүлгийг МҮОНТ-тэй хамтран НЭМҮТ, ХӨСҮТ, Хавдрын үндэсний зөвлөл ТББ, даван туулагчдын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. – Хавдрын хяналтын хөтөлбөр боловсруулах ЭМЯ-ны ажлын хэсэгт хорт хавдраас урьдчилан сэргийлэх чиглэлээр НЭМҮТ-тэй хамтран ажиллаж байна. Энэ хүрээнд зонхилон тохиолдох 7-н байрлалын хорт хавдрын анхдагч урьдчилан сэргийлэлтийн сэдвийн агуулга, чиглэлийг боловсруулж байна. 	
1.3	БСТ-1.3.1 Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгт байгууллага, хувь хүний үүрэг, оролцоог нэмэгдүүлэх сурталчилгаа, нөлөөллийн уулзалтыг зохион байгуулна	–	<ul style="list-style-type: none"> – Хийгдсэн сургалтын тоо – Шийдвэр гаргагч нарт зориулсан нөлөөллийн уулзалтын тоо 	Хэвлэл мэдээллийн сэтгүүлчдийн сургалт 1 удаа, Баруун бүсийн удирдах ажилтны зөвлөгөөн, Урлагийн байгууллагын удирдах ажилтнуудын зөвлөлдөх уулзалт тус тус зохион байгуулсан	<ul style="list-style-type: none"> – Сэтгүүлчид зориулсан сургалт зохион байгуулж, 40-өөс доошгүй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтанг оролцуулсан байна. 	<ul style="list-style-type: none"> – Хавдрын дэлхийн өдрийг тэмдэглэх хүрээнд “Цагаан үзэг” холбоотой хамтран сургалт зохион байгуулж, 30 сэтгүүлч хамрагдсан. – ХСҮТ, НЭМҮТ, ХӨСҮТ, Хавдрын үндэсний зөвлөл ТББ-ын удирдлагуудад танилцуулга мэдээлэл хийсэн. – Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн сэдвээр Тайваны гэр бүлийн сантай хамтран эмзэг бүлгийн айл өрхийн 68 хүнд 1 удаа сургалт зохион байгуулсан. – Сувилахуйн албанаас үйлчлүүлэгчид болон олон нийтэд зориулсан “Бид таны туслагч” сэдэвт сувилагчийн нэг өдөр өдөрлөгийг 7 тасаг баталсан төлөвлөгөөний дагуу зохион явуулж, 577 хүнийг хамруулан сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. – Хавдрын эсрэг аяны хүрээнд Баян-Өлгий, – Баянхонгор аймгийн Засаг дарга, тамгын газар, ИХТ-ийн дарга, ЭМГ, Нэгдсэн эмнэлгийн дарга, удирдлагуудтай уулзалт зохион байгуулж, ухуулга, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. 	100%

ЗОРИЛТ 2. ХОРТ ХАВДРЫН БҮРТГЭЛИЙН ЧАДАВХИЙГ САЙЖРУУЛНА							
2.1	БСТ-2.1 Хорт хавдрын бүртгэл судлалаар байрны дагалдан сургалт зохион байгуулна.	-	- Зохион байгуулсан сургалтын тоо - Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо	2023 онд аймаг дүүргийн хавдрын бүртгэлийн ажилтнуудад сургалт 30 бүртгэгч хамрагдсан	Аймаг дүүргийн хавдрын бүртгэлийн ажилтанд зориулсан зайн сургалтыг 2-оос доошгүй удаа зохион байгуулж, 30 ажилтан хамруулна.	- 21 аймаг, 9 дүүргийн хавдар бүртгэгч нарыг хамруулсан цахим сургалтыг нийт 4 удаа зохион байгуулж, хорт хавдрын өвчлөл, нас баралт, хяналтын сарын мэдээ, мэдээний сангийн үйл ажиллагааг хэрхэн удирдах, ашиглах талаар сургаж дадлагажууллаа. - Хавдар бүртгэгчийн баримжаа олгох 14-21 хоногийн ажлын байрны дадлага сургалтанд 5 аймгийн, Баянгол дүүргийн нийт 6 хавдар бүртгэгчдийг хамруулсан. - Хавдрын бүртгэл судлал сэдэвт цахим сургалтын модуль боловсруулж, ЭМХТ-тэй хамтран видео контент бэлтгэж, ЭМХТ-ийн цахим хуудсанд байршуулж, цахим сургалт зохион байгуулж байна.	100%
ЗОРИЛТ 3: ХОРТ ХАВДРЫН ЛАВЛАГАА ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛНА.							
3.1 ХСҮТ-ийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах							
3.1.1	БСТ-3.1.3 ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоо, стандартыг магадлах баталгаажилт хийлгэнэ	3.4	Баталгаажилт хийсэн аудитийн дүгнэлт Стандартын хэрэгжилтийн хувь	2022, 2023 ондуудад баталгаажилт хийгдсэн болно.	Хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлж, ISO 9001:2015 стандартыг 90 ба түүнээс дээш хувь хэрэгжүүлсэн байна.	2024 оны 03 сарын 21-нд “Эс Эф Си Эс” ХХК нь “ISO 9001:2015” магадлах аудит хийсэн. Аудитийн дүгнэлтээр 2 жижиг үл тохирол, сайжруулах 3 саналтайгаар “Стандартын шаардлага үргэжлүүлэн хангаж байна” гэж дүгнэсэн.	100%
3.1.2	Төвийг магадлан итгэмжлэлийн үйл ажиллагаанд хамруулна.	1.0	- Магадлан итгэмжлэлийн гэрчилгээ - Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	2024 оны 03 сарын 19-д магадлан итгэмжлэлийн хугацаа дуусна. 2023 оны магадлан	- ЭМС-ын тушаалаар магадлан итгэмжлэлийг сунгуулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/554 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын дагуу Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагыг магадлан шинжлэх шалгуурын дагуу магадлан үнэлгээ хийгдэж, 3 жилийн хугацаатайгаар магадлан итгэмжлэлийн гэрчилгээг авсан.	100%

				итгэмжлэлийн хүсэлт илгээсэн.	- Зөвлөмжийг 90%-иас дээш хэрэгжүүлсэн байна.		
3.1.3	БСТ-3.1.1 Стандарт үйл ажиллагааны зааварчилгаа (СҮАЗ) болон журмын хэрэгжүүлэлтийг сайжруулж, шинэчлэн боловсруулна	-	- Шинэчлэгдсэн СҮАЗ-ын тоо - СҮАЗ-ын хэрэгжилтийн хувь	2020 онд 34 тасаг, алба стандарт үйл ажиллагааны зааварчилгааг шинээр боловсруулсан хэрэгжүүлж эхэлсэн.	- 5-аас доошгүй тасгийн үйл ажиллагааны СҮАЗ-ыг боловсруулсан байна. - Стандарт үйл ажиллагааны зааварчилгааг 80%	Дотоод хяналтын төлөвлөгөөнийн дагуу СҮАЗ-ийн шинэчлэл хийгдэж байна. Мэдрэлийн мэс засал, Урологийн мэс засал, Халдвар хяналт сэргийлэлтийн алба, Хөхний төв, Санхүү эдийн засгийн алба, Даатгал статистикийн албаны СҮАЗ шинэчлэгдсэн. Стандарт үйл ажиллагааны зааварчилгааг 80% хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
3.1.4	Тохиолдол эрсдэлийн бүртгэл, мэдээллийг сайжруулах хүрээнд мэдээллийн санд бүртгэгдсэн тохиолдол бүрийн шалтгаан хамаарлыг тогтоох судалгаа хийж, дүгнэлтэд үндэслэн урьдчилан сэргийлэх ажил хэрэгжүүлнэ.	-	- Мэдээллийн санд бүртгэгдсэн тохиолдлын хувь - Шалтгаан хамаарлын судалгаа хийсэн тохиолдлын хувь - Зөвлөмжийн дагуу төлөвлөсөн урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийн хувь	2023 онд Эрүүл мэндийн хөгжлийн төвийн тохиолдол эрсдэл бүртгэх мэдээллийн санд 26 тохиолдол бүртгэгдсэн. Шалтгаан хамаарлын судалгааг 10%-д хийсэн. Урьдчилан сэргийлэх 26 арга хэмжээ хэрэгжүүлсэн.	- Мэдээллийн санд бүртгэгдсэн тохиолдлын хувь-90% - Шалтгаан хамаарлын судалгаа хийсэн тохиолдлын хувь-80%-иас дээш - Зөвлөмжийн дагуу төлөвлөсөн урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилтийн хувь-90%-иас доошгүй байна.	- 2024 оны 10 сарын 31-ний байдлаар эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой эмнэлзүйн 21, эмнэлзүйн бус 5 нийт 26 эрсдлийн тохиолдол бүртгэн, шалтгааныг арилган шийдвэрлэсэн. - 2024 оны эрсдлийг бууруулах төлөвлөгөөнд нийт 84 ажил төлөвлөсөн ба үүнээс 70% нь эмнэлзүйн эрсдэл, 30% нь эмнэлзүйн бусэрсдэл байна. Төлөвлөгөө 90%-ийн хэрэгжилттэй байна. Бүртгэгдсэн эрсдлийн тохиолдлуудыг дахин гарахаас сэргийлэхийн тулд хэлэлцүүлэг зохион байгуулж, сэргийлэх хариу арга хэмжээг цаг тухайд нь хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 онд дараах үйл ажиллагааг зохион байгуулсан. Үүнд: Сахиурын журам-ыг шинэчлэн, өвчтөний асаргаа, ар гэрийн асаргааны чиглэлээр сургалт зохион байгуулж байна. 2022 оны А/352 тоот тушаал, ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2022 оны А/52 тоот "Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам"-ыг танилцуулах сургалтыг Хагалгаа, мэдээгүйжүүлгийн нэгдсэн тасгийн 35 сувилагчид сургалт зохион	100%

						байгуулсан. ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны А/79 дугаар тушаалаар батлагдсан “Үйлчлүүлэгчийн унах эрсдлийг үнэлэх журам”-ыг танилцуулж, унах эрсдлээс сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулсан. Тарилгын стандарт, тарилгын аюулгүй байдлын чиглэлээр сургалт зохион байгуулж, бүх сувилагч хамрагдсан.	
3.1.5	Халдвар хяналт, сэргийлэлтийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь Хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ	2023 онд 11 удаа хяналт хийгдэж, ЭТҮХХ-ийн 168 /0.41%/ илэрсэн.	Төлөвлөсөн ажлыг 90%-иас доошгүй хэрэгжүүлсэн байна. Халдварын тохиолдлол, үед оновчтой хариу арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.	Халдварын хяналт сэргийлэлтийн төлөвлөгөөнд 5 зорилтын дор 33 үйл ажиллагаа төлөвлөн хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-95.8% Мэс заслын дараах шархны халдвар 2023 онд 141 /2,32%/ байсан бол 2024 онд 105 тохиолдол бүртгэгдсэн. Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдол, дэгдэлтийн үед тухай бүрт нь дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээг цаг тухайд нь оновчтой авч хэрэгжүүлсэний үр дүнд дэгдэлтийг таслан зогсоож халдварын тохиолдлын тоог өмнөх оныхоос 25%-иар бууруулсан. Нийт 67-н удаа зөвлөмж өгч ажилласан зөвлөмжийн хэрэгжилтийн хувь-89,5.	89,5%
3.1.6	Байгууллагын үйлчилгээний стандартын дагуу хаягжилт, дуугүй хөтөчийг шинэчлэх, сайжруулна.	-	- Шинэчилсэн дуугүй хөтөчийн тэмдэг, тэмдэглэгээг хийсэн тоо - Дотно, гадна хаягжилтын шинэчилсэн байдал	- Дуугүй хөтөч, тэмдэглэгээг жил үр шинэчлэн хийдэг.	- Шинэчилсэн дуугүй хөтөчийн тэмдэг, тэмдэглэгээг бүрэн шинэчилсэн байна. - Дотно, гадна хаягжилтыг бүрэн шинэчилсэн байна.	Амбулаторийн тасгийн дуугүй хөтөчийг шинэчлэх ажлыг бүрэн дуусгасан. Хаяг шинэчлэх ажил хийгдэж байна.	70%

3.1.7	Засварын ажлын төлөвлөгөө батлан, төлөвлөгөөний дагуу засвар үйлчилгээг гүйцэтгэнэ.	–	– Засвар үйлчилгээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	– 2023 оны засварын ажил төлөвлөгөөний дагуу 85% гүйцэтгэлтэй.	– Төлөвлөсөн ажлыг -90%-иас доошгүй хэрэгжүүлсэн байна.	<p>Байгууллагын урсгал болон их засварын төлөвлөгөөнд 13 ажил төлөвлөн хэрэгжүүлсэн. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> – ХСҮТ-ийн В1 давхрын бялдаржуулах өрөөний засвар, галын цэгүүдийн иж бүрдэл, тохижилтын ажил, SIGMA ачааны лифтийн засварн угаалгын хэсгийн засвар, элэг цөс нойр булчирхайн мэс заслын тасгийн, мэс заслын өрөөний агааржуулалтын засварын ажил, гал тогооны таазны засар, туяа тасгийн в блокын их засвар, өргөтгөлийн барилгын ЦТП-ын засварын ажлууд зэрэг 8 ажлыг 100%ийн гүйцэтгэлтэй хийж гүйцэтгэсэн. – Лабораторийн тасгийн их засвар, ариун цэврийн өрөөнүүдийн их засвар-80% – дулаан хангамжийн шугамын шинэчлэлийн ажил зэрэг 3 ажил, тендер зарлаж, ажил гүйцэтгэх гэрээ хийгдэж засварын ажил эхэлсэн. Гүйцэтгэл 70% – Өргөтгөлийн барилгын цахилгааны хаалттай дэд өртөөнд /ABP/ автомат сэлгэн залгуур суулгах, төвийн халаах хэрэгслүүд, /радиатор/ босоо шугамыг иж бүрэн шинэчлэх их засварын ажил зэрэг 2 ажил хийгдээгүй. <p>Төлөвлөгөөний хэрэгжилт- 78%</p>	78%
3.1.8	Олон улсын олон мэргэжлийн эмч мэргэжилтэний хамтарсан зөвлөгөөнийг хуваарийн дагуу тогтмол хийнэ.	–	– Батлагдсан хуваарь – Хуваарийн дагуу зохион байгуулсан зөвлөгөөний тоо – Зөвлөгөөнөөр шийдвэрлэсэн тохиолдлын хувь	– АНУ, Герман зэрэг дэлхийн өндөр хөгжилтэй орны нарийн мэргэжлийн эмч нарын багтай хамтарсан зөвлөгөөнийг 28 удаа хийж,	– 2024 онд оношилогдсон хөхний хавдрын тохиолдлын 50% олон улсын зөвлөгөөнөөр орсон байх – 30-аас цөөнгүй олон улсын	<p>Олон мэргэжлийн эмч мэргэжилтний хамтарсан олон улсын зөвлөгөөнийг 2024 онд 35 удаа хийж, 336 өвчтний асуудлыг шийдвэрлэсэн.</p> <p>Хөхний төвд Германы SES, Tuebingen Их сургуулийн профессоруудтай долоо хоног бүр хийгддэг зөвлөгөөнөөр 25 удаагийн зөвлөгөөнөөр 321 өвчтний тохиолдол хэлэлцсэн байна.</p> <p>Юта-Миннесотагийн их сургуультай хамтарсан зөвлөгөөнд 10 удаагийн зөвлөгөөнөөр 15 тохиолдол хэлэлцсэн.</p>	100%

			-	60 гаруй өвчтөний эмчилгээ, оношилгооны асуудлыг шийдвэрлэсэн.	зөвлөгөөн хийсэн байна	Мэс заслын болон туяа, хими эмчилгээний тасгууд дотоодын олон мэргэжлийн эмч нарын багийн хамтарсан зөвлөгөөнийг 2024 оны эхний 10 сарын байдлаар 57 удаа зохион байгуулж, 739 өвчтний асуудлыг хэлэлцэж, эмчилгээ оношлогооны шийдвэр гаргасан. Хөхний төвөөр тусламж үйлчилгээ авч зөвлөгөөнд орж буй эмчлүүлэгчдийн 76% нь олон мэргэжилтний хамтарсан тусламж үйлчилгээ авсан байна. Туяа, хими эмчилгээний тасгууд олон улсын олон мэргэжлийн зөвлөгөөнийг 24 удаа зохион байгуулсан.	
--	--	--	---	--	------------------------	--	--

ЗОРИЛТ 4: ХОРТ ХАВДРЫН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ЧАНАР ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛНА.

4.1 Хорт хаврын оношилгооны чанар, хүртээмжийг сайжруулна.

4.1.1	БСТ-4.1.4 Хавдрын мутаци тодорхойлох шинжилгээний тоо, төрлийг нэмэгдүүлнэ.	-	- Шинээр нэвтрүүлсэн шинжилгээний төрөл - Мутаци тодорхойлох шинжилгээний тоо	2023 оны байдлаар 5 төрлийн мутац тодорхойлж бай эмчилгээний сонголт хийхэд ашиглаж байна.	- 2 төрлийн мутаци тодорхойлох шинээр нэвтрүүлсэн байна. - 50 хүнд	Хавдрын мутаци тодорхойлох шинжилгээ 2024 оны эхний 11 сарын байдлаар 110 хийгдсэн. 2024 онд хорт хавдрын оношилгоонд 2 мутацийг шинээр нэвтрүүлсэн. Хавдрын мутаци тодорхойлох шинжилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн шинээр BRCA-I, BRCA-2 шинжилгээ нэвтрүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. . 24 хүнд шинжилгээ хийгдсэн. NGS оношилгооны аппаратыг санхүүгийн бэрхшээлийн улмаас худалдан авч чадаагүй тул хавдрын мутаци тодорхойлох шинжилгээний төрлийг нэмэгдүүлэх ажил удааширч байна.	70%
4.1.2	TARE (Элэгний хавдар тэжээгч артерийн судсыг радио идэвхит бодисоор бөглөх) эмчилгээг	-	- Сургалтад хамруулсан эмч, мэргэжилтэний тоо - Боловсруулсан эмчилгээний заавар	TARE эмчилгээ нэвтрээгүй байна.	- Сургалтад хамруулсан эмч, мэргэжилтэний тоо-2 - Боловсруулсан эмчилгээний заавар-1	TARE (Элэгний хавдар тэжээгч артерийн судасыг радио идэвхит бодисоор бөглөх) эмчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд Оросын холбооны улсын Хавдар судлалын үндэсний төвд эмч, мэргэжилтэнүүдийг сургахаар гэрээ байгуулан ажиллаж байна. Эмчилгээний зааврыг боловсруулах ажил хийгдэж байна.	40%

	нэвтрүүлэх бэлтгэл хангана.						
4.1.3	БСТ-4.2.3 MRI аппарат суурилуулж, оношилгоонд ашиглана.	1500.0	– Төхөөрөмж суурилуулалтын ажлын тайлан – MRI- оношилгоонд хамрагдсан хүний тоо	MRI-аппаратын тендер зарлагдаж, нийлүүлэгч сонгогдсон.	– Тоног төхөөрөмжийг суурилуулж ашиглаж эхэлсэн байна. – MRI оношилгоонд хамрагдсан хүний тоо-100-аас цөөнгүй хүн	Тоног төхөөрөмж худалдан авалт, нийлүүлэх ажил журмын дагуу явагдаж байна. Суурилуулах өрөөний барилгын засвар хийгдсэн.	60%
4.1.4	Дурангийн төв байгуулна.		-Засварын ажлын гүйцэтгэлийн хувь -Дурангийн тусламж үйлчилгээнд хамрагдсан хүний тоо -Шинээр ханган нийлүүлсэн дурангийн аппарат	Дурангийн төвийн барилгын засварын зураг болон ТЭЗҮ хийгдсэн.	– Барилгын засварын ажил 80% – Дурангийн тусламж үйлчилгээнд хамрагдсан хүн 30 хүртэл хувиар нэмэгдсэн байна. – Шинээр ханган нийлүүлсэн дурангийн аппарат-20	Дурангийн төвийн засварын ажлын ТЭЗҮ хийгдэж тендер зарлагдаж, барилгын ажил эхэлсэн. Засварын ажлын гүйцэтгэл 40%-тай явж байна. 40 ширхэг Дурангийн аппаратын худалдан авалтын тендер зарлагдаж, нийлүүлэгчийг сонгосон бөгөөд нийлүүлэлтийн шатандаа ажил үргэлжилж байна.	80%
4.2 Хавдрын мэс засал эмчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.							
4.2.1	БСТ-4.3.2, 4.1.2 Элэг шилжүүлэн суулгах мэс заслын үеийн	–	– Батлагдсан оношилгооны шинэ алгоритм	Одоо гематоксиллин эозины арга хэрэглэж байна	– Элэг ховхрох хүндрэлийг оношилох шинэ	– Элэг ховхрох хүндрэлийг оношилох шинэ алгоритмыг боловсруулсан. Эмнэл зүйн хороогоор батлуулахаар бэлтгэл ажил хангагдсан.	70%

	хүндрэл элэгний ховхорлыг оношлох олон улсын практикт нийцсэн алгоритм боловсруулж, ашиглана.		– Элэг ховхрох хүндрэл буурсан хувь – Шинээр нэвтрүүлсэн оношилгооны төрөл	Жилд дундажаар элэг ховхрох хүндрэл 20% бүртгэгдэж байна.	алгоритмийг ашиглаж эхэлсэн байна. – Шинэ алгоритм ашигласнаар уг хүндрэл өмнөх оныхоос 10% буурсан. – Иммуногистохими шинжилгээний 8 төрөл шинээр нэмэгдсэн байна.	– Иммуногистохимийн шинжилгээний 8 төрөл шинээр нэмэгдсэн. – 2024 оны 12-р сард эмч, мэргэжилтэнүүд гадаад сургалтад хамрагдах гэж байна. – Уг хүндрэл 2023 онд 10-н тохиолдол бүртгэгдэж байсан бол 2024 онд 8 тохиолдол бүртгэгдэж, 2 тохиолдлоор буурсан.	
4.2.2	БСТ-4.3.1 Умайн хүзүү болон өндгөвчний хорт хавдрын мэс засалд эрхтэн хадгалах шинэ технологи нэвтрүүлнэ.	–	– Шинээр нэвтрүүлсэн технологийн тоо – Шинэ арга, технологи ашиглан амжилттай эмчилсэн хүний тоо	2023 онд нөхөн үржихүйн эрхтэн хадгалах мэс заслыг нэвтрүүлсэн.	– Эмэгтэйчүүдийн мэс засалд дурангийн мэс заслын 2 шинэ технологи – Шинэ арга, технологи ашиглан 10 тохиолдолд амжилттай мэс засал	Умайн хүзүү болон өндгөвчний хорт хавдрын мэс засалд эрхтэн хадгалах 2 шинэ технологи нэвтрүүлсэн. 1. Үтрээний хүрцээр нэг оролттой хэвлийн дурангаар өндгөвчний хавдар авах мэс заслыг нэвтрүүлсэн. 2. Том хэмжээтэй миомын хоргүй хавдрыг хэвлийн дурангаар “Morcellator” багаж ашиглан жижиглэж авах мэс заслыг нэвтрүүлсэн. 3. Дээрх шинэ технологийг ашиглан 10 мэс заслыг амжилттай хийсэн.	100%
4.2.3	БСТ-4.5.2 Төвөнхийн лазер мэс заслын үйлдлийн удирдамж боловсруулж батлуулна.	–	– ЭМС-аар батлагдсан эмнэлзүйн удирдамж	Уг технологи нэвтрээгүй	Төвөнхийн лазер мэс заслын удирдамжийг Эмнэлзүйн хороогоор батлуулсан байна.	Үйлдлийн удирдамжийг боловсруулах шатандаа байна.	40%

4.2.4	БСТ-4.9.4 Орон нутагт эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлэх чадавхийг нэмэгдүүлнэ.	-	<ul style="list-style-type: none"> - Зохион байгуулсан сургалтын тоо - Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо - Аймаг, дүүргийн эмнэлэгт хамтран хийсэн мэс заслын тоо - Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал хийж эхэлсэн аймгийн тоо 	2023 онд эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын эмч Увс, Дорнод, Өмнөговь аймагт 3-5 хоног сэлгэн ажиллаж, 10 эмчийг ажлын байранд дагалдуулан сургаж, эмэгтэйчүүдийн хавдрын 5 мэс заслыг тухайн аймгийн эмч нартай хамтран хийсэн.	<ul style="list-style-type: none"> - 3-4 аймагт сургалт - Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо-30-аас цөөнгүй - 10 болон түүнээс цөөнгүй хавдрын мэс заслыг аймаг, дүүргийн эмнэлэгт хамтран амжилттай хийсэн байна. - Эмэгтэйчүүдийн зарим төрлийн хавдрын мэс засал хийж эхэлсэн аймгийн тоо-3-4 аймаг 	Эмэгтэйчүүдийн мэс заслын тасгийн эмч нар 2024.03.20-24ны өдрүүдэд Сүхбаатар, Хөвсгөл, Увс, Өмнөговь аймагт ажиллаж, аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн эх барих эмэгтэйчүүдийн эмч нарт ажлын байрны дагалдан сургалт зохион байгуулж, 100 эмч, мэргэжилтэн хамрагдсан. Мөн аймгийн дээрх аймгуудын эмч нартай хамтран эмэгтэйчүүдийн хорт хавдрын 18 мэс заслыг орон нутгат нь амжилттай хийсэн. Аймгийн эмч нартай хамтран зөвлөгөөн хийж, 93 өвтөний оношилгоо, эмчилгээ хяналтын асуудлыг шийдвэрлэж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. Үүний үр дүнд Сүхбаатар, Увс аймгуудад эмэгтэйчүүдийн хорт хавдрын зарим мэс заслыг хийж эхэлсэн.	100%
4.2.5	Робот мэс засал нэвтрүүлэх бэлтгэл ажил хангана.	100.0	<ul style="list-style-type: none"> - Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо - Сургалтын тоног төхөөрөмжийн хангалт 	Уг технологи нэвтрээгүй сургалтын тоног төхөөрөмжөөр хангагдаагүй	<ul style="list-style-type: none"> - Сургалтын дуураймал орчинд мэс заслын эмч нарын 50-иас доошгүй хувийг сургалтад хамруулсан байна. 	ХСҮТ-д REVO-I брэндийн Робот мэс заслын Console-бүхий "Робот мэс заслын сургалтын төв" байгуулагдсан. Робот мэс заслын сургалтын төвийн ажиллах журам, төлөвлөгөөг боловсруулан мөрдөж ажиллаж байна. ХСҮТ-ийн Мэс заслын эмч нарын 60 гаруй хувь сургалтад хамрагдаад байна.	100%

4.2.6	Хавдрын мэс засалд 3D-ICG технологи нэвтрүүлнэ.	500.0	<ul style="list-style-type: none"> - Шинээр ханган нийлүүлсэн тоног төхөөрөмж - Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо - Амжилттай хийсэн мэс заслын тоо 	Хавдрын мэс засалд 3D-ICG технологи нэвтрээгүй байна.	<ul style="list-style-type: none"> - 3D-ICG аппаратаар хангасан байна - Уг технологид ажлын байрны сургалтад 20-иос цөөнгүй эмч, мэргэжилтэний г сургасан байна. - 10-аас цөөнгүй мэс заслыг амжилттай хийсэн байна. 	<ul style="list-style-type: none"> - 3D-ICG аппаратыг ханган нийллүүлж, хорт хавдрын мэс засалд ашиглаж байна. - Элэг цөс, нойр булчирхай, эмэгтэйчүүд, урологийн, хөхний мэс засалд уг технологийг амжилттай хэрэглэж байна. Уг технологийг ашиглан 50 гаруй мэс заслыг амжилттай хийсэн. - 2024 онд Хөхний төв нь харуул тунгалгийн булчирхай болон нөхөн сэргээх мэс заслын үеийн далбангийн цусан хангамжийг ICG тодосгогч бодисоор шалгах технологийг нэвтрүүлсэн. хэрэглэж байна. - Мэс заслын эмч нар бүрэн сургагдсан. 	100%
4.2.7	<u>БСТ-4.3.5</u> Уян дурангаар ходоодны салстын доорх хавдруудыг авах хагалгааны удирдамж боловсруулж батлуулж, ажиллана	-	<ul style="list-style-type: none"> - Батлуулсан удирдамж - Ходоодны салстын доорх үүсгэвэр авах хагалгааны тоо 	- Уян дурангийн аргаар ходоодны салстыг хуулах мэс засал 10-с доошгүй хийгдсэн.	<ul style="list-style-type: none"> - Удирдамж боловсруулж Эмнэлзүйн хороогоор батлуулсан байна - Хийсэн хагалгааны тоо 20-с доошгүй байна 	Уян дурангийн аргаар ходоодны салстын доорх хавдруудыг авах хагалгааны удирдамжийг боловсруулан, ЭМЯ-ны холбогдох мэргэжлийн нийгэмлэг, холбооноос санал зөвлөмж авахаар хүргүүлсэн байна. 2024 онд Уян дурангийн аргаар ходоодны салстын доорх хавдар хуулах 170 хагалгааг хийсэн.	90%
4.2.8	<u>БСТ-4.3.7</u> Мэдрэлийн мэс заслын баг бүрдүүлж, мэдрэлийн мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлж эхэлнэ.		<ul style="list-style-type: none"> - Сургаж бэлтгэсэн эмч, мэргэжилтэний тоо - Ханган нийлүүлсэн тоног төхөөрөмжийн тоо 	- Нейронкологи төвийн төслийн хүрээнд 2 мэдрэлийн мэс заслын эмч бэлтгэгдсэн.	<ul style="list-style-type: none"> - Сургаж бэлтгэсэн эмч, мэргэжилтэний тоо-3 - Ханган нийлүүлсэн тоног төхөөрөмжийн 	<ul style="list-style-type: none"> - Нейронкологи хөгжүүлэх зорилгоор мэдрэлийн мэс заслын амбулаторийн үзлэгийн өрөөг шинээр зохион байгуулсан. - Нейронкологи төвийн төслийн хүрээнд мэдрэлийн мэс заслын 3 эмчийг Тайвань улсын Үндэсний их сургуульд 1 сарын хугацаатай сургалтад хамруулж, мэдрэлийн мэс заслын багийг сургаж бэлтгэсэн. 	100%

			-		тоо-1 иж бүрдэл	<ul style="list-style-type: none"> – 2024 онд 12 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмж багтсан мэдрэлийн мэс заслын иж бүрдэл ханган нийлүүлж тусламж үйлчилгээнд ашиглаж байна. Уг тоног төхөөрөмжийг ашиглаж мэдрэлийн мэс заслын 15 төрлийн 61 мэс заслыг амжилттай хийсэн. – Мэдрэлийн мэс заслын амбулаторийн кабинетийг шинээр нээж, мэдрэлийн хавдрын үзлэг хийж эхэлсэн ба энэ онд 500 гаруй хүнд амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. 	
4.2.9	БСТ-4.3.4 Онкоурологийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.		<ul style="list-style-type: none"> – Амжилттай хийсэн мэс заслын тоо – Амбулаторийн кабинетээр үйлчлүүлсэн хүний тоо 	Онкоуроло-гийн хагалгааны болон оношилгооны багажийн иж бүрдэл багажаар хангасан. 2023 онд 107 мэс засал. 355 хүнд амбулаторийн үзлэг хийсэн.	Онкоурологийн кабинетийн үйл ажиллагаа эхэлж, 500-аас хүнд үйлчилсэн байна 150-аас цөөнгүй хүнд урологийн мэс заслыг амжилттай хийсэн байна.	2024 оны эхний 11 сарын байдлаар Онкоурологийн кабинетын үйл ажиллагаа тогтмолжиж, тайлангийн хугацаанд бөөр, шээсний замын хавдартай 1441 хүнд амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлж, 153 хүнд бөөр шээсний замын хавдрын мэс заслыг амжилттай хийсэн.	100%
4.3 Хорт хавдрын туяа, хими эмчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.							
4.3.1	Туяа эмчилгээнд True Beam шугаман хурдасгуурыг нэвтрүүлнэ.	-	<ul style="list-style-type: none"> – Суурилуулж, тохируулга хийгдсэн шугаман хурдасгуур аппарат – Шинээр нэвтрүүлсэн технологи 	True Beam шугаман хурдасгуур нэвтрээгүй. Аппарат суурилуулах бункерын засвар хийгдсэн. Тоног төхөөрөмжийн	<ul style="list-style-type: none"> – Шугаман хурдасгуур аппарат суурилуулж, тохируулга хийгдсэн байна. – Туяа эмчилгээнд True Beam шугаман 	<ul style="list-style-type: none"> – Truebeam шугаман хурдасгуурын хэмжилт тохируулгыг 2024 оны 1 сард дуусгасан. 3 дугаар сарын 8-22 ний өдрүүдэд ОУАЭА-ийн “End-to-end” хөндлөнгийн аудитийн байгууллагаар Чанарын баталгаажуулалт хийгдэж, 4 дүгээр сараас эмчилгээнд ашиглаж эхэлсэн. – 2024 оны эхний 10 сарын байдлаар нийт 113 хүнд эмчилгээ хийсэн. Үүнээс 3D CRT-10, VMAT-98, SBRT-5 хүн эмчилгээнд орсон байна. Тухайн технологийг ашиглан өдөрт 25-35 хүн эмчилгээнд орж байна. Үйлдвэрлэгчийн on-site буюу ажлын 	100%

			– Эмчилгээ хийгдсэн хүний тоо	худалдан авалт хийгдсэн.	хурдасгуур нэвтэрсэн байна. – Уг технологийг ашиглан 100-аас доошгүй хүнд эмчилгээ хийсэн байна.	байрны сургалтыг шат дараатайгаар зохион байгуулж, Aria upgrade сургалтыг 2023 оны 5, 8 саруудад, True Beam аппаратын операторын сургалтыг 2024 оны 1 сард, HyperArc сургалтыг 2024 оны 9 сард, RGSC сургалтыг 10 сард хүлээн авч шинэ технологиудыг үе шаттайгаар эмчилгээнд ашиглаж байна.	
4.3.2	БСТ-4.8.1 Элэг, уушигны хавдрын стереотактик туяа эмчилгээ (SBRT) нэвтрүүлнэ.	–	– Батлагдсан эмнэлзүйн заавар – Стереотактик туяа эмчилгээ (SBRT) хийгдсэн хүний тоо	2023 онд шинэ шугаман хурдасгуур суурилуулж, одоогийн Clinac iX шугаман хурдагуурыг OBI-аар тоноглосоноор SBRT хийх тоног төхөөрөмжийн нөхцөл бүрдсэн.	– Элэг, уушги стереотактик туяа эмчилгээний эмнэлзүйн заавар батлагдсан байна. – Элэг, уушигны хавдартай 10 өвчтөн эмчилнэ.	– Стереотактик биеийн туяа эмчилгээний (SBRT) зааврыг боловсруулж, ХСҮТ-ийн эмнэлзүйн хороогоор 2024 оны 2 сарын 22-нд батлуулсан. – 2024 оны 6 сарын 14-21-нд Япон улсын Хиросимагийн их сургуулийн эмч, мэргэжилтнүүд ирж мэс заслын тасгууд болон Туяа эмчилгээний тасагтай хамтарсан сургалт зохион байгуулж, SBRT эмчилгээг хамтран эхлүүлсэн. – Стереотактик эмчилгээний төлөвлөлтийн СТ скан хийх болон эмчилгээний гүйцэтгэлийн дарааллын гарын авлагыг боловсруулсан. – 2024 оны 10 сарын байдлаар элэг, уушгины хавдартай 5 өвчтөнд эмчилгээг амжилттай хийсэн.	100%
4.3.3	4D хэмжээст буюу амьсгалын хөдөлгөөн тооцсон туяа эмчилгээг нэвтрүүлнэ.	ОУАЭ А-ийн төсөл	– Нэвтрүүлсэн шинэ технологи – Шинэ технологи ашиглан эмчилгээнд орсон тоо	ОУАЭА-ийн төслийн хүрээнд мэргэжилтнүүдийг Австрали улсад сургахаар төлөвлөсөн	– 4D буюу эрхтэний хөдөлгөөн тооцсон КТГ скан ба туяа эмчилгээний төлөвлөлтийг нэвтрүүлсэн байна, – Эмчилгээнд 10 хүн орсон байна.	Амьсгалын хөдөлгөөн тооцох RGSC системийг төлөвлөлтийн Somatom 16 КТГ болон True Beam шугаман хурдасгуур аппаратууд дээр суурилуулсан. 2 эмч, 1 физикч инженер 2024 оны 1-р сард Их Британи улсын Ливерпүүл хотод энэ чиглэлээр богино хугацааны сургалтанд хамрагдсан. 2024 оны 10 сарын 16-17-ны хооронд Вариан компаний сургагч багш on-site сургалт хийж 4D буюу эрхтэний хөдөлгөөн тооцсон КТГ скан ба туяа эмчилгээний төлөвлөлт хийж 2 хүний эмчилгээг хамтран эхлүүлсэн. Эхний 10 сарын байдлаар хөхний хавдартай 2 өвчтөн, элэгний хавдартай 1 өвчтөнд эмчилгээ нь эхэлсэн хийгдэж	85%

						байгаа ба хөхний хавдартай өвчтөн 2 өвчтөний төлөвлөлтөнд хийгдэж байна.	
4.3.4	БСТ-4.9.2 Дархлаа, бай болон гормон эмчилгээ хийх заавар шинэчлэн боловсруулж батлуулна.	2.0	– Батлагдсан заавар – Дархлаа, бай эмчилгээ нэвтрүүлэх үндэслэл, судалгаа	Дархлаа эмчилгээний заавар батлагдаагүй байна.	– Дархлаа, бай эмчилгээний эмнэлзүйн заавар Эмнэлзүйн хороогоор батлагдсан байна. – Дархлаа эмчилгээ нэвтрүүлэх үндэслэл, хэрэгцээний судалгаа хийж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	2024 оны хагас жилд хорт хавдрын эсрэг дархлаа, бай болон даавар эмчилгээ хийх эмнэлзүйн зааврыг боловсруулж, ХСҮТ-ийн Эмнэлзүйн хороогоор хэлэлцүүлж батлуулсан. Монгол улсад элэгний анхдагч өмөнтэй өвчтөнд дархлаа эмчилгээ хийх удирдамжийг боловсруулж, эмнэлзүйн хороогоор батлуулсан. 14 өвчтөн дархлаа эмчилгээнд хамрагдсан. Дархлаа эмчилгээ хийх хэрэгцээ, үндэслэл, тооцоог хийж ЭМДЕГ-т илгээсэн. ЭМДЕГ болон хрот хавдрын тусламж үйлчилгээ үзүүлдэг эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарсан хэлэлцүүлэгт оролцож, дархлаа эмчилгээ нэвтрүүлэх үндэслэл, хэрэгцээний судалгааг танилцуулсан.	100%

4.4 Хөнгөвчлөх, дэмжих тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

4.4.1	– Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний зайн болон танхимын сургалт зохион байгуулна.	6.0	– Боловсруулсан сургалтын хөтөлбөр – Зохион байгуулсан сургалтын тоо – Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо – Аймаг, дүүргийн тоо	Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний заавар шинэчлэгдсэн.	– Зохион байгуулсан сургалтын тоо-5 – Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо-100-аас дээш – 10-аас цөөнгүй аймаг, 4 дүүргийн өрх, сумын эрүүл	– “Хавдаргүй хот” сэдэвт ажлын хүрээнд нэг багц цагийн “Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний эрх зүйн бичиг баримт, баримтлах зарчмууд” сургалт зохион байгуулж, 42 эмч хамрагдсан. – “Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний журам, заавар”, “Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний зарчим” сэдвээр Сүхбаатар аймгийн сум өрхийн 20 эмч нарт цахим сургалт хийсэн. – Анхан шатны эрүүл мэндийн эмч, сувилагч, сум, өрхийн эмч нарт зориулсан “Хавдрын үеийн хөнгөвчлөх тусламж үйлчилгээ” сэдэвт сургалтын хөтөлбөр боловсруулж, батлуулсан. – 2024 оны 10-р сарын 05-08-нд “Хоспис болон	100%
-------	---	-----	---	--	--	---	-------------

					<p>мэндийн төвийн эмч, сувилагч нарыг хамруулсан байна.</p>	<ul style="list-style-type: none"> - Хөнгөвчлөхийн дэлхийн өдөр"-ийг тохиолдуулан НЭМГ, МХЭН-тэй хамтран 3 үе шаттайгаар өрхийн эмч нарын дундах мэдлэг, чадварыг тест болон гардан үйлдлийн шалгалт авсан. Уг шалгалтад 149 өрхийн ЭМТ-ийн 151 эмч оролцож, үүнээс 3 эмчийг шилдгээр шалгаруулсан. - “Хавдрын эсрэг үндэсний аян”-ы хүрээнд - Баян-өлгий, Баянхонгор аймагт хөнгөвчлөх эмчилгээний зарчим, өвдөлт намдаах эмчилгээний менежмент сэдэвт сургалт зохион байгуулж, сум, өрхийн 160 эмч, сувилагч хамрагдсан. - ЭМХТ-тэй хамтран “Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний ерөнхий ойлголт”, “Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний бодлогын бичиг баримт”, “Өвдөлт удирдах” зэрэг 3 сэдвээр цахим хичээлийн модуль боловсруулж, видео хичээл бэлтгэж, ЭМХТ-ийн цахим хуудсанд байршуулсан. - Монголын хөнгөвчлөх эмчилгээний нийгэмлэгээс зохион байгуулж байгаа цахим сургалтанд “Хэвлийн асцитын эмчилгээ” “Итгэмжлэгдсэн төлөөлөгч ба амилуулах тусламж үйлчилгээний талаар” гэсэн сэдвээр 2 хичээл тогтмол явуулж байна. 	
4.4.2	Хавдрын үеийн дэмжих тусламж үйлчилгээний чиглэлээр үйлчлүүлэгчдэд зориулсан гарын авлага боловсруулна.	5.0	<ul style="list-style-type: none"> - Боловсруулсан гарын авлага, материал - Хэвлүүлж түгээсэн гарын авлагын тоо 	2023 онд хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, хоол зүйн сэдвээр 8 төрлийн мэдээлэл сурталчилгааны материал боловсруулан	Үйлчлүүлэгчдэд зориулсан 3 төрлийн гарын авлага, сурталчилгааны материал боловсруулж, 500 хувь хэвлэж түгээсэн байна.	Хавдрын дэмжих тусламж үйлчилгээний сэдвээр дараах гарын авлага, санамж, постеруудыг боловсруулан хэвлэж, эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдэд түгээж байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Хавдартай үйлчлүүлэгчдэд зориулан “Нийгмийн халамжийн талаарх мэдээллийн гарын авлага - “Үйлчлүүлэгчийг дэмжих алба” болон Ногоон гэрийн үйл ажиллагааны талаар мэдээллийн брошурыг монгол гэр хэлбэртэй хийж, хэвлэн тасгуудад түгээсэн. 	100%

				хэвлүүлж, түгээсэн.		<ul style="list-style-type: none"> - Эрүүл мэндийн нийгмийн ажилтаны тусламж үйлчилгээний мэдээлэл боловсруулан тасгуудад түгээсэн. - “Хавдартай өвчтөн болон түүний ар гэр, асран халамжлагчдад зориулсан сэтгэл зүйн зөвлөгөө” гарын авлага боловсруулсан. - “Хэрхэн сайн унтаж амрах вэ?” сэдвээр үйлчлүүлэгчдэд зориулсан гарын авлага боловсруулсан. - Хавдрын үеийн хоол эмчилгээний сэдвээр гарын авлага боловсруулан хэсэгчлэн хэвлэн түгээж байна. - Дэмжих тусламж үйлчилгээний сэдвээр нэгдсэн гарын авлагын агуулгыг боловсруулж дууссан. Эх бэлтгэл хийгдэж байна. - Ажилчдад зориулан “Ажлын байранд сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалъя” постер хийж, хэвлүүлэн, төвийн пэйж хуудсанд байршуулсан. - АХБ-аас боловсруулсан гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх сэдвээр харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан брайл үсэгтэй 2 ширхэг гарын авлагыг үйлчлүүлэгчийн номын санд байршуулж хэрэгцээтэй үйлчлүүлэгчид ашиглуулж байна. 	
4.4.3	Хавдрын үеийн хоол зүйн удирдамж боловсруулж, тусламж үйлчилгээнд ашиглана.	5.0	<ul style="list-style-type: none"> - Батлагдсан удирдамж - Удирдамжийн дагуу тусламж үйлчилгээ - үзүүлсэн хүний тоо 	Хоолзүйн удирдамж байхгүй байна.	<ul style="list-style-type: none"> - Боловсруулсан удирдамж-1 - Удирдамжийн дагуу тусламж үйлчилгээ үзүүлсэн хүний тоо-≥500 	<ul style="list-style-type: none"> - Хавдрын үеийн хоол зүйн заавар боловсруулахад шаардлагатай мэдээлэл цуглуулах, ЭМ-ийн сайдын 2023 оны А/440 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэл зүйн хоол эмчилгээний заавар”, ОУ-ын ижил төстэй заавар удирдамжуудыг судлах ажлууд хийгдсэн. - Хоол зүйн зааврын төслийг боловсруулж байна. 	70%
4.4.4	Хавдар бүрийн онцлогт тохирсон эмчилгээний	50.0	<ul style="list-style-type: none"> - Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний хоолны төрөл 	Эмнэлзүйн хоол эмчилгээний зааврын дагуу хоол	<ul style="list-style-type: none"> - Шинээр нэвтрүүлсэн эмчилгээний хоолны төрөл-10-аас доошгүй 	Элэг цөс нойр булчирхайн өвчний үеийн хоолыг 13 нэр төрлөөр нэмэгдүүлсэн. 2-р хоолонд шинээр хачир нэмж олгож байна. Илчлэг нэмэгдүүлсэн хоол- 8, бүтэц өөрчилсөн хоол	100%

	хоол нэвтрүүлнэ.		- Шинэ төрлийн эмчилгээний хоолоор үйлчилсэн эмчлүүлэгчийн тоо	үйлдвэрлэж байна.	- Шинэ төрлийн эмчилгээний хоолоор давхардсан тоогоор - ≥ 6000 хүнд үйлчилсэн байна.	-9, талх боов -10, өглөөний цай -2 нэр төрлөөр тус тус нэмэгдсэн. Шинэ төрлийн хоолоор нийт 6240 хүнд үйлчилсэн.	
4.4.6	БСТ-4.10.2 Мэс заслын өмнө болон дараах сэргээн засах эмчилгээний сургалт зохион байгуулна.		- Сургалтын тоо - Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо	2023 онд ХСҮТ-ийн мэс заслын тасгийн сувилагч нарт 2 удаа сургалт зохион байгуулсан.	- Сургалтын тоо- 2 - Сургалтад аймаг, дүүргийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хаврын эмч, сувилагч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч нийт 100-аас цөөнгүй хүн хамрагдсан байна.	ХСҮТ-ийн Сэргээн засах эмчилгээний тасаг, АШУҮИС-ийн Сувилахуйн сургуультай хамтран “Хавдрын үеийн олон мэргэжилтний сэргээн засах тусламж үйлчилгээ” сэдэвт сургалтыг 2024.03.13-нд зохион байгуулсан. Сургалтад хөнгөвчлөх, мэс засал, хими туяа эмчилгээ хийлгэж буй үйлчлүүлэгчид хавдрын тохиолдол дээр суурилсан олон мэргэжилтэний багийн ажиллагааны талаар гардан үйлдэл, дадлага гэсэн агуулга багтсан. Сургалтанд УНТЭ, УХТЭ, УГТЭ, аймаг, дүүрэг, өрх, хувийн эмнэлгүүдийн сэргээн засах эмч, сувилагч, хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, сэтгэл зүйч, хоол зүйч, нийгмийн ажилтан зэрэг нийт 110 оролцогч хамрагдсан.	100%
4.4.7	“Хорт хавдрын хөнгөвчлөх тусламж үйлчилгээний үеийн сувилахуйн заавар”-ыг		- Батлагдсан заавар - Зааврын дагуу тусламж үйлчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	Хавдрын үеийн төрөлжсөн сувилахуйн тусламжийн заавар боловсруулж байна.	- Батлагдсан заавар-1 - Зааврын дагуу тусламж үйлчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо- 300	ЭМЯ-ны Ажлын хэсэгт ХСҮТ-ийн Сувилахуйн алба, Хөнгөвчлөх эмчилгээний тасгийн эмч, мэргэжилтэнүүд хамтран ажиллаж “Хорт хавдрын хөнгөвчлөх тусламж үйлчилгээний үеийн заавар” боловсруулсан. Тус зааврыг ЭМЯ-ны ажлын хэсгээр 2 удаа хэлэлцүүлж, гарсан санал, зөвлөмжийн дагуу нэмэлт өөрчлөлтийг хийж илгээсэн.	90%

	боловсруулж батлуулна.		– Сургалтад хамрагдсан сувилагчийн тоо		– сургалтад хамрагдсан сувилагчийн тоо-100	Уг зааврыг танилцуулах, хэлэлцүүлэх, санал авах зорилгоор 2 удаагийн сургалт зохион байгуулж, Сүхбаатар аймгийн болон Баянзүрх дүүргийн өрх, сумын эмч нар нийт 150 эмч, мэргэжилтэнүүд оролцлоо.	
ЗОРИЛТ 5: ЦАХИМ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛНЭ							
5.1	Эмгэг судлалын лабораторийн шинжилгээг бүрэн цахимжуулна.	2.0	– E-Health програмд нэмсэн модуль – Програмд шинжилгээний хариу оруулсан хувь	E-Health програмд эмгэг судлалын лабораторийн модуль байхгүй. Шинжилгээний хариуг WORD-ийн файл болгон бэлтгэж хэвлэдэг.	– E-Health програмыг эмгэг судлалын шинжилгээний модулаар өргөтгөж, мэдээний сантай болсон байна.	E-Health програмд эмгэг судлалын лабораторийн модулийг нэвтрүүлэх нэмэлт хөгжүүлэлт хийж, дараах 7 маягыг програмд оруулсан. Үүнд: – Амьд сорьцын шинжилгээний хуудас – Эсийн шинжилгээний хуудас – Бамбай булчирхайн эсийн шинжилгээний хуудас – Шээс ялгаруулах зам, шээсний эсийн шинжилгээний хуудас – Шүлсний булчирхайн эсийн шинжилгээний хуудас – Эмэгтэйчүүдийн эдийн шинжилгээний хуудас – Хөхний булчирхайн эдийн шинжилгээний хуудас – Умайн хүзүүний эсийн шинжилгээний хуудас Эмгэг судлалын шинжилгээ 2024 оны 9-р сарын 25-ны өдрөөс цахимд бүрэн шилжиж эхний 10 сарын байдлаар 3002 шинжилгээний мэдээлэл цахим мэдээний санд орсон байна.	100%
5.2	Цахим аюулгүй байдлын үнэлгээ хийлгэнэ.	–	Цахим аюулгүй байдлын үнэлгээний дүгнэлт тайлан Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн хувь Мэдээллийн аюулгүй байдлын сургалтанд хамруулсан	Үнэлгээ хийлэх хүсэлтээ гаргасан.	– Цахим аюулгүй байдлын үнэлгээ хийлгэж дүгнэлт гаргуулсан байна. – Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн хувь 100% – Мэдээллийн аюулгүй	– Тагнуулын Ерөнхий Газраар цахим аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийлгэсэн. – Өгсөн зөвлөмжийн дагуу төлөвлөгөө гарган ажиллаж байна. Зөвлөмжийг хэрэгжүүлж цахим аюулгүй байдлыг хангахын тулд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг 2025 оны улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр ЭМЯ-нд хүсэлт гаргасан. Уг ажилд шаардлагатай 1,6 тэрбум төгрөгийн төслийн санал хүргүүлсэн.	100%

			мэргэжилтний тоо		байдлын сургалтанд хамруулсан мэргэжилтэний тоо – 1		
5.3	Эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг QR коджуулна.	5,0	– Тоног төхөөрөмжүүдийг QR коджуулсан хувь	Одоо цаасан бүртгэл, мэдээний сантай.	– Тусламж үйлчилгээнд ашиглагдаж буй тоног төхөөрөмжүүдийн 50-аас багагүй хувийг QR кодтой болгосон байна.	Тоног төхөөрөмжүүдийн ашиглалт, аюулгүй ажиллагааны зааварчилгаа болон бусад мэдээллийг шинэчлэн боловсруулах ажил 80%-тай хийгдсэн. Мэдээлэл, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, тусгай зөвшөөрлийг цахим хэлбэрт оруулан QR хэлбэрээр QR коджуулж, QR кодийг хэвлэн нааж эхэлсэн.	90%
5.4	Тоног төхөөрөмжийн бүртгэл, засвар үйлчилгээний програм хангамж ашиглана.	20,0	– Тоног төхөөрөмжийн ашиглалтын програм хангамж – Үүсгэсэн мэдээллийн сангийн тоо – Засвар үйлчилгээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Засвар зйлчилгээний нэгдсэн програм хангамж байхгүй.	– Ашиглалтад орсон тоног төхөөрөмжийн бүртгэл, засвар үйлчилгээний програм-1 – Тоног төхөөрөмжийн мэдээллийн сан-1 – Засвар үйлчилгээний мэдээллийн сан-1 – Засвар үйлчилгээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-80-иас доошгүй хувь	Хэрэгцээний анхан шатны судалгаа хийгдэж, Програмд тавигдах шаардлага багтаамжийг тодорхойлж, үнийн саналыг компаниудаас авсан. Програм хангамж хийх компанийг сонгон шалгаруулах ажил хийгдэж байна.	50%

5.5	БСТ-5.1.2 Төвийн статистик мэдээллийг тогтмол баяжуулж, эмч, ажилтнуудын ашиглах боломжийг нэмэгдүүлж цахим хуудсанд байршуулна.		<ul style="list-style-type: none"> - ХСҮТ-ийн статистик мэдээллийн улирал бүрийн ном - Цахим хуудсанд шинэчлэн оруулсан мэдээлийн тоо 	Улирал бүр статистик үзүүлэлтийн ном нэгтгэж цахиаар холбогдох мэргэжилтнүүдэд түгээж байна.	Төвийн статистик үзүүлэлтийн номыг улирал бүр нэгтгэж, цахим хэлбэрээр байгууллагын дотоод сүлжээнд байршуулна	Төвийн статистик мэдээллийн ном цахим хэлбэрээр улирал бүр гаргаж байна. 2024 онд эхний 3 улиралд цахим мэдээллийг нэгтгэж, байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Статистик мэдээллийн улирал тутмын номыг элэг шилжүүлэн суулгах мэс заслын мэдээлэл, зарим оношилгоо шинжилгээний үзүүлэлтээр баяжуулсан.	100%
-----	--	--	---	--	--	---	-------------



ЗОРИЛТ 6: ХОРТ ХАВДРЫН СУДАЛГАА, ШИНЖИЛГЭЭ, СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТАСРАЛТГҮЙ ХӨГЖҮҮЛНЭ.

6.1 Хорт хавдрын эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх, нотолгоонд суурилсан мэдээ, мэдээллээр хангана.

6.1.1	БСТ-6.1.2 Монголын дурангийн мэс заслын эмч нарын 8-р чуулга уулзалт (MACLES-VIII) зохион байгуулна.		<ul style="list-style-type: none"> - Шинээр танилцуулсан оношилгоо эмчилгээний технологи - Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо 	2023 онд уг чуулга уулзалтын үеэр 2 төрлийн шинэ технологи танилцуулах сургалт хийсэн 150 гаруй эмч, мэргэжилтэн хамрагдсан.	<ul style="list-style-type: none"> - Шинээр танилцуулсан оношилгоо эмчилгээний технологи -2 - Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо-160 	2024 оны 08 сарын 07-08 хооронд Монголын дурангийн мэс засалч эмч нарын 7-р чуулга уулзалт буюу “MACLES-VII” Япон-Монголын Форумыг “Advanced Pancreatic Surgery” сэдвийн дор зохион байгуулсан. Хурлын үеэр Япон улсын Нагоя төв эмнэлгийн захирал, дэлхийн нэрт мэс засалч Prof. Nakaо Akimasa, Prof. Shuji Nomoto уригдан оролцож, нойр булчирхайн хавдрын дурангийн мэс засал хийж, шууд дамжуулалтаар хичээл зааж, илтгэлүүд хэлэлцүүлсэн.	100%
6.1.2	БСТ-6.1.2 Хавдрын сувилахуй судлал эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.	5.0	<ul style="list-style-type: none"> - Хуралд оролцогчийн тоо - Хуралд хэлэлцүүлсэн бүтээлийн тоо 	Хавдар судлалын тулгамдсан асуудал хурлын салбар хуралдаан хэлбэрээр зохион байгуулж, 120	<ul style="list-style-type: none"> - Хуралд оролцогчийн тоо -120-аас цөөнгүй - Хуралд хэлэлцүүлсэн бүтээлийн тоо - 10 	“Хавдрын тулгамдсан асуудал-2024” эрдэм шинжилгээний хурлыг дор Хавдрын сувилахуй судлал сэдэвт эрдмийн бага хурлыг 2024 оны 10-р сарын 25-нд зохион байгуулж нийт 96 сувилагч, тусгай мэргэжилтэн оролцсон. Эрдмийн хуралд нийт аман илтгэл 7, постер илтгэл 3 оролцсон ба тэргүүн байранд Сэргээн засах тасгийн хөдөлгөөн засалч Ц.Цолмонбаяр, дэд байранд Туяа эмчилгээний тасгийн сувилагч	100%

				гаруй сувилагч оролцсон.		С.Болор-Оюун, 3-р байранд Яаралтай тусламжийн тасгийн сувилагч П.Алтанбөмбөг, постер илтгэлд Д.Одбаяр нар тус тус шалгарч,Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнасан.	
6.1.3	БСТ-6.1.2 “Хавдар судлалын тулгамдсан асуудал-2024” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.	40.0	<ul style="list-style-type: none"> - Ерөнхий захирлын тушаал - Оролцогчдын тоо - Салбар хуралдааны тоо - Хэлэлцүүлсэн илтгэлийн тоо - Хэвлүүлсэн сэтгүүл 	“Хавдар судлалын тулгамдсан асуудлууд” үндсэн-салбар (5) хуралдаанаар зохион байгуулж, 400 гаруй эмч мэргэжилтнүүд хамрагдсан байна.	<ul style="list-style-type: none"> - Тушаал-1 - Оролцогчдын тоо-300 - Салбар хуралдааны тоо-5 - Хэлэлцүүлсэн илтгэлийн тоо-50-аас цөөнгүй - Хавдар судлал сэтгүүлийг 300 ширхэг хэвлүүлж түгээсэн байна. 	<p>Хавдар Судлалын тулгамдсан асуудал-2024” эрдэм шинжилгээний хурлыг 2024 оны 9-10 сард үндсэн (1) болон салбар хуралдаан (5)-аар зохион байгууллаа.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Хавдрын эсрэг системийн эмчилгээний менежмент” - “Хөхний хавдрын цогц менежмент” - “Уушги, улаан хоолойн дурангийн мэс заслын өнөөгийн чиг хандлага” - Эмнэл зүйн ховор тохиолдлын хэлэлцүүлэг - Хавдрын сувилахуй судлал <p>Тус хуралд ОХУ, АНУ, Япон, Герман, БНХАУ зэрэг улсын 10 гаруй эрдэмтэн, профессоруд уригдан оролцож, илтгэл тавьж, аймаг, дүүргийн 550 гаруй эмнэлгийн мэргэжилтэн оролцлоо. Хуралдааны үеэр нийт 42 аман илтгэл, 16 ханын илтгэлийг хэлэлцүүлж, шилдэг 13 илтгэл (Аман-9, Ханын-4)-ийг шалгаруулан мөнгөн шагнал олголоо.</p> <p>Шинэ номинаци: “Шилдэг хавдар судлаач эмч”, “Шилдэг хамт олон” номинацийг шинээр бий болгож шалгаруулсан нь өмнөх хурлуудаас онцлог байлаа. Энэхүү номинацид Хөвсгөл аймгийн НЭ-ийн Хавдрын тасгийн эрхлэгч Т.Цэрэнсүрэн, Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн Хавдар, хөнгөвчлөх эмчилгээний тасгийн хамт олон тус тус шалгарлаа.</p> <p>“Хавдар судлал” сэтгүүлийг эмхэтгэн хэвлүүлж, 330 ширхэгийг түгээсэн.</p> <p>Нийтлэгдсэн Эрдэм шинжилгээний бүтээл-39: Судалгаа, шинжилгээ (17), Тохиолдол (10), Сувилахуй (5), Лекц, тойм (5), Шинэ технологи (1), Шинэ номын танилцуулга (1)</p>	100%

6.1.4	БСТ-6.1.1 Эмнэлзүйн туршилт судалгаа (clinic trial) хийх суурийг тавина.	–	Батлагдсан судалгааны арга, аргачлал Судалгааны явцын тайлан	Эмнэлзүйн туршилт судалгаа хийгдээгүй.	Олон төвт эмнэлзүйн туршилт судалгааны арга аргачлал батлагдаж судалгаа эхэлсэн байна. Судалгааны явцын тайланг Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.	Архаг Д гепатитын эмчилгээнд Гепалатид эмийг хэрэглэх олон төвт санамсаргүй түүвэрлэлттэй, давхар нууцлалт, плацебо-хяналт бүхий IIa шатны эмнэлзүйн судалгааны ажлын арга аргачлал батлагдаж, судалгааны ажил амжилттай хэрэгжсэн. Судалгааны ажлын тайланг ХСҮТ-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, Эрүүл мэндийн яамны Анагаах ухааны ёс зүйн хороонд илгээсэн. Энэхүү судалгааны ажлын IIb шатны судалгааны ажлын арга, аргачлалыг тус төвийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцэн баталж, ЭМЯ-ны Анагаахын ёс зүйн хорооноос ёс зүйн зөвшөөрөл авсан. Судалгааны ажил батлагдсан арга, аргачлалын дагуу ХСҮТ-д түгшиглэн хийгдэж байна.	100%
6.1.5	БСТ-6.2.1 Эмч мэргэжилтэнүүдийг магистр, докторын судалгааны ажил хийхэд дэмжлэг үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.	–	– Шинэчлэн боловсруулсан журмын тоо – Сургалтын хөнгөлөлт, дэмжлэгт хөтөлбөрт хамрагдсан эмч, мэргэжилтэний эзлэх хувь	2021 онд Журам батлагдсан. 2023 онд 10 эмч, сувилагч тусгай мэргэжилтэн хөнгөлөлт эдэлсэн.	Сургалтын дэмжлэг үзүүлэх журмыг шинэчлэн боловсруулж Захирлын тушаалаар батлуулсан байна. Хөнгөлөлт, дэмжлэгт тухайн жилд магистр, докторын зэрэг хамгаалсан эмч, мэргэжилтэнийг 100% хамруулсан байна.	Дотоодын их, дээд сургуулийн докторантур, магистрантурын сургалтанд суралцаж байгаа тус төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сурч боловсрох, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх ажил 2022 оноос эхлэн хэрэгжиж байна. ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/18 тушаалаар “Сургалтын дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинэчлэн боловсруулж баталсан. 2024 онд Анагаах ухааны магистрийн зэрэг хамгаалсан ХСҮТ-ийн 3 эмч мэргэжилтэнд журмын дагуу 2’317’280 төгрөгийн тэтгэлгийг олгосон. Мөн магистр, докторын сургалтад суралцаж буй эмч, сувилагч, бусад ажилтнуудад журмын дагуу ажлын цагийн зохицуулалт хийж байна. Сургалтын төлбөрийн 15-30% хүртэл хөнгөлөлт үзүүлэ байна.	100%

6.2 Хавдар судлалын салбарын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлнэ.							
6.2.1	БСТ-6.3.2 Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшил олгох болон мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг хуваарь, хөтөлбөрийн дагуу зохион байгуулна.	50,0	<ul style="list-style-type: none"> - Зохион байгуулсан сургалтын тоо - Батлагдсан сургалтын тойролтын хуваарийн дагуу тойролт хийсэн дадлагажигч эмчийн тоо - Төгсөгчийн тоо - Төгсөлтийн дараах сургалтын хяналт шинжилгээн үнэлгээ (ХШҮ)-ний дүн 	<p>Үндсэн мэргэшил-1, төрөлжсөн мэргэшил-6, мэргэжил дээшлүүлэх сургалт -9 чиглэлээр 108 эмч, эмнэлгийн мэргэжилтэн төгссөн.</p> <p>Тойролтын хуваарийн дагуу 230 гаруй дадлагажигч эмч нар тойролт хийсэн. 2023 оны ХШҮ-95%</p>	<ul style="list-style-type: none"> - Үндсэн мэргэшил-1, төрөлжсөн мэргэшил-6, мэргэжил дээшлүүлэх сургалт -9 чиглэлээр сургалт зохион байгуулсан байна. - Төгсөгчийн тоо-100-аас цөөнгүй - Тойролтын хуваарийн дагуу 100-аас цөөнгүй суралцагч тойрсон байна. - ХШҮ-ний дүн өмнөх оныхоос буураагүй 	<p>Төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулж, нийт 119 эмнэлгийн мэргэжилтнийг мэргэшүүлэн сургалаа. Үүнд:</p> <p>1. Үндсэн мэргэшлээр (9):</p> <ul style="list-style-type: none"> - Хавдар судлал 9 эмч, <p>2.Төрөлжсөн мэргэшлээр (71):</p> <ul style="list-style-type: none"> - Хавдрын хими эмчилгээ судлал -7 эмч, - Толгой хүзүүний мэс засал судлал- 7 эмч, - Эмэгтэйчүүдийн хавдар судлал -7 эмч, - Хавдрын туяа эмчилгээ судлал -2 эмч -  -21 сувилагч, -  судлал -18 сувилагч <p>3.Мэргэжил дээшлүүлэх сургалтаар (48):</p> <ul style="list-style-type: none"> - Хавдрын мэс засал -31 эмч, - Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал- 10 эмч, - Хавдрын хөнгөвчлөх эмчилгээ- 5 эмч, - Умайн хүзүүний эс зүй -2 эмч <p>4. ХСҮТ-ийн гэрээт сургалт эрхлэгч байгууллагуудаас тойролтын хуваарийн дагуу эмнэлзүйн тойролтоор 215 эмнэлгийн мэргэжилтэн 13 чиглэлээр суралцсан.</p>	100%
6.2.2	БСТ-4.9.4 Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн мэргэжилтнүүди	20,0	<ul style="list-style-type: none"> - Байгуулсан гэрээний тоо - Сургалтанд хамрагдсан хүний тоо - Зохион байгуулсан сургалтын тоо - 	<ul style="list-style-type: none"> - Байгуулсан гэрээний тоо- 6 - Сургалтанд хамрагдсан хүний тоо- 39 - Зохион байгуулсан сургалтын тоо-2 	<ul style="list-style-type: none"> - Байгуулсан гэрээний тоо- 9 - Сургалтанд хамрагдсан хүний тоо- 68 Зохион байгуулсан сургалтын тоо- 4 - 	<p>- ХСҮТ-ийн Эмэгтэйчүүдийн мэс заслын эмч нарын баг 2024 онд Хөвсгөл АНЭ, Сүхбаатар АНЭ, Архангай АНЭ, Увс аймгийн НЭ, Өмнөговь БОЭТ-ийн эх барихмэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын эмч нарт “ Эмэгтэйчүүдийн хавдрын мэс засал” сэдэвт ажлын байрны 4 багц цагийн сургалт зохион байгуулж нийт 100 эмч мэргэжилтнийг хамруулсан.</p> <p>Ажиллан суралцах хөтөлбөрийн хүрээнд</p>	100%

	<p>йг “Ажиллан сурах” хөтөлбөрийн дагуу дагалдуулан сургах, чадавхижуулна.</p>					<ul style="list-style-type: none"> – ХСҮТ-ийн эмч мэргэжилтнүүдээс 2024 онд Хавдар судлал үндсэн мэргэшлийн сургалтанд 4 эмч элсэн суралцаж байгаагийн 2 нь Төрийн сангийн зардлаар элсэн суралцаж байна. – Төрөлжсөн мэргэшлийн сургалтанд хавдрын туяа эмчилгээ судлал төрөлжсөн мэргэшлээр 2 эмч, толгой хүзүүний мэс засал мэргэшлээр 1 эмч, хавдрын хими эмчилгээ судлалаар 2 эмч, – хавдрын мэс заслын мэргэжил дээшлүүлэх ходоод нарийн гэдэсний хавдрын мэс заслаар 2 эмч, хөхний хавдрын мэс заслаар 2 эмч сургалтыг 1 эмч, нойр булчирхайн хавдрын мэс заслаар 1 эмч, эмэгтэйчүүдийн хавдрын мэс заслын мэргэжил дээшлүүлэх сургалтанд 4 эмч нийт 19 эмчийн суралцсаны сургалтын төлбөрийн хөнгөлөлтийг 17 эмчид үзүүлсэн байна. Мөн хавдрын сувилахуй судлалаар 8 сувилагч, хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй судлалаар 3 сувилагч амжилттай суралцаж төгссөн. – 2024 онд Орон нутагт хими эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх холбогдуулан “Хавдрын хими эмчилгээний найруулга зүй” мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулан ЭМХТ-өөр батлуулан баталгаажуулж намрын элсэлтээр нийт 6 элсэгчдийг бүртгэн сургалтыг эхлүүлэн зохион байгуулан ажиллаж байна. – Шинээр “ Хавдрын ангиографи судсан дотуурхи оношилгоо эмчилгээ судлал” 5 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан ЭМХТ-өөр батлуулан 2024 оны намрын элсэлтээр нийт хөдөө орон нутгийн 8 эмчийн хамруулан сургаж сургалтыг зохион байгуулж байна. – Төгсөлтийн дараах “ Хавдрын хими эмчилгээ судлал” төрөлжсөн мэргэшлийн сургалтанд 	
--	--	--	--	--	--	---	--

						<p>Дундговь АНЭ, Дорноговь АНЭ, Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлэг, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, УНТЭ-ийн эмч нар нийт 7 эмч амжилттай суралцаж төгссөн ба цаашид хими эмчилгээг орон нутагт өргөжүүлэхээр төлөвлөж байна.</p> <p>– Багц цагийн 9 удаагийн сургалтын хөтөлбөрийг батлуулж сургалтыг төлбөргүй зохион байгуулж төвийн нийт эмч, сувилагч бусад мэргэжилтнүүд нийт 1076 эмч мэргэжилтнүүдийн хамруулсан байна.</p>	
6.2.3	БСТ-6.3.2 Төгсөлтийн дараах туяа эмчилгээ, хими эмчилгээ судлал, эмэгтэйчүүдийн мэс засал судлал төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулна.	5,0	<ul style="list-style-type: none"> – Шинэчлэн боловсруулсан хөтөлбөрийн тоо-5 – Батлуулсан сургалтын хөтөлбөрийн тоо -1 	2014-2016 онд төрөлжсөн мэргэшлийн хөтөлбөрүүд боловсруулж батлуулсан.	2024 онд Хавдрын хими эмчилгээ судлал, хавдрын туяа эмчилгээ судлал, эмэгтэйчүүдийн хавдар судлал төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг өөрчилж шинэчлэн боловсруулж ЭМЯ-ны ЭМХЗ-өөр хэлэлцүүлэн батлуулсан байна. Шинээр хөхний хавдрын мэс засал, хавдрын ангиографийн мэргэжил	<p>2024 онд дараах сургалтын хөтөлбөрүүдийг шинэчлэн боловсруулсан. Үүнд:</p> <p>1. Төрөлжсөн мэргэшлийн сургалтын хөтөлбөр (3):</p> <ul style="list-style-type: none"> – Хавдрын хими эмчилгээ судлал – Хавдрын туяа эмчилгээ судлал – Эмэгтэйчүүдийн хавдар судлал <p>– Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, ЭМЯ-ны Хавдар судлал мэргэжлийн салбар зөвлөлөөр батлуулан, ЭМХТ-д илгээсэн. ЭМЯ-ны Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлөөр батлуулахаар хүлээгдэж байна.</p> <p>2. Хавдрын мэс заслын мэргэжил дээшлүүлэх 8 хөтөлбөрийн агуулга, багтаамжийг нэмэгдүүлэн, төрөлжсөн мэргэшлийн 4 хөтөлбөр болгон боловсруулж, мэргэжлийн индекс шинээр авахаар ЭМХТ, ЭМЯ-руу холбогдох материалын хамт хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> – Ходоод, гэдэсний хавдрын мэс засал – Элэг цөс, нойр булчирхайн хавдрын мэс засал – Уушги, голтын хавдрын мэс засал – Хөхний хавдрын мэс засал <p>3. Шинээр эрх авсан сургалтын хөтөлбөр (2):</p> <ul style="list-style-type: none"> – Хавдрын ангиографи судсан дотуурх оношилгоо эмчилгээ 	95%

					дээшлүүлэх сургалтын хөтөлбөрийг ЭМХТ-өөр хэлэлцүүлж батлуулсан байна.	- Хавдрын химийн эмийн найруулга зүйн сургалт	
6.2.4	БСТ-4.9.4 Орон нутгийн хавдрын эмч, сувилагч нарт хими эмчилгээний ажлын байрны сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгнө.	3.0	<ul style="list-style-type: none"> - Ажлын байрны сургалт хийсэн аймгийн тоо - Аймагт хийсэн хими эмчилгээний эмчийн үлэгийн тоо - Сэлгэн ажилласан эмчийн тоо- 	2023 онд 4 аймагт ажлын байрны сургалт зохион байгуулж, 4 эмч сэлгэн ажиллаж 80 хүнд хими эмчилгээний үзлэгхийж зөвлөгөө өгч ажилласан.	<ul style="list-style-type: none"> - Ажлын байрны сургалтыг 2-3 аймагт зохион байгуулсан байна. - Аймагт хийсэн хими эмчилгээний эмчийн үлэгийн тоо- ≥50 - Сэлгэн ажилласан эмчийн тоо-3 	Мэргэшүүлэх, дадлагажуулах сургалт: “Хавдрын хими эмчилгээ судлал” төрөлжсөн мэргэшлийн сургалтанд Дундговь АНЭ, Дорноговь АНЭ, Баянгол дүүргийн нэгдсэн эмнэлэг, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, УНТЭ-ийн эмч нар нийт 7 эмч амжилттай суралцаж төгссөн ЦЭЭЖНИЙ ҮЗЛЭГХИЙЖ хүртээмжийг нэмэгдүүлэх салбарын бологыг хэрэгжүүлэх хүрээнд 2024 оны намрын элсэлтээр 7 эмч, эм зүйч аймаг, дүүргийн ЭМТ-өөс элсэн суралцаж байна. Ажлын байрны сэлгэн ажиллуулах, ажлын байрны дагалдан сургалт хийх хүрээнд Орхон, Хэнтий, Өвөрхангай, Өмнөговь аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ-ийн хавдрын тасагт тус төвийн Хими эмчилгээний эмч нарын баг ажиллаж, ажлын байрны сургалт зохион байгуулж, хамтарсан зөвлөгөөн хийж, эмчилгээ, оношилгоо, хяналтын зөвлөгөө өгч, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. Телемедицинээр зайн сургалтыг хуваарийн дагуу хийж байна. Архангай, Дорноговь аймгийн эмч хавдрын хими эмчилгээ, хөнгөвчлөх эмчилгээний талаар 6 удаагийн сургалт зөвлөгөөн хийсэн.	100%
6.2.5	Цээжний хөндийн хавдрын дүрс оношилгоо,	2.0	- Батлагдсан сургалтын хөтөлбөр	Цээжний хөндийн хавдрын дүрслэл	Батлагдсан сургалтын хөтөлбөр-1	2024 оны 5-р сард Цээжний хөндийн хавдрын дүрс оношилгоо, эмчилгээний чиглэлээр олон улсын эрдэм шинжилгээний хурал, 1 багц цагийн сургалт	100%

	эмчилгээний чиглэлээр сургалт зохион байгуулна.		- Сургалтад хамрагдсан эмч нарын тоо	оношилгоо чиглэлээр сургалт зохион байгуулж байгаагүй	Сургалтад 50-иас цөөнгүй эмч хамрагдсан байна.	зохион байгуулж, 300 орчим эмч, мэргэжилтнүүд хамрагдсан.	
6.2.6	<u>БСТ-6.4.1</u> Оношилгоо, эмчилгээнд шинээр нэвтэрч арга, технологид эмч, мэргэжилтэнүүдийг гадаад оронд сургана.	40.0	Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо	2023 онд 81 эмч, мэргэжилтэн гадаадын өндөр хөгжилтэй оронд уурт, богино хугацааны сургалтад хамрагдсан.	50-аас цөөнгүй эмч, мэргэжилтэнийг гадаадын өндөр хөгжилтэй оронд урт, богино хугацааны сургалтад хамруулсан байна.	2024 онд нейронкологи, стереотактик туяа эмчилгээ, цагаан мөгөөрсөн хоолойн хавдрын мэс засал, онкоурологи болон хөхний хорт хавдрын нөхөн сэргээх мэс заслын чиглэлээр нийт 30 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаад улсад урт, богино хугацааны цахим болон танхимын сургалтанд хамруулаад байна. 2024 онд тус төвийн 88 эмч мэргэжилтэн гадаадын өндөр хөгжилтэй орнуудад урт, богино хугацааны сургалт, семинар, туршлага судлах сургалтанд хамрагдсан байна. Гадаадад урт хугацаатай суралцаж буй 6 эмч, ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн.	100%

ЗОРИЛТ 7: ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ТӨСВИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЗАРЦУУЛАЛТАД ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТ ХИЙНЭ.

7.1	<u>БСТ-7.1.1</u> Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд хяналт хийнэ	-	- Аудитын тайлан	Жил бүр тайлагнаж байна	Аудитийн тайланг тухай бүр холбогдох байгууллага, албан тушаалтан хүргүүлсэн байна	Төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашигтай байдалд Дотоод аудитор нь хяналт, шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн жил бүр санхүүгийн тайланд хөндлөнгийн гадаад аудитыг хэрэгжүүлэн зөрчилгүй ажиллаж байна.	100%
-----	--	---	------------------	-------------------------	--	--	-------------

7.2	БСТ-7.1.2 Санхүү, төсөв, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлагналын үйл ажиллагааны үнэн зөв, найдвартай байдалд хяналт хийнэ	-	- Аудитын тайлан	Улирал бүр тайлагнаж байна.	Тайланг тухай бүрт нь холбогдох байгууллаг, алабан тушаалтанд хүргүүлсэн байна.	Санхүү, төсөв, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлагналын үйл ажиллагааны үнэн зөв, найдвартай байдалд Дотоод аудитор нь хяналт, шалгалтыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн жил бүр санхүүгийн тайланд хөндлөнгийн гадаад аудитыг хэрэгжүүлэн зөрчилгүй ажиллаж байна.	100%
-----	---	---	------------------	-----------------------------	---	--	-------------

ЗОРИЛТ 8:АЖИЛЛАГСАДЫН АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА.

8.1	БСТ-8.1.1 Нийгмийн хамгааллын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлнэ.	-	- Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь - Ажилагсадын сэтгэл ханамжийн хувь	Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 90 хувьтай хэрэгжүүлсэн.	Төлөвлөсөн арга хэмжээг $\leq 90\%$ хэрэгжүүлсэн байна. - Сэтгэл ханамжийн хувь $\leq 90\%$ болсон байна.	Хавдар судлалын үндэсний төвд ажиллагсдын нийгмийн баталгааны түвшин, цалин хөлсийг нэмэгдүүлэх, урамшууллын системийг төвийн хэмжээнд нэгдсэн байдлаар нэвтрүүлэх, мэргэжлээс шалтгаалсан өвчин, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах явцад ажилтны эрүүл мэнд, амь насыг хамгаалах нөхцлийг бүрдүүлэх, мэргэжлийн эрсдлээс хамгаалах зорилгоор Төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэн ажиллаж байна. Нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийг 100 хувьтай хэрэгжүүлэн ажиллаж байна. Төвийн эмч, ажилтнуудаас сэтгэл ханамжийн судалгааг 2024 оны эхний хагас жилд 1 удаа авсан ба судалгаанд нийтдээ 160 ажиллагсад хамрагдсан.	100%
-----	---	---	--	--	--	--	-------------

						Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Хоёрдугаар хавсралтаар хавсралтаар хавсаргав.	
8.2	БСТ-8.1.2 Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.	-	- Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь - Өвчний улмаас чөлөө авсан ажилтны хувь	2023 онд эрүүл мэндийг дэмжих чиглэлээр 7-н ажил зохион байгуулсан	- Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь-≤90% байна. - Өвчний улмаас чөлөө авсан ажилтны тоо өмнөх оноос буурсан байна.	Хавдар судлалын үндэсний төвийн ажилтнуудыг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулж, эрүүл мэндийн түвшинг тогтоон, өвчлөлийг эрт оношилж, өвчлөл хүндрэлээс урьдчилан сэргийлэх, ажилтнуудын бие бялдрыг чийрэгжүүлэх зорилго бүхий “Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөр”-ийг 2021-2023 онд батлан хэрэгжүүлэн ажилласан. 2024 онд уг хөтөлбөрт нэмэлт өөрчлөлт оруулан “ХСҮТ-ийн ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөр” (2024-2026 он), төлөвлөгөө”-г батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг Гуравдугаар хавсралтаар хавсаргав.	100%
8.4	Багш-шавийн (Mentorship) хөтөлбөр хэрэгжүүлнэ.	-	- Хөтөлбөрт хамрагдсан эмч, мэргэжилтэний тоо	Шинэ сувилагчийн хөтөлбөр хэрэгжиж байна. Багш-шавийн хөтөлбөр байхгүй.	- Хөтөлбөрт шинээр ажилд орсон эмч, сувилагч нарыг бүрэн хамруулсан байна.	Багш-шавийн (Mentorship) хөтөлбөр хэрэгжүүлж ажиллаж байна. Сувилахуйн алба нь шинэ сувилагчийн хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлдэг ба үүнд 5 хоног, 3 сар, нэг жилийн хөтөлбөрүүд багтана. 2024 оны 11-р сарын 22-нд тухайн жилд шинээр ажилд орсон шинэ сувилагч, тусгай мэргэжилтэн нарын өдөрлөгийг зохион байгуулсан. Нийт 150 орчим эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ЭМЯ-ны харьяа эмнэлгийн зочид оролцлоо. 2024 онд шинээр ажилд орсон нийт сувилагч 24, тусгай мэргэжилтэн 8 байгаа ба нийт 32 сувилагч, тусгай мэргэжилтэн нарт тус бүрд нь багш томилон багш шавийн хөтөлбөр хэрэгжүүлэх бэлтгэл хангасан. ЭМЯ-наас 2024 онд батлагдсан Багш шавийн хөтөлбөрийг мөрдөж ажиллана. Мөн 9-р сарын 18-нд АШУҮИС-ийн Сувилахуйн сургуультай хамтран Багш-шавийн уулзалт зохион	90%

						явуулсан ба нийт 120 сувилагчид хамрагдаж, сургуулийн зочин багш нарын лекц уншлаа.	
8.5	БСТ-8.2.2 Чадамжийн шалгуурыг үндэслэн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг үнэлнэ.	-	- Чадамжийн үнэлгээг шинэчлэн тогтоохоор хүсэлт гаргасан эмч мэргэжилтэн үүдийн үнэлгээнд хамруулсан хувь	Чадамжинй шалгуур үзүүлэлтийг боловсруулан эмч мэргэжилтнийг 100% үнэлсэн.	- Чадамжийн үнэлгээг ахиулахаар хүсэлт гаргасан эмч, мэргэжилтнү үдийг чадамжийн үнэлгээнд 100% хамруулж үнэлгээг шинэчлэн тогтоосон байна.	ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны А/32 дугаар тушаалаар батлагдсан “Цогц чадамжид суурилсан үнэлгээ хийх журам”-ын дагуу ерөнхий чадамж болон тухайн мэргэжлийн онцлог байдлыг харгалзсан гардан үйлдлийн шалгуур гэсэн үзүүлэлтээр үнэлсэн. Нийт 120 их эмч, 150 сувилагч, 11 эм зүйч, 6 физикч инженерийн үнэлгээг баталгаажуулсан байна. ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/32 дугаар тушаалаар “Цогц чадамжид суурилсан үнэлгээ хийх журам”-ыг шинээр боловсруулан баталж, 2023 оны 04 дүгээр сарын 01-нээс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг тушаалаар их эмч, сувилагч, эм зүйч, физикч инженер гэсэн 4 албан тушаалын ажилтнуудын чадамжийн үнэлгээг ерөнхий болон мэргэжлийн гэсэн 2 бүлэг шалгуураар үнэлэхээр тусгасан. Ерөнхий чадамжийн шалгуур, мэргэжлийн шалгуур нь тухайн ажлын байрны онцлогоос шалтгаалан харилцан адилгүй байхаар тусгасан. 2024 онд шинээр ажилд орсон (36 их эмч, сувилагч, эм зүйч) болон урт хугацааны чөлөөнөөс ажилдаа орсон (20 эмч, сувилагч, физикч инженер) ажилтнуудын чадамжийн үнэлгээг хийж чадамжийг тодорхойлон ажилласан.	100%
8.6	Төвийн ажилтнуудад гамшигийн төлөвлөгөөний дагуу гамшиг, эрсдэлээс сэргийлэх	-	- Зохион байгуулсан сургалтын тоо - Сургалтад хамрагдсан	Жил бүр газар хөдлөлт, гал түймрээс сэргийлэх сургалтыг зохион байгуулдаг.	Газар хөдлөлт, гал түймэр, үер усны гамшиг, биотеррорист халдлагаас сэргийлэх, цацрагийн	ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын үндэсний хүрээлэнтэй хамтарч “Улсын аюулгүй байдалд эрүүл мэндийн нөлөөлөл” сэдэвт 2 цагийн сургалтыг 2024.06.07-ны өдөр зохион байгуулж, 300 гаруй ажилтан, албан хаагчид оролцсон. Сургалтад нийт ажиллагсадын 60% хамрагдсан.	100%

	сургалтууд зохион байгуулна.		ажиллагсадын хувь		аюулгүй байдлын сургалтыг тус бүр 1-2 удаа зохион байгуулсан байна. Сургалтад нийт ажиллагсадыг 60%-иас доошгүй хамруулсан байна.		
8.7	Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.	10.0	- Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь - Ёс зүйн зөрчлийн тоо	Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүйн салбар хорооны төлөвлөгөөг жил бүр батлан хэрэгжүүлдэг.	Төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байна.	Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор 21 ажил төлөвлөснөөс бүрэн хэрэгжүүлэн ажиллаж 100% гүйцэтгэлтэй байна. Төлөвлөгөөт болон зарлаж нийтдээ 6-н хурлыг зохион байгуулан хуралдаж холбогдох шийдвэрүүдийг гаргаж ажилласан. Ёс зүйн сорил нийт ажилчдаас авч, дүн шинжилгээ хийж, зөвлөмжөөр хангасан. 4 тасгийн хооронд нөхөрсөг уулзалт 2 удаа зохион байгуулж, ажил мэргэжлийн онцлог, хамтын ажиллагааны үйл ажиллагааг сайжруулсан. Эмч, ажилтнуудад ёс зүйн чиглэлээр соён гэгээрүүлэн, мэдээллээр хангах зорилгоор 6-н сургалтыг зохион байгуулсан. Эмнэлгийн мэргэжилтэний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Дөрөвдүгээр хавсралтаар хавсаргав.	100%
8.8	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх, соён	3.0	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Авилгаас сэргийлэх хөтөлбөрийг жил	Төлөвлөсөн арга хэмжээг бүрэн	АТГ-аас байршуулсан санал хүсэлтийн хайрцагт ирсэн санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна.	100%

	гэгээрүүлэх ажлыг төлөвлөн хэрэгжүүлнэ.			бүр батлан хэрэгжүүлдэг.	хэрэгжүүлсэн байна.	<p>1. 2024 оны 04 дүгээр сарын байдлаар нийт 29-н гомдол, санал ирсэн. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Талархал – 4 - Төвийн эмч, ажилтнуудтай холбоотой гомдол – санал – 14 - Бусад гомдол – 12 ирсэн. <p>2. 2024 оны 11-р сарын байдлаар нийт 38-н гомдол, санал ирсэн. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Төвийн ажилтнуудтай холбоотой 38 ирсэн байна. Эдгээр гомдол, санал гаргасан иргэдээс эргэж хариу өгөх хаяг, утасны дугаараа бичээгүй байсан. Гомдол, саналтай холбоотой зохих арга хэмжээг авч шийдвэрлэн ажиллаж байна. - 2024 оны 01-р сард Эрүүгийн цагдаагийн газраас тус төвийн захиргааны зөвлөлийн гишүүдэд “Эрүүл мэндийн салбарт үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цаашид анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгуулсан. - 2024 оны 02-р сард: АТГ-ын Шударга ёс-хөгжил дэвшилд 110 гомдол мэдээлэл хүлээн авах утасны дугаар бүхий зурагт хуудсыг мэдээллийн самбарт байршуулсан. - 2024 оны 04-р сард: АТГ-аас гаргасан Авлигын эсрэг хуулийн зүйл заалт бүхий 2 зурагт хуудсыг цахим бүртгэлийн хэсгийн мэдээллийн самбарт, захиргааны хэсгийн мэдээллийн самбаруудад байршуулсан. - 2024 оны 11-р сард АТГ-ын комиссар Балдандорж төвийн сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд “Авлигын эсрэг үйл ажиллагаа”-ны талаар мэдээлэл, сургалт хийсэн. - 2024 оны III улирлын байдлаар нийт -277 гомдол, санал, хүсэлт, өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлээд байна. Үүнээс: 	
--	---	--	--	--------------------------	---------------------	---	--

						<ul style="list-style-type: none"> - Санал – 30 - Гомдол – 222 - Өргөдөл – 25 <p>“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 1-т заасны дагуу иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, гаргах эрхийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор санамж, зурагт хуудас, талархлыг самбар, санал хүсэлтийн хайрцгийг амбулаторийн хүлээлгийн танхим, эмчилгээний тасгууд болон төвийн цахим хуудсанд байрлуулан мөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны утасны дугаар, цахим хаяг, өрөөний дугаар бүхий нэрийн хуудсыг сувилагчийн пост, хүлээлгийн заал, хүлээн авах зэрэг үйлчлүүлэгч олноор үйлчлүүлдэг газруудад байрлуулан ажиллаж байна.</p> <p>Авилагын эсрэг төлөвлөгөөний хэрэгжилтийг Тавдугаар хавсралтаар хавсаргав.</p>	
--	--	--	--	--	--	---	--

ЗОРИЛТ 9: ЭМНЭЛГИЙН САНХҮҮГИЙН БИЕ ДААСАН БАЙДЛЫГ ХАНГАЖ, САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОНО

9.1	БСТ-9.1.1 Улирал, хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн баланс гаргаж, байгууллагын санхүүгийн удирдлагыг үр ашигтай хэрэгжүүлнэ.	-	Санхүүгийн баланс гаргасан байна.	Улирал, хагас жил, жилийн эцэст мэдээлсэн байна.	Балансийг бүрэн гаргасан байна.	Санхүү, төсөв, анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүүгийн тайлагналыг улирал хагас жил болон жилийн эцсийн санхүүгийн баланс гаргаж байгууллагын удирдлагад мэдээллийг цаг тухай бүрт хүргэж байна. Мөн жил бүр санхүүгийн тайланд хөндлөнгийн гадаад аудитыг хэрэгжүүлэн зөрчилгүй ажиллаж байна.	100%
-----	--	---	-----------------------------------	--	---------------------------------	--	-------------

9.2	БСТ-9.1.2 Шилэн дансанд мэдээлэл байршуулна.	-	Шилэн дансанд мэдээллийг оруулсан байна.	Сар бүр тайлагнаж жилд нийт 12 удаа мэдээллийг оруулсан байна.	Мэдээллийг 100% оруулсан байна.	Шилэн дансны цахим хуудсанд 2024 оны 10 сарын байдлаар 16 төрлийн 86 мэдээлэл байршуулсан. Шилэн данс, байгууллагын ил тод байдлын мэдээллийг хугацаанд нь тайлагнаж ажилласан.	100%
-----	--	---	--	--	---------------------------------	---	-------------

Зорилт 1: Хорт хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлгийн ажлыг эрчимжүүлж, сургалт сурталчилгаа, ухуулга нөлөөллийн арга хэмжээ хэрэгжүүлнэ. 3 арга хэмжээ- 100%

Зорилт 2: Хорт хавдрын бүртгэлийн чадавхийг сайжруулна. 1 арга хэмжээ- 100%

Зорилт 3: Хорт хавдрын лавлагаа тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна. 8 арга хэмжээ- 92.8%

Зорилт 4: Хорт хавдрын оношилгоо, эмчилгээний чанар хүртээмжийг сайжруулна. 23 арга хэмжээ- 86.7%

Зорилт 5: Цахим эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлнэ. 5 арга хэмжээ- 88%

Зорилт 6: Хорт хавдрын судалгаа, шинжилгээ, сургалтын үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлнэ. 11 арга хэмжээ- 99.5%

Зорилт 7: Хөрөнгө оруулалт, төсвийн санхүүжилтийн зарцуулалтад хяналт, үнэлгээ, дотоод аудит хийнэ. 2 арга хэмжээ- 100%

Зорилт 8: Ажиллагсадын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангана. 7 арга хэмжээ- 98.7%

Зорилт 9: Эмнэлгийн санхүүгийн бие даасан байдлыг хангаж, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно. 2 арга хэмжээ- 100%

НИЙТ 62 АРГА ХЭМЖЭЭ, ХЭРЭГЖИЛТИЙН ХУВЬ 92.8%

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЭРДЭНЭХҮҮ

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ



Ц.УРАНЧИМЭГ

ЭМНЭЛЗҮЙ ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ



С.ХҮРЭЛСҮХ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД, СУРГАЛТЫН АЛБАНЫ ДАРГА



Ц.БАДАМСҮРЭН

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН



А.ЦЭНД-ӨЛЗИЙ



ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЙЛАН 2024

Хянасан:

Ц.Уранчимэг, ХСҮТ-ийн Үйл
ажиллагаа эрхэлсэн дэд захирал

Бэлтгэсэн:

Л.Энхээ, ХСҮТ-ийн Үйлчлүүлэгчийг
дэмжих албаны дарга

2024 оны 12 дугаар сарын 5

АГУУЛГА

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТ	3
1.1 ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ	3
1.1.1. ЕБС-ийн багш, эмч нарт зориулсан сургалт	3
1.1.2. ЕБС-ийн сурагчдад зориулсан сургалт	4
1.1.3. Эмзэг бүлгийн иргэдэд зориулсан сургалт	4
1.1.4. Сэтгүүлчдэд зориулсан сургалт	4
1.1.5. Уран бүтээлчдэд зориулсан сургалт	5
1.2 ТӨВИЙН АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ	5
1.2.1. Зорилтот бүлгийн сургалтууд	5
1.2.2. Ажилчдад зориулсан лекц	6
1.2.3. Жендэрийн сургалт	7
1.2.4. Цэргийн бэлтгэл үүрэгтний анхан шатны сургалт	7
1.2.5. Ажлын байрны стресс бууруулах сургалт	7
ХОЁР. ХАВДРЫН ДАВАН ТУУЛАГЧДЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР	8
2.1. Хөгжим эмчилгээний хөтөлбөр	8
2.2. Даван туулагчдад зориулсан дэмжих бүлгийн сургалт	10
2.2.1. Хоол зүй, сэтгэл зүйн дэмжих бүлгийн сургалт, уулзалт	10
2.2.2. Нийгмийн дэмжлэгийн сургалт, уулзалт	10
• “Гараар урлахуй” сургалт	10
• Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид дэмжлэг сургалт, уулзалт	11
• Асран халамжлагчдад урам өгөх арга хэмжээ	11
• Хавдрын даван туулахуйн сэдвээрх мэдээлэл сурталчилгаа	11
• Хавдрын даван туулагчдын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх	12
ГУРАВ. КАМПАНИТ СУРГАЛТ АЖИЛ	12
3.1. ХАВДРЫН ЭСРЭГ АНХААРАЛ ХАНДУУЛАХ ДЭЛХИЙН ӨДӨР	12
3.3. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ	14
3.4. ДЭЛХИЙН ТАМХИГҮЙ ӨДӨР-5/31	16
3.5. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДЭЛХИЙН ӨДӨР-9/17	17
3.6. ВИРУСТ ГЕПАТИТТЭЙ ТЭМЦЭХ ДЭЛХИЙН ӨДӨР- 7/28	19
3.7. ХӨХНИЙ ХАВДРЫН МЭДЭЭЛЛИЙН САР-Х САР	19
ДӨРӨВ. МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАХ	23
4.1. Гарын авлага, товхимол, санамж, постер	23
4.2. Видео контент	24
ТАВ. ТЕЛЕВИЗ, РАДИО, СОНИН, НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА	28
• ХСҮТ-ийн нүүр ном	28
• Хэвлэл мэдээлэл	28

2024 онд үндэсний хэмжээнд хорт хавдраас урьдчилан сэргийлэх бодлого, арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажлын хүрээнд ЭМЯ ахалсан дараах ажлын хэсгүүдэд хамтран ажиллалаа. Үүнд:

- Хорт хавдраас сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөр боловсруулах ажлын хүн амын дунд хорт хавдрын **анхдагч урьдчилан сэргийлэлтийн** арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах НЭМҮТ-ээр ахлуулсан ажлын хэсэг
- “Эрүүл монгол хүн” хөтөлбөрийн хүрээнд зонхилон тохиолдох 7-н төрлийн хорт хавдрын анхдагч урьдчилан сэргийлэлтийн сэдвээр үндэсний хэмжээнд түгээх мэдээлэл сурталчилгааны видео контентуудын агуулга боловсруулах ЭМЯ, НЭМҮТ-ийн хамтарсан ажлын хэсэг
- ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтын сэдвээр сургалт, мэдээлэл сурталчилгаа ажлуудыг зохион байгуулах ЭМЯ, НЭМҮТ, ХӨСҮТ, НҮБХС хамтарсан ажлын хэсэг

2024 онд ХСҮТ-ийн мэдээлэл сурталчилгааны ажлын төлөвлөгөөний гүйцэтгэл 91% биелж, олон нийтэд зориулсан сургалт, мэдээлэл сурталчилгааны чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ЭРҮҮЛ МЭНДИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТ

1.1 ОЛОН НИЙТЭД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

2024 онд тус албанаас олон нийтэд эрүүл мэндийн боловсрол олгох, хавдрын эрсдэлт хүчин зүйлс, тамхины хор хөнөөл, зонхилон тохиолдох хавдруудын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, ХПВ-ийн халдвараас сэргийлэх дархлаажуулалт ба хорт хавдар, хавдрыг даван туулах зэрэг сэдвүүдээр талаар нийслэлийн ЕБС-иудад 8, төрийн бус байгууллагуудад 4, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нарт 1 нийт 13 удаагийн сургалтыг зохион байгуулжээ. Эдгээр сургалтуудад ЕБС-иудын захирал, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, 5-6-р ангиудын анги даасан багш, тухайн ангиудад эрүүл мэндийн хичээл заадаг багш, сэтгэл зүйчид, 7-р ангийн сурагчид, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч нар, урлагийн байгууллагын уран бүтээлчид, хэвлэл мэдээллийн ажилтнууд, эмзэг бүлгийн иргэд зэрэг олон нийтийн төлөөллүүдээс 3500 гаруй хүнийг хамруулсан байна.

1.1.1. ЕБС-ийн багш, эмч нарт зориулсан сургалт

ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалт орон даяар хэрэгжиж эхэлж байгаатай холбоотойгоор ХПВ ба хорт хавдар, ХПВ-ийн эсрэг дархлаажуулалт, бэлгийн бойжилт ба шилжилтийн насныхан, тэдэнтэй харилцах арга зүйн сэдвээр 7-н удаагийн танхимын ба зайн сургалтыг НЭМҮТ, ХӨСҮТ, Нийслэлийн Боловсролын Газартай хамтран хийлээ. Сургалтад нийслэлийн 9-н дүүргийн төрийн өмчит ба хувийн ЕБС-иудын захирал, сургуулийн эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, 5-6-р ангиудын анги удирдсан багш, тухайн ангиудад эрүүл мэндийн хичээл заадаг багш нар болон өрхийн эмч, вакцинатор сувилагч зэрэг 3000 гаруй хүнийг хамруулсан байна.

1.1.2. ЕБС-ийн сурагчдад зориулсан сургалт

Нийслэлийн 84-р сургуулийн 7-р ангийн 60 сурагч, 97-р сургуулийн 8-р ангийн 50 сурагч нийт 110 сурагчид 2 удаагийн сургалтыг “Тамхи, электрон тамхины хор хөнөөл” сэдвээр ХСҮТ дээр зохион байгуулсан.

1.1.3. Эмзэг бүлгийн иргэдэд зориулсан сургалт

Тайванийн гэр бүлийг хөгжлийг дэмжих сантай хамтран эмзэг бүлгийн өрхийн нийт 100 иргэнд хавдрын эрсдэлт хүчин зүйлс, хорт хавдраас урьдчилан сэргийлэх аргууд болон эрт илрүүлгийн ач холбогдлын талаар 2 удаагийн тус бүр 1 цагийн сургалтыг зохион байгуулж мэдээлэл өглөө.



1.1.4. Сэтгүүлчдэд зориулсан сургалт

Хавдрын эсрэг Дэлхийн өдөрт зориулан Монголын эрүүл мэндийн сэтгүүлчдийн Цагаан үзэг холбоо ТББ-тай хамтран “Хавдаргүй ирээдүйн төлөө БҮГДЭЭРЭЭ эрх мэдэл, манлайллаа нэгтгэцгээе” сэдэвт сургалтыг зохион байгуулж хэвлэл мэдээллийн 20 гаруй байгууллагын 40 сэтгүүлчийг оролцууллаа.



Сургалтад оролцогчдод хорт хавдраас сэргийлэх, хянах талаарх төрийн бодлого, авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, өвчлөлийн үзүүлэлт, урьдчилан сэргийлэлт, тусламж үйлчилгээний өнөөгийн чиг хандлага, тулгамдаж буй асуудлуудын талаар олон эх сурвалжаас мэдээлэл өгч, сэтгүүлчдийн асуултад хариулан, харилцан ярилцлаа. Сургалтад ХСҮТ-ийн ерөнхий захирал Н.Эрдэнэхүү, ХСҮТ-ийн үйл ажиллагаа эрхэлсэн захирал Ц.Уранчимэг, ХСҮТ-ийн ХХБТЭИА-ы дарга Т.Ундармаа, НЭМТСА-ны дарга Ц.Бадамсүрэн, ҮДА-ны дарга Л.Энхээ, НЭМҮТ-ийн захирал С.Өнөрсайхан, НЭМҮТ-ийн Эрүүл мэндийг дэмжих мэдээллийн албаны дарга С.Гэрэлмаа, ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албаны дарга О.Дашпагма, Хавдрын үндэсний зөвлөл ТББ-ын тэргүүн Б.Цэцэгсайхан, “Цагаан үзэг” сэтгүүлчдийн



холбооны гүйцэтгэх захирал Б.Ундрах болон сэтгүүлчид оролцсон юм. Жил бүрийн хавдрын эсрэг анхаарал хандуулах Дэлхийн энэ өдөр сэтгүүлчдэд зориулан сургалт зохион байгуулах нь хэвлэл мэдээллээр иргэд, олон нийтэд хавдрын асуудлаар үнэн зөв мэдээлэл түгээх, хавдраас урьдчилан сэргийлэх арга замууд, эрт илрүүлгийн ач холбогдлыг сурталчлан таниулах, хавдрын тулгамдсан асуудлуудыг хөндөж олон нийтийн анхааралд аваачих олон төрлийн мэдээ, мэдээллүүд бэлтгэгдэн түгээгдэж, иргэдийн мэдэх эрхийг хангахад чухал нөлөө үзүүлдэг ач холбогдолтой билээ.



1.1.5. Уран бүтээлчдэд зориулсан сургалт

Даван туулагчдыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлдэг “Хөгжим эмчилгээ” хөтөлбөрт дэмжин оролцсон, хамтран ажилладаг урлагийн байгууллагын ажилтнуудад хавдрын эрсдэлт хүчин зүйлс, шалтгаан, урьдчилан сэргийлэх арга замууд, эрт илрүүлгийн ач холбогдлын сэдвээр сургалтыг Улаанбаатар театрын байранд 2 удаа зохион байгуулсан. Уг сургалтад Улаанбаатар чуулгын 100 гаруй ажилтан, Монголын хэл хуурын холбооны 200 гаруй угсаатны өв соёл тээгч уран бүтээлчид хамрагдлаа.

1.2 ТӨВИЙН АЖИЛЧДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ

2024 онд төвийн ажилчдын хувь хүний хөгжлийг дэмжих хүрээнд 22 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 600 гаруй ажилчдыг хамруулсан байна.

1.2.1. Зорилтот бүлгийн сургалтууд

- Төвийн сувилагч нар болон аймаг, дүүргээс суралцагч сувилагч нарт “Олон нийтэд сургалт, мэдээлэл сурталчилгаа хийх арга зүй” сэдвээр 2 удаагийн сургалтыг хийж 40 хүнийг хамруулсан.
- Ажилтан бүр хөтөч” сургалтыг 4-н удаа хийж, лаборатори, инженер техникийн ажилтан, цахим бүртгэгч, цэвэрлэгээ үйлчилгээний ажилтан 60 хүнийг хамруулсан.
- “Харилцаа ба багаар ажиллах” сургалтыг 1 удаа зохион байгуулж эм зүйн албаны 12 ажилтныг хамруулсан.
- “Байгууллагын соёл” шинэ ажилтны сургалтыг 4-н удаа хийж 51 ажилтанг хамруулсан.
- "Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих сар"-ын хүрээнд ХСҮТ-ийн ҮДА, ХНХА-аас хамтран "Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд" сургалтыг төвийн эрэгтэй ажилчдын дунд зохион байгуулсан. Сургалтад НЭМҮТ-ийн ЭМДМА-ны дарга С.Гэрэлмаа "Бүх төрлийн тамхин бүтээгдэхүүний хор хөнөөл, тамхинаас хамааралтай өвчлөлөөс урьдчилан сэргийлэх нь", ХСҮТ-ийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн эмч М.Мөнхжаргал "Эрэгтэй ажилчдын эрүүл мэндийн байдал-урьдчилан сэргийлэх үзлэгийн үр дүн", ХСҮТ-ийн ЦХМЗ-ын тасгийн эрхлэгч Ц.Ганзориг "Тамхи ба

уушигны хорт хавдар" сэдвээр тус тус танилцуулга мэдээлэл хийсэн. Сургалтад эмч, сувилагч, техникч, инженер, засварчин зэрэг 30 гаруй эрэгтэй ажилчин оролцсон бөгөөд сургалтын төгсгөлд ажлын байранд эрүүл мэндийг дэмжих, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр шаардлагатай ажлуудын талаар мэдээлэл солилцлоо.

1.2.2. Ажилчдад зориулсан лекц

- Ажилтнуудын харилцаа, хандлагыг сайжруулах, ёс зүй, ёс суртахууны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор 2 удаагийн лекцийг зохион байгууллаа.

АШУҮИС-ийн профессор, МУ-ын хүний гавъяат эмч Р.Сээсрэгдорж багшийн “Монголын уламжлалт анагаах ухаан дах эмчийн ёс зүй” сэдэвт сургалтад төвийн 300 гаруй эмч, сувилагч хамрагдлаа. Монголын анагаах ухаанд эртнээсээ эмч хүн өвчтнийг ойлгох, харилцах, эмчлэх ухааны үндэс болсон ёс зүй, ёс суртахууны мөн чанарын талаар тайлбарлан танилцуулсан нь сургалтад оролцогчдод маш сонирхолтой бөгөөд чухал хэрэгцээтэй сэдэв байсныг онцлон дурдаж байлаа.

Түүнчлэн Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр батлагдсантай холбогдуулан төвийн нийт ажилчдад сурталчлан танилцуулах зорилгоор “Төрийн албан хаагчийн ёс зүй” сургалтыг зохион байгуулж, Монгол улсын ёс зүйн хорооны гишүүн, АШУҮИС-ийн багш профессор М.Цэрэнбат багшийг урин лекц уншуулсан нь сонирхолтой бас, үр дүнтэй сургалт болж чадлаа. Уг сургалтад тус төвийн 400 гаруй ажилтан хамрагдсан бөгөөд төрийн албан хаагчийн ажил, амьдралын онцлог, хүнд хэцүү боловч нэр төртэй энэ салбарт сайн соёлыг дэлгэрүүлэхэд хувь хүний ёс суртахуун, биеэ авч явах соёл, ажил амьдралын тэнцвэрт байдлаа хадгалах нь хэр чухал нөлөөтэй болохыг хөндсөн, хамт олныг идэвхижүүлсэн үр дүнтэй сургалт болсон билээ.



1.2.3. Жендэрийн сургалт

“Жендэрт суурилсан хүчирхийллийн эсрэг-16 хоногийн аян”-ны хүрээнд Хүйсийн тэгш эрхийн төв ТББ-ын захирал, жендэрийн шинжээч Г.Ганбаясгах сургагчийг урьж “Жендэр, жендэрийн эрх тэгш байдал, жендэрт суурилсан хүчирхийлэл” сургалтыг нийт ажилчдын дунд зохион байгуулсан.



1.2.4. Цэргийн бэлтгэл үүрэгтний анхан шатны сургалт

Зэвсэгт хүчний жанжин штабтай хамтран цэргийн бэлтгэл үүрэгтний анхан шатны чадавхижуулах сургалтыг зохион байгууллаа.



Сургалт 2024 оны 1-р сарын 26-27-ны өдрүүдэд энхийг сахиулагчдын сургалтын төв буюу Төв аймгийн Алтанбулагт Зэвсэгт хүчний 311-р ангид зохион байгуулагдаж ХСҮТ-ийн 34 эмч, ажилчин сургалтад хамрагдлаа. Мөн ХСҮТ-ийн ажилтнууд 311-р ангийн цэргийн алба хаагчдад хорт хавдраас сэргийлэх сургалтыг хийлээ. Цэргийн бэлтгэл үүрэгтний анхан шатны

сургалт нь оролцогчдыг цэвэр агаарт гаргасан төдийгүй хувь хүний хурд, хүч, цэц мэргэн, тэсвэр тэвчээрийг сорьсон, идэвхижүүлсэн, сонирхолтой, үр өгөөжтэй арга хэмжээ болсон.

1.2.5. Ажлын байрны стресс бууруулах сургалт

Ажлын байран дах стрессийг бууруулах, ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хүрээнд 7 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 200 гаруй ажилтанг хамрууллаа. Үүнд:

- “Харилцан яриа ба багийн ажиллагаа”, “Гэмтлийн дараах өсөлт” сэдвээрх 2 удаагийн сургалтад БМАБА-ны 32 ажилтан
- “Миний стресс” сургалтад МТА-ны 3-н ажилтан“



- “Тэсвэр хатуужил уу? эсвэл урам зориг уу?” сэдэвт сургалтад “Эрүүл жин-эрүүл бие” хөтөлбөрт оролцож буй 30 ажилтан
- “Гэмтлийн дараах өсөлт”, “Сэтгэцийн эрүүл мэндээ хэрхэн хамгаалах вэ?” мэдээллийг эмч, сувилагч нарын яриан дээр
- “Амьдралын зам” ART therapy сургалтад 27 ажилтан



ХОЁР. ХАВДРЫН ДАВАН ТУУЛАГЧДЫГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Хавдрын даван туулагчдад дэмжих хөтөлбөрийн хүрээнд 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлуудын биелэлт 80 %-тай хэрэгжлээ.

2.1. Хөгжим эмчилгээний хөтөлбөр

ХСҮТ 2021 оны 12-р сард үйлчлүүлэгчийн хүлээлгийн танхимдаа төгөлдөр хуур бүхий орчинтой болсноор, 2022 оны 3-р сарын 1-ээс хойш өнөөг хүртэл хэрэгжиж буй “Хөгжим эмчилгээ” хөтөлбөр маань үйлчлүүлэгчид, эмчлүүлэгчид, хавдрын даван туулагчдад танигдсан ажлуудын нэг болсон юм. Долоо хоног бүрийн Лхагва гаригийн 11.00-12.00 цагт болдог хөгжим эмчилгээний хөтөлбөр 3 дах жилдээ амжилттай хэрэгжлээ.



2024 онд энэхүү хөтөлбөрийг СУИС-ийн Хөгжмийн урлагийн сургууль, МУ-ын Консерватори, БХИС-ийн Хөгжмийн коллеж, ЦДБЭТ, Адожи сургалтын төв, ДБЭТ, Улаанбаатар театр, Монгол угсаатан-хэл хуурын холбоо, төгөлдөр хуурын сургалтын төв, соло уран бүтээлчид, даван туулагчид зэрэг 10 гаруй байгууллага, хувь хүмүүс дэмжин 200 гаруй хөгжимчид, уран бүтээлчид оролцож 33 удаагийн



хөгжим эмчилгээг зохион байгуулж, дунджаар 1700 гаруй хүнд хүргэсэн байна.

ХСҮТ-ийн зүгээс хөгжим эмчилгээний хөтөлбөрийг дэмжин оролцсон уран бүтээлчдэд ХСҮТ-ийн ерөнхий захирлын “Талархал”-ийг гардуулж, тоглолтыг лайваар дамжуулах, төвийн пэйж хуудсанд мэдээлэл оруулан нийтэд түгээх зэргээр уран бүтээлчдээ урамшуулан дэмждэг юм.



2.2. Даван туулагчдад зориулсан дэмжих бүлгийн сургалт

ХСҮТ-ийн ҮДА-ны нийгмийн ажилтан, хоол зүйч, сэтгэл зүйч нар төвийн үйлчлүүлэгч болон, хэвтэн эмчлүүлэгч, хяналтын өвчтнүүдэд зориулан хавдрын эмчилгээ, хэвтэх үеийн болон гарсны дараах үеийн хооллолт, нийгмийн халамж тэтгэмж, сэтгэл зүйн тааггүй байдлаа даван туулах сэдвүүдээр сургалтуудыг тогтмол зохион байгууллаа.



2.2.1. Хоол зүй, сэтгэл зүйн дэмжих бүлгийн сургалт, уулзалт

Тус албаны хоол зүйч Даваа, Лхагва, Баасан гаригуудад “Хоол боловсруулах эрхтний хорт хавдар ба хавдрын мэс заслын дараах хооллолт”, “Элэг цэс нойр булчирхайн хорт хавдар, мэс заслын дараах хооллолт”, “Хими туяа эмчилгээний үеийн хооллолт” сургалтуудыг тогтмол хийж 200 гаруй эмчлүүлэгч, асран халамжлагчдыг оролцуулсан байна.



Үйлчлүүлэгчийн сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах сэдвээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулж эмчлүүлэгч, сахиур зэрэг 20 хүн харагджээ.



2.2.2. Нийгмийн дэмжлэгийн сургалт, уулзалт

• “Гараар урлахуй” сургалт

Чимэглэлийн сургалтын төвийн багш нартай хамтран долоо хоног бүрийн Баасан гаригт хэвтэн эмчлүүлэгч болон сахиур, даван туулагч нарт зориулан “Гараар урлахуй” сургалтыг зохион байгууллаа.

Нийт 27 удаа хийгдсэн сургалтад нийтдээ 170 хүн хамрагдаж эсгий, шүр, гипс урлал, лаа, саван, декор хийх арга зүйд суралцлаа. Сургалтад хамрагдсан даван туулагчдаас цаашид сурсан зүйлээ хөгжүүлэн, жижиг бизнэс эхлүүлж байна.



- **Хөгжлийн бэрхшээлтэй үйлчлүүлэгчид дэмжлэг сургалт, уулзалт**

Харааны бэрхшээлтэй эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдэд хүний эрх хүчирхийллийн талаар мэдээлэл хүргэх зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооноос хэвлүүлсэн, брайль хэвлэлтэй хосолсон гарын авлага номтой болж үйл ажиллагаандаа ашиглаж байна.



Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Тэгш тусгал ТББ-тай хамтран хавдрын улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдэд зориулан шинэ нөхцөлд дасан зохицоход нь туслах дэмжих бүлгийн сургалтууд хийх, эмнэлгийн орчны ээлтэй байдалд үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах хүрээнд хамтран ажиллахаар төлөвлөлөө.



- **Асран халамжлагчдад урам өгөх арга хэмжээ**

Хавдрын даван туулагчдын санаачлага болон үс, гоо сайхны бизнес эрхлэгч дэмжигч нартай хамтран хүнд өвчтний сахиурт дэмжлэг үзүүлэн баярлуулах үйл ажиллагааг 2 удаа зохион байгуулсан. Хөнгөвчлөх эмчилгээний тасгийн эмч нартай ярилцан, орон нутгаас ирж эмчлүүлж буй эмчлүүлэгчдийн сахиураас эрэгтэй, эмэгтэй тус бүр нэг хүнийг сонгон, тэднийг биеийн алжаал ядаргаа тайлах, саун, иллэг, үс засалт, гоо сайхны үйлчилгээнд хамруулан, өдрийн хоолонд урих үйл ажиллагааг зохион байгуулж хүнд өвчтний асран халамжлагчдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүллээ.



- **Хавдрын даван туулахуйн сэдвээрх мэдээлэл сурталчилгаа**

Химийн бай эмчилгээний эмүүдийн чанар, хүртээмжийг сайжруулахад хавдартай эмчлүүлэгчдийн оролцоог нэмэгдүүлэх, дуу хоолойг хүргэх, байр сууриа илэрхийлэх боломжийг дэмжин ажиллаж ирлээ.



Хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ач холбогдол, тусламж үйлчилгээнд учирч буй хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга замуудын талаар МҮОНТ, ТВ-5, С-1, Боловсрол



ТВ, Ийгл ТВ, Itoim.mn, Ikon.mn, mass.mn сайтын ярилцлага, хэлэлцүүлэг зэрэг 10 гаруй удаагийн нэвтрүүлэгт хавдрын даван туулагчдыг оролцуулсан.

Хөхний хавдрын сард зориулан “Өөрийгөө ойлго, өөрийгөө өөрчил” даван туулагчдад зориулсан уулзалт, өдөрлөгийг зохион байгуулж 200 гаруй эмчлүүлэгч, үйлчлүүлэгчийг хамруулсан. Хавдрыг даван

туулах сэдвээр уулчин-даван туулагч М.Батхишигтэй лайв ярилцлага хийсэн.

- **Хавдрын даван туулагчдын хөтөлбөрт дэмжлэг үзүүлэх**

Улаанбаатар эмпати олон улсын хөтөлбөртэй ЕБС-ийн 6-9-р ангийн сурагчид өөрсдийн хийсэн гар урлал, хүнсний бүтээгдэхүүнээр “Science fair” үзэсгэлэн худалдааг сургууль дээрээ зохион байгуулж олсон орлогоосоо ХСҮТ-ийн үйл ажиллагаанд зориулан 2 дах жилдээ хандивлалаа. Сурагчид сайн үйлсийн энэхүү үйл ажиллагааг зохион байгуулахад технологийн багш нар дэмжин туслажээ. Тус сургуулийн 11В ангийн сурагч Б.Хулан зурсан зургаа борлуулан эмнэлэгт хандивладаг түүхээс санаа авсан энэхүү сайн дурын үйл ажиллагаагаараа хүүхдүүд хавдаргүй ирээдүйн төлөөх үйлст хүмүүнлэгийн үнэтэй хувь нэмэр оруулж байна.



ГУРАВ. КАМПАНИТ АЖИЛ

2024 онд 6-н удаагийн олон нийтэд зориулсан кампанит ажил зохион байгууллаа.

3.1. ХАВДРЫН ЭСРЭГ АНХААРАЛ ХАНДУУЛАХ ДЭЛХИЙН ӨДӨР

Жил бүрийн 2 дугаар 4-ны өдрийг дэлхийн нийтэд хорт хавдрын эсрэг дуу хоолойгоо нэгтгэх, олон нийтийн анхаарлыг хандуулах, үнэн, бодитой мэдээлэл түгээх, хорт хавдраас сэргийлэх, эрт илрүүлэгт хамрагдахын ач холбогдлыг сурталчлан ойлгуулах зорилгоор “Хавдрын эсрэг Дэлхийн өдөр” хэмээн тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Энэ жил уг өдрийг “Хавдаргүй ирээдүйн төлөө БҮГДЭЭРЭЭ эрх мэдэл, манлайллаа нэгтгэцгээе” уриан дор тэмдэглэлээ.

ХСҮТ-ийн Үйлчлүүлэгчийг дэмжих алба, Монголын эрүүл мэндийн сэтгүүлчдийн Цагаан үзэг холбоо хамтран хорт хавдар түүний эмчилгээ, оношилгооны өнөөгийн чиг

хандлага, баримталж буй бодлого, хэрэгжүүлж буй арга хэмжээ, тулгамдаж буй асуудлуудын талаар олон нийтэд үнэн зөв, бодит мэдээллийг түгээх зорилгоор 20 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын 40 орчим сэтгүүлч, зураглаач оролцсон сургалт зохион байгуулсан. *Дэлгэрэнгүйг 4-р нүүрний 1.1.4 хэсгээс үзнэ үү.*

Хавдрын эсрэг Дэлхийн өдрийн хүрээнд ХСҮТ-ийн эмч нарыг оролцуулсан “Хавдрын эрсдэлт хүчин зүйлс”, анима хэлбэрээр “Хавдрын эрт илрүүлэг” сэдэвт 2 төрлийн 60 секундийн видео шторк хийж, МҮОНТ, UBS, TV-5, ТВ-8, ТВ-9, Малчин ТВ, Eagle TV болон төвийн пэйж хуудсаар түгээн олон нийтэд хүргэлээ.

НЭМҮТ-тэй хамтран ЕБС-ийн сурагчдын дунд хавдрын эрсдэлт хүчин зүйлийн сэдвээр “Эрүүл дадал-эрүүл амьдрал” рийлийн уралдаан зарлаж шалгарууллаа.

Умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэг, ХПХВ-ийн эсрэг дархлаажуулалтын сэдвээр ТВ хэлэлцүүлгийг МҮОНТ-тэй хамтран НЭМҮТ, ХӨСҮТ, Хавдрын үндэсний зөвлөл ТББ, даван туулагчдын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.



Мөн уг өдөрт зориулан ДЭМБ-аас гаргасан зөвлөмжийн дагуу НЭМҮТ-тэй хамтран 8-н төрлийн постерыг бэлтгэж төвийн пэйж хуудас, олон нийтийн сүлжээгээр түгээж, ухуулга нөлөөлөлд ашиглалаа.



3.3. НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ ЖИЛ

Эрүүл мэндийн яамнаас 2024 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Сүхбаатарын төв талбайд иргэд, олон нийтэд зориулсан эрүүл мэндийн өдөрлөгт ХСҮТ-ийн багийг зохион байгуулан оролцлоо.



ЭМЯ болон Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс хамтран зохион байгуулсан тус өдөрлөгийн нээлтэнд Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, ДЭМБ-ын суурин төлөөлөгч Др.Сокорро Эскаланте, ЭМЯ-ны төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбат, Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд болон албаны бусад хүмүүс оролцсон юм.



“Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” уриатай энэхүү өдөрлөгт ХСҮТ-ийн эмнэл зүй эрхэлсэн дэд захирал С.Хүрэлсүх, ҮДА-ний нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, хоол зүйч, даван туулагч-сайн дурын идэвхитнүүд, НЭМТСА, ХХБТЭИА, СА-дын эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцож, цусны даралт, биеийн жингийн индекс хэмжих, хорт хавдраас урьдчилан сэргийлэх зөвлөмж, мэдээллийг иргэдэд өгөх, санамж, танилцуулгыг тараалаа.



Иргэдэд эрүүл зөв хоололт, идэвхитэй дасгал хөдөлгөөн, зөв ойлголт мэдээллийг түгээх, хандлагыг өөрчлөх замаар хүн амд эрүүл амьдралын хэв маяг, дадал хэвшлийг сурталчлан таниулах зорилготой тус өдөрлөгийн үеэр нийтийн гимнастик, ахмадын дасгал хөдөлгөөн, урлаг спортын арга хэмжээнүүд зохион байгуулагдсан.

3.4. ДЭЛХИЙН ТАМХИГҮЙ ӨДӨР-5/31

Жил бүрийн 5-р сарын 31-ийг дэлхий нийтээр "Тамхигүй өдөр" болгон тэмдэглэдэг бөгөөд энэ жилийг "Тамхи үйлдвэрлэлийн хөндлөнгийн оролцооноос хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалцгаая" уриан дор тэмдэглэж байна.

Дэлхий нийтээр Тамхины эсрэг "Худлаа ярихаа зогсоо" аяныг өрнүүлж байна.

5-р сарын 31-нд ЭМЯ, НЭМҮТ, СЭМҮТ, ДЭМБ-аас хамтран Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулсан Тамхины эсрэг олон нийтэд зориулсан өдөрлөгт ХСҮТ-ийн оролцоог ҮДА-аас зохион байгуулж, НЭМСТА, ЦХМЗТ, СА, МТА, ХХСА-тай хамтран оролцлоо.

Өдөрлөгийн нээлтэд ЭМЯ-ны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, НЭМҮТ-ийн ерөнхий захирал С.Өнөрсайхан, ДЭМБ-ын ХБӨ хариуцсан мэргэжилтан Б.Болормаа, Улсын 3-р төв эмнэлгийн ерөнхий захирал

Ц.Төмөр-Очир, ХСҮТ-ийн ҮА эрхэлсэн дэд захирал Ц.Уранчимэг нар үг хэлж Тамхины эсрэг нэгдэхийг олон нийтэд уриаллаа.

ХСҮТ-ийнхөн өдөрлөгийн үеэр тамхины хор хөнөөл, хорт хавдраас сэргийлэх талаах эмч, сувилагч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар зөвлөгөө мэдээлэл өгч, санамж зөвлөгөө тараахын зэрэгцээ иргэдэд даралт хэмжих үйлчилгээг хүргэлээ.

Мөн ХСҮТ-ийн эмч, сувилагч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, МТА-ын инженерүүд, резидент эмч нарын баг тамхины эсрэг уриалга бүхий флэшмоб хийж иргэдийг идэвхижүүллээ.





3.5. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ДЭЛХИЙН ӨДӨР-9/17

Жил бүрийн 9 дүгээр сарын 17 бол "ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ӨДӨР" юм. ДЭМБ-аас энэ жил уг өдрийг тусламж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангахад үйлчлүүлэгчийг цаг алдалгүй, зөв оношлох нь нэн чухал болохыг онцолж, **“ЗӨВ АЮУЛГҮЙ ОНОШИЛГОО”** уриан дор тэмдэглэж буй уг өдрийн хүрээнд ХСҮТ-ийн Үйлчлүүлэгчийг дэмжих албанаас үйлчлүүлэгчдэд зориулсан өдөрлөг зохион байгууллаа.



Өдөрлөг ХСҮТ-ийн хүлээлгийн 3 танхимд зэрэг явагдсан бөгөөд Сувилахуй алба, Дүрс оношилгооны тасаг, Туяа эмчилгээний тасаг, Эм зүйн алба, Халдвар хяналт сэргийлэлтийн алба, Амбулаторийн тасаг, Эмчилгээний хоол шим тэжээлийн тасаг, Мэдээлэл технологийн алба, ЭМТҮЧАБА-д дэмжин оролцсон.



Өдөрлөгийн хүрээнд: Үйлчлүүлэгчид артерийн даралтыг хэмжих, биеийн жингийн индексийг тодорхойлох, оношилгооны түгээмэл хэрэглэгдэх шинжилгээнүүдэд биеэ бэлтгэх, зөв оношилгоо, эмийг зохистой хэрэглээний талаарх мэдээллийг түгээлээ.



Мөн хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, үзлэг оношилгоо, гараа зөв угаах, халдваргүйжүүлэх аргачлал, хавдрыг даван туулах, сэтгэл зүй, хоол зүйн зөвлөгөө мэдээллүүдийг өгсөн.

Өдөрлөгийн үеэр үйлчлүүлэгчдэд эмчилгээний хоол шим тэжээлийн тасаг ханиад томууны улиралд үйлчлүүлэгчдэд жимсний халуун шүүсийг түгээж дархлааг нь дэмжлээ.



3.6. ВИРУСТ ГЕПАТИТТЭЙ ТЭМЦЭХ ДЭЛХИЙН ӨДӨР- 7/28

7 дугаар сарын 28-ны өдрийг “Вируст гепатиттай тэмцэх дэлхийн өдөр” болгон тэмдэглэхээр шийдвэрлэснээс хойш 22 дахь удаагаа энэ өдрийг тэмдэглэн өнгөрүүлж байна. ХСҮТ-ийн ҮДА, ХХСА, Хими эмчилгээний тасаг, ЭЦНБМЗЭШСТ хамтран “Гепатиттай тэмцэх дэлхийн өдөр”-ийн хүрээнд 2024.08.02-ний өдөр үйлчлүүлэгчдэд зориулсан өдөрлөг зохион байгууллаа.



Өдөрлөгөөр үйлчлүүлэгчдэд гепатит В болон С вирусийн тухай ойлголт, халдвар дамжих зам, урьдчилан сэргийлэлт, гепатит В вирусийн эсрэг дархлаажуулалт, элэгний архаг үрэвсэл, элэгний хатуурал, гепатит С вирусийн эсрэг эм, вирусийн халдвар илрүүлэх шинжилгээ, элэгний хорт хавдар, элэгний хяналтын талаар мэдээлэл зөвлөгөө өгсөн.



Мөн халдвар хамгааллын дэглэм баримтлан гепатит В, С вирус илрүүлэх түргэвчилсэн оношилгоог 50 хүнд хийж, зөвлөгөө өгөв. Сэдвийн дагуу 5-н төрлийн зурагт хуудас, зөвлөмж материал боловсруулж, 200 ширхэгийг түгээв.

3.7. ХӨХНИЙ ХАВДРЫН МЭДЭЭЛЛИЙН САР-Х САР

Дэлхий нийтэд 2023 онд 55,720 хөхний хорт хавдрын шинэ тохиолдол оношлогдож, 500 000 гаруй эмэгтэй энэ шалтгаанаар нас баржээ. Монгол улсад 2023 онд хөхний хорт хавдрын 344 шинэ өвчлөл оношлогдсны 0.5-1 хувь нь эрэгтэйчүүдэд тохиолдсон байна.



Жил бүрийн 10 дугаар сарыг дэлхий нийтээр хөхний хорт хавдраас сэргийлэх мэдээ мэдээллийг түгээх, хавдрыг даван туулагчдад итгэл найдвар, урам зориг өгөх, дуу хоолойгоо нэгтгэх сар болгон тэмдэглэдэг. Энэ хүрээнд ХСҮТ-ийн Үйлчлүүлэгчийг дэмжих албанаас эмчлүүлэгчид, асран халамжлагчдад үйлчлүүлэгчдэд зориулан “ӨӨРИЙГӨӨ ОЙЛГО, ӨӨРИЙГӨӨ ЧӨЛӨӨЛ” сэдэвт хавдрыг даван туулагчдад зориулсан дэмжих бүлгийн уулзалтыг зохион байгууллаа. ХСҮТ-д хэвтэн эмчлүүлэгч, сахиур, хяналтын өвчтөн, эмч ажилтнууд зэрэг 100 гаруй хүн оролцсон дэмжих бүлгийн уулзалтад хөхний хавдрыг даван туулж буй Б.Батхишиг, О.Хулан нарыг уригдан оролцож өөрсдийн түүх, туршлагаасаа хуваалцсан юм.



Хавдрын даван туулагч Б.Батхишиг нь Монгол улсын зөвлөх инженер бөгөөд хорт хавдартай гэдгээ мэдээгүй, өвдчихсэн үедээ 2023 оны 05 дугаар сарын 18-нд дэлхийн хамгийн өндөр 4-дэх оргил болох Гималайн нурууны **дтд.8516м Лхоце оргилд,**

оношлогдсныхоо дараа хавдрын мэс засал, хими, туяа эмчилгээний олон курсуудыг дуусгаад, биеийн тэнхээ тамир сул үедээ ч идэвхитэй хөдөлгөөнийг эрхэмлэн, өөрийн бэлтгэл дасгалаа үргэлжлүүлэн хийсээр **2024 онд** дэлхийн 8 дах ноён оргил болох **дтд.8163м Манаслу** оргилд амжилттай оргилджээ.



Хавдрын даван туулагч О.Хулан нь Европын 10 орон 20 гаруй хотоор 2 сар, Монгол орноороороо 1 сар үүргэвчтэй аялсан соло аялагч, контент бүтээгч, хувиараа бизнес эрхлэгч билээ. Японд нөхөр, хүүхдийн хамт амьдардаг О.Хулан хавдраар өвдснөөс хойш өөрийн өвчний талаар маш их уншиж, судалж, хийлгэж эмчилгээнүүдийнхээ үр нөлөөний талаар тэмдэглэл хөтлөн, эмч нараас зөвлөгөө авч, аливаад бодитоор хандах, хоббигоо хөгжүүлэх нь өөрийгөө ялан дийлэхэд их дэм болсон тухай сонирхолтой түүхээ хуваалцсан юм.



Зочин илтгэгчдийн хавдрыг даван туулж буй өөрсдийн түүх, туршлага, хөгжилтэй хэрнээ ухаарал бүхий чин сэтгэлийн яриа нь уулзалтад оролцогчдод итгэл найдвар, урам зориг өгсөн, халуун дулаахан уулзалт боллоо.





Уулзалтад ХСҮТ-ийн Ерөнхий захирал Н.Эрдэнэхүү, ХСҮТ-ийн Эмчилгээ эрхэлсэн орлогч захирал С.Хүрэлсүх болон тасаг, албадын дарга, эрхлэгч нар оролцсон бөгөөд ерөнхий захирал Н.Эрдэнэхүү нээж хэлсэн үгэндээ *“Цаашдаа өөрийгөө хайрлаж, хүссэн зүйлээ хийж өвдөхгүй аз жаргалтай амьдраарай”* гэж хэлсэн юм.

Мөн ХСҮТ-ийн хөхний төвийн эмч У.Минжин хөхний тусламж үйлчилгээний талаар мэдээлэл өгч танилцуулав.



Уулзалтад оролцсон даван туулагчдад урам өгөхөөр ДБЭТ-ийн дуучин Б.Сувд, Хүмүүнлэгийн үйлстэн хүүхдийн элч дуучин МУСТА Х.Буянжаргал уран бүтээлчид хүрэлцэн ирж ая дуугаа өргөсөн бөгөөд уулзалтын төгсгөлд оролцогчдын дунд явуулсан азтан шалгаруулах сугалаанд Дархан-Уул аймгаас ирсэн хөхний хавдрын даван туулагч Азтанаар тодрон гарын бэлэгний эзэн болсон юм.

ДӨРӨВ. МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГААНЫ МАТЕРИАЛ БОЛОВСРУУЛАХ

Зонхилон тохиолдох хорт хавдруудаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн сэдвээр ... төрлийн материалыг товхимол, санамж, постер, шторк, баримтат кино, подкаст хэлбэрээр хийж хэвлэмэл болон цахим хэлбэрээр түгээлээ. Үүнд:

4.1. Гарын авлага, товхимол, санамж, постер

- “Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн цагаан толгой”н агуулгаар 5-н төрлийн постер боловсруулан, хэвлэж амбулатори, тасгуудад тараах, төвийн пэйж, дэлгэцүүдэд байршуулан ашиглаж байна.



- Хавдрын үеийн сэтгэл зүйн тусламж, хоол зүйн тусламж, нийгмийн дэмжлэгийн сэдвээр санамж материалууд боловсруулан эмчлүүлэгч, үйлчлүүлэгчдэд түгээж байна. Элэг, ходоодны хавдар, хими эмчилгээний үеийн хооллолтын талаарх 3-н төрлийн санамжийг тус бүр 500 ш дахин хэвлүүлсэн.

- Хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ач холбогдлын сэдвээр 20-н төрлийн цуврал постер зөвлөмжийг НЭМҮТ-тэй хамтран боловсруулж цахим хэлбэрээр түгээсэн.

4.2. Видео контент



- Хавдрын эрсдэлт хүчин зүйлс ба хавдрын эрт илрүүлэг сэдвээр 2 төрлийн видео шторк хийж, хавдрын эсрэг Дэлхийн өдөр олон нийтийн цахим сүлжээ болон МҮОНТ, UBS, Малчин, С1, ТВ5, Ийгл ТВ-ээр давтамжтайгаар түгээсэн.




- “Эмчийн нэг өдөр” 3-н цуврал баримтат киног толгой хүзүүний нөхөн сэргээх мэс засал, улаан хоолойн хавдрын дурангийн мэс засал, элэгний хавдрын үеийн элэг шилжүүлэн суулгах мэс засал зэрэг зөвхөн ХСҮТ-д хийгддэг мэс засал эмчилгээний сэдвээр хийн МҮОНТ, UBS TV, ТВ-5, ТВ-9, ТВ-8, С-1, Малчин ТВ-ээр олон нийтэд цацаж хавдрын мэс заслын эмчийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний онцлогийг сурталчилсан.




-



Дэлхийн эмч нарын өдөрт зориулан ХСҮТ-өөс гадаадад суралцаж буй эмч нарын видео мэндчилгээг хийж төвийн гадаад сургалтын үйл ажиллагааг сурталчилсан.



- Цээжний хөндийн мэс засдын тасгийн 10-н жилийн ойд зориулсан ба авилгын эсрэг тус бүр 60 секундйн 2 шторк хийж төвийн пэйж хуудсанд байршуулсан. Мөн АТГ-т илгээсэн. Мөн ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалтын сэдвээр 2-н төрлийн реелийг ХӨСҮТ-тэй хийж ЕМЗ болон ТХМЗ-ын эмч нарын ярилалгыг оруулан олон нийтэд түгээсэн.



- Умайн хүзүү, уушиг гуурсан хоолой, хөхний хорт хавдруудаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, хавдрын эрсдэлт хүчин зүйлс, тамхидалт, ХПВ-ийн халдварын эсрэг дархлаажуулалт, хавдрыг даван туулахуйн, сэтгэл зүйн сэдвээр ХСҮТ-өөс 5-н удаагийн лайв зөвлөгөө, НЭМҮТ-тэй хамтран 11-н удаагийн рийл, нийт 16 удаагийн лайв, рийл зөвлөгөөг хийсэн.



ТАВ. ТЕЛЕВИЗ, РАДИО, СОНИН, НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ СУРТАЛЧИЛГАА

2024 онд тус төвөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаануудын талаар тухай бүрд нь байгууллагын нүүр номонд мэдээлэл тавих, хэвлэл мэдээллийн байгууллагуудад мэдээлэл өгөх болон олон нийтийн хэвлэл мэдээллээр түгээгдэж буй мэдээллүүдийн үнэн бодит байдлыг хянах, буруу ташаа мэдээллүүдийг залруулах, засах ажлууд тасралтгүй хийгдсэн.

Байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтэд хүргэх, мэдээлэхээс гадна ЭМЯ, НЭМҮТ, ДЭМБ, АНУ-ын Өвчний хяналтын төв зэрэг төрийн, төрийн бус, олон улсын байгууллагуудаас олон нийтэд зориулан гаргасан мэдээ, мэдээллүүдийг төвийн нүүр номонд байршуулж мэдээллээ.

- **ХСҮТ-ийн нүүр ном**

Мэдээллийн тоо: Нүүр номонд нийт 350 гаруй мэдээллийг байршуулж, баяжуулан шинэчилсэн байна.

ТӨВИЙН НҮҮР НОМОНД ХАНДСАН БАЙДАЛ



Хандагчид: 2024 онд төвийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээ, хавдрын эрсдэлт хүчин зүйлс, зонхилон тохиолдох хавдруудын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэг, эмч ажилчдын нийгмийн асуудал, ажлын байрны зар, эрдэм шинжилгээ судалга зэрэг сэдвүүдээр 350 гаруй мэдээ байршуулж хандагчдын тоо 72000 гаруйд хүрсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 6000 гаруйгаар нэмэгджээ. Мөн пэйжийн мэдээнд **таалагдсан** гэсэн үзүүлэлт 2023 оны эцэст 59000 байсан бол 2024 онд 61000-д хүрч өссөн байна.

- **Хэвлэл мэдээлэл**

Хавдрын тусламж үйлчилгээ, төвийн үйл ажиллагаа, эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаа, хавдраас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн 40 орчим хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр 430 гаруй мэдээ, ярилцлага, нийтлэл түгээсэн байна. Үүнд:

- Сонин хэвлэлээр дамжуулан 10 удаагийн мэдээ, сурвалжлага
- МҮОНРТ, UBS, ТВ-5, ТВ-9, ТВ-25, Өлзий ТВ, Ийгл ТВ, Тэнгэр Тв, С1 ТВ, ETV, HDMongol TV, Малчин ТВ, NTV, Eagle TV зэрэг сувгуудаар 200 орчм удаагийн мэдээ мэдээлэл
- Нийгмийн сүлжээ, мэдээллийн сайтаар 200 орчим удаагийн мэдээлэл, ярилцлага
- Монголын Үндэсний Радио, MGLRadio-Дэлхийн Монголчууд ФМ-ээр 20 удаагийн ярилцлага, мэдээ, мэдээлэл тус тус түгээгджээ.

Эмчийн лайв зөвлөгөө:

“Хорт хавдрын мэдээллийн сар”-ын хүрээнд умайн хүзүү, ходоод, улаан хоолой, бүдүүн шулуун гэдэс, хөх, уушигны хорт хавдруудаас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ач холбогдол, стомын үеийн арчилгаа зэрэг сэдвүүдээр 7 удаагийн “LIVE” нэвтрүүлэг бэлтгэн, өөрийн цахим хуудсаараа дамжуулан 5 дах жилдээ хүргэлээ. Тус “LIVE зөвлөгөө”-г МҮОНТ болон бусад мэдээллийн сайтууд шууд хуваалцан түгээж байна.

**Хавдар судлалын үндэсний төвийн ажиллагсдын
нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний 2024 оны тайлан**

2024 он

Цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох

1. Хөдөлмөрийн тухай хуулийн 107, 108, 109 дүгээр зүйлийг үндэслэн Монгол улсын Засгийн газрын “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2024 оны 128 дугаар тогтоолын 6, 10 дугаар хавсралтыг үндэслэн зарим албан тушаалын ажилтан тус бүрийн үндсэн цалинг тодорхой хувиар нэмэгдүүлэн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс олгож эхэлсэн.
Тус төв нь 2023 оны 04-р сарын 03-ны өдрөөс эхлэн их эмч, сувилагч, эм зүйч, физикч инженер гэсэн 4-н албан тушаалын ажилтнуудыг эмнэл зүйн цогц чадамжид суурилсан цалингаар цалинжуулж эхэлсэн. Үүнээс гадна ур чадвар мэргэжлийн зэрэг, дэвийг харгалзан дараах нэмэгдлийг олгон ажиллаж байна.
 - Хоол унааны нэмэгдэл–110000₮, (ЭМС-ны 2018 оны 548 дугаар сайдын тушаалыг үндэслэн)
 - Хэвийн бус нөхцөлийн нэмэгдэл: Хэвийн бус нөхцөлд ажиллаж буй ажилтанд үндсэн цалингийн 10 хувийн нэмэгдлийг сар бүр тогтмол
 - Цолны нэмэгдэл – Үндсэн цалингийн 10 хувь,
 - Ур чадварын нэмэгдэл – 10-25 хүртэлх хувь
 - Хариуцлагын нэмэгдэл – Албан тушаалын хариуцлагын дагуу,
 - Илүү цагийн хөлс – Илүү цагаар ажилласан хөлсийг 1,5 дахин,
 - Шөнийн цаг ажилласны нэмэгдэл – 1 цаг тутамд 1000 төгрөгөөр тооцох
 - Хавсран ажилласны хөлс – Хавсран ажилласан албан тушаалтанд үндсэн цалингийн 40 хүртэлх хувь,
2. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 491 дүгээр тогтоолын дагуу Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 2023 оны 1 дүгээр сарын 2-ноос эхлэн ажилласан жил бүрээр тооцон 1-25 хувиар өгч эхэлсэн ба одоо 478 ажилтан уг нэмэгдлийг авч байна.
3. Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын баримтлан “Эрүүл мэндийн ажилтанд нэмэгдэл урамшуулал олгох” журам, Хавдар судлалын үндэсний төвийн дүрмийг үндэслэн эмч, ажилтны ажлыг сар бүр дүгнэж, улирал тутамд үндсэн цалингийн 20 хүртэлх хувийн нэмэгдэл мөнгөн урамшууллыг олгож байна. 2024 оны 1 дүгээр улиралд 446, 2 дугаар улиралд 419, 3-р улиралд 416 ажилтанд тус тус урамшуулал олгосон байна.

**Хөдөлмөрийн норм нормативыг үндэслэн ажлын ачааллыг
тэнцвэржүүлэхээр авсан арга хэмжээ**

4. Эрүүл мэндийн сайдын 2022 оны “Улсын хэмжээнд 2022-2025 онд эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглах орны дээд хязгаарыг батлах тухай” А/475 дугаар тушаал, төвийн захиргааны зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн өвчний цочмог үеийн 154 ор, өвчний хурцавтар үеийн 30 ор, хөнгөвчлөх эмчилгээний 45 ор, өдрийн эмчилгээний 46 ор нийт

төвийн хэмжээнд 275 ор ажиллахаар норм нормативыг тогтоож төлөвлөгөөг боловсруулсан.

5. Хавдар судлалын үндэсний төвийн “Амбулаторийн үзлэгийн норм нормативын төлөвлөгөө”, “Хэвтүүлэн эмчлүүлэх тусламж үйлчилгээний ажиллах норм нормативын төлөвлөгөө”, “Үйл оношилгоо, лабораторийн шинжилгээний төлөвлөгөө”-г тасаг албадын хүний нөөц, тоног төхөөрөмжийн хүчин чадал, орны тоо, ачаалал зэрэгт харгалзан гаргасан.
6. Төвийн туяа эмчилгээний тусламж үйлчилгээнд шинэ технологи нэвтрүүлсэнтэй холбоотойгоор ажлын ачааллыг харгалзан шарлагын техникчийн 2 орон тоог нэмж баталсан.
7. Эрүүл мэндийн сайдын тушаал, тус төвийн үйл ажиллагааны цаашдын зорилго, эмч, ажилтнуудын ажлын ачааллыг бууруулах чиглэлээр тасаг, албанаас ирүүлсэн саналыг харгалзан Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн дараах орон тоог 2024 оны 05-р сараас шинээр нэмж, мөн албан тушаалын чиг үүргийг өөрчлөлтөөс шалтгаалан шилжүүлэн нэмж баталсан.
 - Сувилахуй эрхэлсэн дэд захирал
 - Эрдэм шинжилгээ, судалгаа хариуцсан мэргэжилтэн
 - Маркетинг сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн
 - Эрүүл мэндийн даатгалын бүртгэгч
 - Мэдээгүйжүүлгийн сувилагч
 - Мэс засал, боолтын сувилагч
 - Туслах сувилагч
 - Төвийн эрхлэгч, их эмч
 - Элэг цөс нойр булчирхайн мэс заслын их эмч
 - Шарлагын техникч
 - Сэргээн засах эмчилгээний их эмч
 - Дүрс оношилгооны их эмч
8. Эмч, ажилтнуудын ээлжийн амралтын хуваарийг холбогдох албан тушаалтнуудаар ажил үүргийн хуваарийн зохицуулалтыг давхардуулахгүй байхаар зохион байгуулалтыг хийлгэн хянуулсны дагуу ХСҮТ-ийн Ерөнхий захирлын тушаалаар баталгаажуулсан. Ажил үүргийн хуваарь, ажилтны хүсэлтийг харгалзан ээлжийн амралтын хуваарьт тухай бүрд нь зохицуулалт хийн ажиллаж байна.
9. Эмчилгээ, үйлчилгээний хүлээгдлийн мэдээг 7 хоног бүрээр гарган Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэн ажилладаг ба энэ онд хүлээлгийн бууруулахаар дотоод шүүрлийн эмчийн кабинетыг шинээр байгуулан ажиллаж байна.

Мөнгөн ба мөнгөн бус урамшууллын шинэлэг тогтолцоог нэвтрүүлж, урамшууллыг ажлын гүйцэтгэлийг сайжруулах, идэвхжүүлэх хөшүүрэг болгох

10. 2022 оноос эхлэн “Дотоодын их, дээд сургуульд докторантур, магистрантурын сургалтанд суралцаж байгаа тус төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд сургалтын дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу **магистрантурт суралцаж төгссөн** эмч, ажилтны боловсролын зэрэг хамгаалсан жилийн сургалтын төлбөрийн 70 хүртэлх хувийг байгууллагаас буцаан олгон ажиллаж байгаа. 2024 онд 3-н мэргэжилтэнд **сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэн** 2.3 сая төгрөг зарцуулж, эмч, мэргэжилтнүүдийг сурч боловсрох, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэхэд нь дэмжин ажилласан.
11. 2024 онд төвийн **10 ажилтан мэргэжлийн зэрэг** (ахлах, тэргүүлэх, зөвлөх) хамгаалсан ба холбогдох бичиг баримтыг үндэслэн 2024 оны 10-р сарын 01-ний өдрөөс **үндсэн цалингийн 10-20 хувийн** мэргэжлийн зэргийн нэмэгдлийг өгч ажилласан.

12. 2024 оны 11-р сарын байдлаар 94 **эмч, ажилтнуудад гадаадын улс орнуудад хурал, сургалт, семинар, туршлага** солилцох зорилгоор 1 сар хүртэлх хугацаагаар **олговортой болон олговоргүй чөлөөг** олгосон.
13. 5-н ажилтанд эрдмийн цол, мэргэжлийн зэрэг хамгаалахад нь зориулан 5 хүртэлх хоногийн олговортой болон олговоргүй чөлөө олгосон.
14. Гадаад улс орнуудад мэргэжил дээшлүүлэх, туршлага солилцох, боловсролын зэрэг хамгаалах зорилгоор 20 хоног ба түүнээс дээш хугацаагаар чөлөө авсан 13 эмч, ажилтнуудтай мөн дотооддоо төрөлжсөн мэргэжлээр суралцах 2 эмчтэй тус тус сургалтын гэрээ байгуулан ажлын байрыг нь хадгалж, чөлөөтэй байх хугацаанд нь нийгмийн даатгалын шимтгэлийг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож байгууллагаас төлсөн.
15. ХСҮТ-ийн **Хүүхэд хамгаалах бодлогын** хүрээнд төвийн эмч, ажилтнуудын хүүхдүүдэд 2024 оны 05 дугаар сард **Хүүхдийн баярыг** тохиолдуулан Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн билет бэлэглэсэн.
16. Тус төвийн Хөдөлмөрийн дотоод журмын 5-р бүлгийн 6 дахь заалт, төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн **нэгдүгээр ангид хүүхэд нь элсэн орж суралцаж байгаа нийт 28 ажилтанд** буюу 2023-2024 оны хичээлийн жилд 19, 2024-2025 оны хичээлийн жилд 9-н ажилтанд өдөр бүр ажлын цагаас **30 минутын хугацаагаар богиносгон** хөнгөлөлт үзүүлсэн.
17. Ажилтнуудын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд МУ-ын Засгийн газрын тогтоолыг үндэслэн 2024 оны 04-р сарын 01-ний өдрөөс эмч, ажилтнуудын цалинг нэмсэн.
18. Төвийн Ерөнхий захирлын тушаалаар Хөдөлмөрийн тухай МУ-ын хууль, Төвийн хөдөлмөрийн дотоод журмыг баримтлан нийтдээ давхардсан тоогоор 252 ажилтанд олговортой болон олговоргүй, урт болон богино хугацааны чөлөө олгосон.
19. Хөдөлмөрийн дотоод журмын заалтыг үндэслэн **эхнэр нь хүүхэд төрүүлж** хүүхэдтэй болсон **2 ажилтанд** ажлын 10 өдрийн олговортой чөлөө олгосон ба **хүүхэд асрах чөлөөтэй байгаа 59 ажилтны** ажлын байрыг хадгалан нийгмийн даатгалын шимтгэлийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон байгууллагаас төлж ажилласан.
20. Хөдөлмөрийн дотоод журмын дагуу аав, ээж, үр хүүхэд нь нас барсан 15 ажилтанд тус бүр 250 000 төгрөгийн **1 удаагийн тусламж** олгосон. Мөн төвийн өндөр настны бүртгэлд бүртгэлтэй 1 өндөр настан нас барсанд гүн эмгэнэл илэрхийлэн ар гэрт нь 1 удаагийн тэтгэмж олгосон. Эдгээрт нийтдээ **4.5 сая** төгрөг зарцуулан ажилласан.
21. Томуугийн улирал буюу 10-р сараас 03-р сард ажилтнуудын дархлааг дэмжих витаминжуулах зорилгоор өглөө бүр чацаргана болон бусад жимсний шүүс, аарц зэргийг бүх ажилтнууддаа өгч ажилласан.
22. 2024 оны 04-р сард **“Үйлчлэгч нартаа баярлалаа”** талархлын өдрийн хүрээнд төвд ажиллаж байгаа үйлчлэгч нартаа талархалаа илэрхийлэн, ажлын урам зориг өгч, баярын өдөр болгон зохион байгуулсан.



23. МУ-ын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу төвийн хэмжээнд **хөгжлийн бэрхшээлтэй 21 ажилтанд** хууль, тогтоомжийн дагуу хөнгөлөлт (**ХХОАТ-ын 10 хувийг, НД болон ЭМ даатгалын** тодорхой хувиар **чөлөөлсөн, ээлжийн амралтанд нэмж 5 өдөр** олгох г.м)-ийг эдлүүлэн ажилласан.
24. Тус төв “Хаан” банк, “Голомт” банк болон “Худалдаа хөгжлийн банк”-тай гэрээ байгуулсны дагуу төвийн эмч, ажилтнуудад **цалингийн зээлийг** хөнгөлөлттэй нөхцлөөр буюу **1.2-1.4 хувиар** зээл авахад нь дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.
25. Хүний нөөц, хөгжлийн албанаас эмч, ажилтнуудад сургуульд сурах, хүүхдээ гадаадад сургуульд сургах, банкны зээлийн баталгаа гаргах, лизингээр эд зүйл худалдан авах, мэргэжлийн дагуу хурал, семинарт оролцох зорилгоор элчин сайдын яамдад виз хүсэх гэсэн шалтгаануудаар давхардсан тоогоор 2024 оны 10-р сарын 31-ний 327 ажилтанд хүний нөөц, хөгжлийн албаны тодорхойлолт гарган ажилласан.
26. Улсдаа болон эрүүл мэндийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж буй эмч ажилтнуудыг салбарын болон төрийн дээд одон медалиар шагнахаар нэр дэвшүүлэн холбогдон албан байгууллагад тодорхойлон ажилласан ба тэдгээрээс 2024 онд Эрүүл мэндийн яамны “Жуух бичиг”-ээр 10 ажилтан, “Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан” цол тэмдэгээр 7 ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медалиар 15 ажилтан, “Алтан гадас” одонгоор 7 ажилтан, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 2 ажилтан тус тус шагнагдсан байна. Үүнээс гадна Монголын эмэгтэйчүүдийн холбооны “Хүндэт тэмдэг”-ээр 4 ажилтанг, Монголын эмэгтэйчүүдийн холбооны “Дурсгалын тэмдэг”-ээр 24 ажилтанг тус тус шагнагдлаа.



27. ХСҮТ-өөс өндөр насны тэтгэврээ тогтоолгосон бүртгэлтэй 190 гаран ахмад настанд Сар шинийн баяр, Ахмадын өдрийг тохиолдуулан үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. 2024 оны 01-р сард Сар шинийн баярыг тохиолдуулан тавгийн идээг нь өгсөн ба 2024 оны 09-р сард Ахмадын баярыг тохиолдуулан хүлээн авч хүндэтгэл үзүүлэн, гарын бэлэг тус тус гардуулсан.



Ажлын цагийн уян хатан тогтолцоог нэвтрүүлэх үндэслэл, шаардлагыг судлан арга хэмжээ авах

28. Ажилтнуудаас авсан сэтгэл ханамжийн судалгааны дүгнэлт, бусад холбогдох бичиг баримтын дагуу хэрэгцээ шаардлагыг харгалзан “Ажлын цаг ашиглалт, цагийн бүртгэлийн журам”-ыг 2023 оны 05-р сарын 29-ний өдрийн А/41 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан. Уг журмыг мөрдүүлэх, ажиллагсдын ажлын цагийн бүтээмжийг сайжруулах зорилгоор цаг бүртгэлийн программыг ашиглан ажиллагсдын цагийн бүртгэлд бүрэн хяналт тавьж, цаг бүртгэлийн тайланг сар бүр цахим программаар гарган ажиллаж байна.
29. Шинээр батлагдсан “Ажлын цаг ашиглалт, цагийн бүртгэлийн журам”-ыг бүх эмч, ажилтнуудад мэдээлж танилцуулсан ба мөн 2024 онд шинээр ажилд орсон нийтдээ 71 ажилтанд нэг бүрчлэн танилцуулж гарын үсэг зуруулан баталгаажуулсан.
30. Ажлын ачаалал, тасаг албаны ажлын уялдаа холбоо, үйл ажиллагааны зохицуулалт зэргийг харгалзан зарим ажилтны хүсэлтийг харгалзан холбогдох удирдах албан тушаалтан зөвшөөрсөний үндсэн дээр ажлын цагийн хуваарьт өөрчлөлт оруулан цаг бүртгэлийн тайлан мэдээг гарган ажиллаж байна.
31. Сар бүрийн эхний 15, 25-ны дотор ажиллагсдын цагийн бүртгэлийг үндэслэн цалингийн хоногийг ажилтан тус бүрээр гаргаж цалин олгох анхан шатны нөхцлийг бүрдүүлж өгсөн.
32. Мөн ажиллагсдын илүү цаг ажилласан бүртгэлийг цагийн цахим бүртгэлтэй тулган бодолт хийж Эмнэл зүй эрхэлсэн дэд захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн дэд захирлаар хянуулан сар бүрийн эхний цалингийн өмнө нийт илүү цагийг нэгтгэн гаргаж ажилладаг.
33. “Эрүүл мэндийн ажилтанд ажлын үр дүн гүйцэтгэлээр нэмэгдэл мөнгөн урамшуулал олгох тухай” журмын дагуу улирал болгон ажилтнуудын цаг ашиглалтыг хянан журмын нэг үзүүлэлт болгон мөрдөн ажиллаж байна. Ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээг сар бүр ажилтнуудад олгосон чөлөө, гадуур ажиллах зөвшөөрөл, ажлын бус цагаар ажиллуулсан зөвшөөрөл, хөдөлмөрийн чадвар түр алдалтын бүртгэлийг үндэслэн цаг бүртгэлийн тайланг программ хангамжийн дагуу гаргадаг. Нийт ажиллагсдын цаг ашиглалтын үнэлгээг сар бүрийн 5-ны дотор тасаг албадад ажилтан нэг бүрээр гарган баталгаажуулж хяналт үнэлгээний багт өгч ажиллаж байна. Мөн тасаг, нэгжийн ажлыг дүгнэх үнэлгээний нэг үзүүлэлт болгон оруулж хяналт тавин ажилласан.

Эрүүл, аюулгүй ажлын байр бүрдүүлэх

34. Тус төвийн эмч, ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 3-р сард гурван сарын хугацаатай “Эрүүл биеэрээ гоёцгооё” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэн ажилласан.



- Уг хөтөлбөрийг олон мэргэжилтний баг удирдан зохион байгуулсан ба үүнд дотоод шүүрлийн эмчийн зөвлөгөө, сэргээн засах тасгийн олон мэргэжилтний зөвлөгөө, дасгал, хоол зүйчийн зөвлөгөө, хичээл багтсан ба үүнээс гадна тусгайлан гаргасан хоолны цэсийн дагуу хөтөлбөрт хамрагдсан эмч, ажилтнуудад зориулан өдрийг хоолыг байгууллагын захиргаанаас үнэ төлбөргүй ажлын байранд нь өгч байх асуудлыг бүрэн шийдвэрлэж ажилласан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд цусны шинжилгээг хөтөлбөрийн эхэнд ба сүүлд авч, 7 хоног бүр хэмжилт үнэлгээ хийж, сургалт мэдээллийг өгч ажилласан. Үүний үр дүнд нийт оролцогчдын БЖИ 32.2 (4.9) -29.7 (5.2) болж буурсан сайн үзүүлэлт гарсан байна.
35. 2024 оны 10 дугаар сарын байдлаар тус төвийн нийт 178 эмч, ажилтан давхардсан тоогоор 867 удаа сэргээн засах эмчилгээнд хамрагдсан байна. Сэргээн засах эмчилгээнд эмч 32.5%, сувилагч 24.1%, бусад ажилтан 43.2% хамрагдсан бөгөөд эмчилгээнд хамрагдагсдын 42% нь 41-50 нас, 37% нь 50-аас дээш насны эмч, ажилчид байна. Оношийн бүлгээр авч үзвэл 49,1% нь нуруу, 19,2% нь хүзүүний өвчлөлтэй эмч, ажилтан байсан ба тэдгээрийг сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэн тохирох эмчилгээнд хамруулж эмч, хөдөлгөөн засалчийн зөвлөгөө өгч ажилласан байна.
36. ХСҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг 2024 оны 5, 10 дугаар сард үйлчлүүлэгчийг дэмжих албаны нийгмийн ажилтан зохион байгуулан явуулсан. Ажиллагсдын сэтгэл ханамжийн судалгааг 5 бүлэг 32 асуумж, нэг нээлттэй асуултаар нэгэн агшины судалгаанд хамруулан авлаа. 2 удаагийн судалгаанд Хавдар судлалын үндэсний төвийн нийт 35 тасаг, албадын 190 эмч, мэргэжилтнүүдийг тоон судалгааны санамсаргүй түүврийн аргаар сонгож судалгаанд хамруулсан.
37. ДЭМБ-аас жил бүрийн 10-р сарын 10-ны өдөр “Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах Дэлхийн өдөр” хэмээн зарласан билээ. 2024 онд энэхүү өдрийг “Ажлын байранд сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалъя” уриан дор тэмдэглэсэн. Ажлын байранд гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах, дарамт шахалт болон хөдөлмөрийн муу нөхцөл байдал нь ажилтны сэтгэцийн эрүүл мэнд, ажлын бүтээмж, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж буйг ДЭМБ-аас онцлон анхааруулжээ. Үүнтэй холбогдуулан 2024 оны 10-р сард “Урлагаар эмчлэх” сэдэвт үйл ажилагааг зохион байгуулсан ба тус төвөөс 20 гаран эмч, ажилтан хамрагдсан байна.
38. 2024 оны 10-р сард Эмч, сувилагч ярианд “Гэмтлийн дараах өсөлт” сэтгэл зүйн сургалтанд 30 үйлчлэгч, 80 эмч, 120 сувилагч хамрагдлаа.
39. ХСҮТ-ийн ажилчдад зориулсан ажлын байрны стрессийг бууруулах, бусдын асуудал, зовлонг ойлгож мэдрэх чадвар, анхаарал төвлөрлийг сайжруулах талаар мэдлэг олгох, эерэг хандлага төлөвшүүлэх сургалтыг Дилав хутагт сантай хамтран “Танин мэдэхүйд суурилсан энэрэх сэтгэлийг хөгжүүлэх нь”

(СВСТ) сургалтыг 2024 оны 11, 12-р саруудад зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Дэмжлэгт орчныг бий болгох

40. Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах дэд хөтөлбөрийн хүрээнд төвийн захиргаа, Худалдаа хөгжлийн банкны удирдлагын төлөөлөлтэй удаа дараа уулзалт зохион байгуулж, банкны бүтээгдэхүүн үйлчилгээг тусгай нөхцөлөөр, хөнгөлөлттэй, уян хатан байдлаар нийт ажилтнуудад олгох цалингийн зээл болон орон сууцны зээлийн нөхцөлийг шийдвэрлүүлэхээр хамтран ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд орон сууцны ипотекийн 6%-ийн зээлд хамрагдах болон хөнгөлөлттэй үнээр худалдан авах хүсэлтэй ажилтнуудыг дэмжин ажилласан.

Хөдөлмөрийн эрүүл ахуйн, халдварын сэргийлэлт, хяналтын үйл ажиллагаа

41. 2024 оны 10-р сард тус төвийн нийт эмч, мэргэжилтэн, эм зүйч нарт “Гарын эрүүл ахуй” буюу гар угааж, халдваргүйжүүлэх үе, гарын эрүүл ахуй сахих 5 мөч зэрэг мэдлэгийн сэргээх тухай сургалт орсон.



42. Мөн 10-р сард Тус төвийн нийт эмч, мэргэжилтэн, эм зүйч нарт “Сэрэмжлүүлэх бичил биетэн”-ний талаар тухай сургалт орлоо. Сургалтаар сэрэмжлүүлэх бичил биетний жагсаалт, эмэнд тэсвэржсэн онцгой хэв шинж бүхий бактери жагсаалт, стандарт болон нэмэлт сэргийлэлтийн аргын талаарх мэдээлэл бүхий сургалт орлоо.

43. “Улирлын томуугийн эсрэг сайн дурын дархлаажуулалт”-ыг 2024 онд 2 удаа буюу 2024.09.20, 2024.11.01-ны өдрүүдэд зохион байгуулан нийтдээ 150 ажилтан вакцинд хамрагдсан байна.

44. “Гарын эрүүл ахуйн өдөр” өдөрлөгийн үйл ажиллагааг 2024.05.03-ний өдөр “Гүн тэнгэрийн нар” ХХК хамтран зохион байгуулсан ба өдөрлөгийн үеэр төвийн 200 гаруй эмч, ажилтнуудад мэдээлэл хийж, тараах материал өгч ажилласан.



45. Шинээр ажилд орсон эмч, сувилагч тусгай мэргэжилтэн, үйлчлэгч зэрэг 71 ажилтанд ажлын байранд гарахын өмнө Төвийн Ерөнхий захирлын баталсан “Шинэ ажилтныг чиглүүлэх сургалтын хөтөлбөр”-ийн дагуу “Халдварын сэргийлэлт, хяналт”, “Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлын менежмент” сэдвээр сургалтанд хамруулж, мэргэжлийн эрсдэлт хүчин зүйлсийн талаар мэдээлэл, зөвлөгөө өгсөн.
46. 2024 оны 10-р сарын байдлаар зүүнд хатгуулсан 13 тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс: эмч- 1, сувилагч- 2, туслах сувилагч-4, үйлчлэгч-1, резидент-3, бусад-2 байсан. Өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг шуурхай авч дархлал тогтцын шинжилгээ хийж, дархлаажуулсан бөгөөд зохих зөвлөмжийг шуурхай өгч ажиллаж байна.

--- оОо ---


Хавдар судлалын үндэсний төвийн ажилтнуудын эрүүл мэндийн дэмжих дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн 2024 оны тайлан

2024 оны 11-р сарын 29

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
Нэг. Урьдчилан сэргийлэх үзлэгт ажилтнуудыг хамруулан, эрүүлжүүлэх, хянах ажлыг зохион байгуулах		
1.1.	Жил бүрийн 1-р улиралд багтаан бүх ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт үнэ төлбөргүй хамруулах	<p>Хавдар судлалын үндэсний төв нь одоогоор ажиллаж байгаа үндсэн ажилтан болон гэрээт ажилтнууд мөн хүүхэд асрах чөлөөтэй байгаа, урт хугацааны сургалтын чөлөөтэй байгаа ажилтнуудыг багтаан нийтдээ 626 эмч, ажилтнуудын нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулан ажиллаж байна.</p> <p>Жил бүрийн 1-р улиралд бүх ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан хэвшсэн ба 2024 онд Урьдчилан сэргийлэх үзлэгийг 03 дугаар сарын 15-ны өдрөөс 04 дүгээр сарын 05-ны өдрийн хооронд 20 хоногт багтаан зохион байгуулсан. Үзлэгт хамрагдвал зохих ажилтнуудаас 524 эмч, ажилтан буюу 96 хувь нь хамрагдсан байна. Үзлэгээр:</p> <ul style="list-style-type: none"> - Хэвлийн эхо шинжилгээ - Цээжний рентген - Хөхний хавдрын илрүүлэг үзлэг, хөхний эхо - Толгой хүзүүний хавдрын үзлэг, бамбайн эхо - Эмэгтэйчүүдийн үзлэг, умайн хүзүүний эсийн шинжилгээ - Дотор, зүрх судас, зүрхний бичлэг, зүрхний эхо - Нүдний эмчийн үзлэг, нүдний уг - Ясны денситометр - Умайн хүзүүний эсийн шинжилгээ - Улаан хоолой, ходоод, дээд гэдэсний дуран - Лабораторын шинжилгээ <p>Мөн уг үзлэгийн үеэр Улсын гуравдугаар төв эмнэлгээс нүдний эмч, зүрх судасны төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэгт эмч, ажилтнуудыг хамруулан өвчлөлийн байдалд судалгаа хийж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - 2024 онд шинээр ажилд орсон 73 ажилтан, урт хугацааны чөлөөнөөс ажилдаа орсон 23 ажилтныг тус тус эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
1.2.	Урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн цаашид эмчийн хяналтанд тогтмол байх ажилтнуудын үзлэг, шинжилгээг тасралтгүй үргэлжлүүлэх	<ul style="list-style-type: none"> - Мөн ионжуулагч цацрагийн үүсгэвэртэй харьцаж буй 49 ажилтанг Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2024 оны 4-р сарын 22-30-ны хооронд хамруулсан. - Урьдчилан сэргийлэх үзлэгээр илэрсэн цаашид эмчийн хяналтанд тогтмол байх ажилтнуудын үзлэг, шинжилгээг тасралтгүй үргэлжлүүлэн ажиллаж байна. Элэгний гемангиома, цөсний хүүдийн ургацаг /полип/, эмэгтэйчүүдийн хавдрын урьдал эмгэг (ургацаг, дисплазия), хөхний үзлэгээр BIRADS III-IV үнэлгээтэй, толгой хүзүүний хавдрын мэс заслын эмчийн үзлэг, оношилгоогоор бамбайн зангилаа оношлогдсон тэдгээр ажилтнууд тус бүрт гурван сараас нэг жил хүртэл хугацаанд дахин хянуулах зөвлөмжийг өгсний дагуу хяналтанд авсан. - Ажилчдын дунд хоол боловсруулах эрхтэн тогтолцооны архаг эмгэг, зүрх судасны эрхтэн тогтолцооны өвчлөл зонхилон тохиолдож байна. Иймд хамт олны дунд дасгал хөдөлгөөн, зохистой хооллолт, спиртийн төрлийн ундааг стандарт хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, хорт зуршлаас татгалзах, стресс бухимдлаа тайлах, зөв удирдах зэрэг сэдвүүдээр ажлын байрны дотоодын сургалтуудыг Хүний нөөц хөгжлийн алба, сэргээн засах тусламж үйлчилгээний баг, эмчилгээний хоол шим тэжээлийн тасаг, үйлчлүүлэгчийг дэмжих алба зэрэг алба тасаг нэгжүүд хамтран ажиллаж уралдаан, аян гэх мэт эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг хамт олны дунд үе шаттайгаар зохион байгуулж үр дүнг тооцон ажиллаж байна. - Үзлэгээр онош тодруулах шаардлагатай хортой хавдар оношлогдсон ажилчдыг нэн даруй цаг алдалгүй эмчилгээнд хамруулсан. - Эмч, ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгээр нян тээгчийг илрүүлэх шинжилгээнд хамруулсан бөгөөд эмч, ажилчдын хамраас МТСА илэрсэн. Нян тээгч илэрсэн ажилчдад хлоргексидиний 0,1% хамар хоолой зайлах уусмал, хлоргексидиний 4% гар угаах саван, МТСА-ын талаарх гарын авлага, сургалт орсон. Давтан шинжилгээ авч баталгаажуулсан бөгөөд 100% эрүүлжсэн. - 2023 онд 143 ажилтан давхардсан тоогоор 203 удаа буюу нийт ажилчдын 25,4%, 2024 онд 122 ажилтан буюу давхардсан тоогоор 246 удаа буюу 21.7% нь тодорхой хугацаагаар хөдөлмөрийн чадвараа түр алдсан байна. 2024 оныг 2023 оны мөн үеийнхтэй харьцуулахад хөдөлмөрийн чадвараа түр алдалт 3,7%-аар буурсан байна.
1.3.	Ажилтнуудын элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээ, биохимийн шинжилгээ, цусны дэлгэрэнгүй шинжилгээ,	<ul style="list-style-type: none"> - Төвийн ерөнхий захирлын 2024 оны Б/101 дүгээр тушаалаар М.Мөнхжаргал нь 2024 оны 3 дугаар сарын 25-ны өдрөөс ажилтны эрүүл мэнд хариуцсан их эмчээр томилогдон ажиллаж байна. - “Төвийн нийт ажилчдад хийгдэх урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах ажлын удирдамж”-ын дагуу 2024 оны 03-04 дүгээр саруудад баталсан хуваарийн дагуу лабораторийн шинжилгээ ба үзлэг, оношилгоо шинжилгээ гэсэн хоёр үе шаттайгаар урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан.

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
	шээсний шинжилгээнд бүрэн хамруулах	<p>ХСҮТ-н нийт 524 ажилтнаас шинэ ажилтан 54, үндсэн 470 ажилтан үзлэгт хамрагдахаас үзлэгт оношилгоонд 451 ажилтан (96%), шинжилгээнд 469 (99% (эм-349, эр-102)) хамрагдсан. Төвийн эмч, ажилтнуудаас эмэгтэйд 13, эрэгтэйд 9 төрлийн оношилгоо шинжилгээ хийж ажилласан.</p> <ul style="list-style-type: none"> - Ажилтнуудын элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээ, биохимийн шинжилгээ, цусны дэлгэрэнгүй шинжилгээ, шээсний шинжилгээнд бүрэн хамруулсан. - Товлолт В гепатитын эсрэг дархлаажуулалтын сэргээх тун /1 тун/- 2, 2-р тунд 1, 3-р тунд 26 эмч, ажилтныг хамруулсан. Нийт ажилчдын дархлал тогтоц 100 mIU/ml дээш 458 ажилтан буюу 87% дархлаатай байна. - Тархвар судлалын заалтаар Улаанбурхан, улаануудын вакцинд эмч- 54, сувилагч- 61, бусад ажилтан-65 буюу нийт 180 /34,2%/ ажилтан хамрагдсан. - Улирлын томуугийн дархлаажуулалтанд 250 /47,5%/ ажилтан хамруулсан. - 2024 оны 10-р сарын байдлаар 73 шинэ ажилтанд чиглүүлэх сургалт орсон. Лабораторийн шинжилгээ (ЦЕШ , В, С вирусийн маркер, В вирусийн вакцины дархлаа тогтоц, бактерлоги) зэрэг шинжилгээнүүдийг бүрдүүлэн ажилд авч байна. В вирусийн дархлаажуулалтанд хамрагдаагүй ажилчдыг ХӨСҮТ дээр дархлаажуулалтанд хамрагдсан шинжилгээний хариуг харж ажилд авч байна.
1.4.	Шинээр ажилд орсон ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулан В гепатитийн эсрэг вакцинд хамруулах	2024 оны 10-р сарын байдлаар 73 шинээр ажилд орсон ба тэдгээрийг лабораторийн шинжилгээ (ЦЕШ , В, С вирусийн маркер, В вирусийн вакцины дархлаа тогтоц, бактерлоги)-үүдийг бүрдүүлэн ажилд авч байна. В вирусгүй эмч, ажилтнуудыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд дархлаажуулалтанд хамруулан бүртгэл хийж, мэдээллээр хангаж ажилласан.
1.5.	Төвийн ажилтнуудын эрүүл мэндийн талаарх мэдлэг хандлага, дадлыг үнэлэх суурь судалгаа хийх	<p>2024 онд ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих чиглэлээр дараах судалгаануудыг хийж ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төвийн ажилтнуудын эрүүл мэндийн талаарх мэдлэг хандлага, дадлыг үнэлэх суурь судалгаа хийгдэж байна. - ХСҮТ-ийн Эмч, сувилагч нарын стресс, сэтгэл гутрал, түгшүүр, нийгмийн дэмжлэгийг тодорхойлох судалгааг онлайн хэлбэрээр авсан. Судалгаа 5 дугаар сард хийгдсэн 17 ажилтан оролцсон. - Япон улсын Хирошима их сургуультай хамтран “Монгол улсын эрүүл мэндийн ажилтнуудын дунд сэтгэцийн эрүүл мэнд, ажлын байрны стрессийг хянах тандах туршилт судалгаа”-д эмч, ажилтан оролцсон. - БНСУ-ын Ионсэй Их сургуулийн Вонжу дахь коллежийн (Yonsei University Wonju College of Nursing) профессор Ki Kyong Kim, зөвлөх профессор JiHea Choi болон SoMi Park нарын удирдлаган дор

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
		<p>“Монгол сувилагчдын сэтгэл зүйн капитал, бүтцийн чадавхи, ажил мэргэжлийн өсөлтөд чиглэсэн байгууллагын тууштай байдлын хоорондын хамаарал” (The relationships of psychological capital, structure empowerment and career growth with organizational commitment in Mongolian nurses) сэдвээр судалгаа хийж магистрын зэрэг хамгаалсан. Энэхүү судалгаанд ХСҮТ-ын 80 сувилагч ХӨСҮТ-ын 50 сувилагч нийт 130 сувилагч хамрагдсан болно. Мөн энэхүү судалгааны үр дүнд үндэслэн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэн тэтгэлэгийн газрын төлөөлөгчид (КОФИН), Ионсэй Их сургуулийн захирал болон профессорууд болон ХСҮТ-ын захиргааны зөвлөлд танилцуулан үйл ажиллагааг 2025 оны төлөвлөгөөнд оруулан хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.</p> 
1.6.	Ажиллагсдын бие бялдарын үзүүлэлт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгаа хийх	<ul style="list-style-type: none"> - Ажиллагсдын бие бялдарын үзүүлэлт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын судалгааг хийж байна. Нийт ажилтны эрүүл мэндийн үзлэгийн мэдээллүүдийг сүүлийн 5 жилээр бүртгэл үүсгэн судалж байна. 2024 оны ажилтнуудын эрүүл мэндийн үзлэгээр илэрсэн өвчлөлийн байдлыг 2022-2023 онтой харьцуулахад ойролцоо боловч 2019-2021 онуудтай харьцуулахад бамбайн зангилаа, зүрх судасны өвчлөл тус тус 5%-аар нэмэгдсэн хандлагатай байна. - "Эрүүл биеэрээ гоёцгооё" хөтөлбөрт 30 эмч эмнэлэгийн ажилчдыг хамруулан судалгаа хийгдсэн. Оролцогчдын 60% БЖИ 30-аас дээш буюу таргалалттай, 33.3% нь жингийн илүүдэлтэй, 86% нь булчингийн массын алдагдалтай, 63% нь дотор өөхлөлттэй өндөр байна. Оролцогчдын 36.6% байнгын суугаа ажил эрхэлдэг, 30% нь ээлжийн ажилтай, үлдсэн 33% тогтмол цагт өдрийн хоол идэх боломжгүй гэсэн судалгаа гарсан байна.
1.7.	Олон мэргэжилтний хяналтанд зорилтот бүлгийн ажилтнуудад “Эрүүл биеэрээ гоёцгооё” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	ХСҮТ-өөс хүн амын дунд зонхилон тохиолдох өвчнөөс сэргийлэх, эрүүл идэвхтэй амьдралыг сурталчлах, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэсэн үйл ажиллагааг 2024 оны туршид тодорхой чиглэлийн дагуу зохион байгуулахаар төлөвлөсний эхний арга хэмжээ болох зохистой хооллолт, дасгал хөдөлгөөнийг дэмжих замаар таргалалтыг бууруулах “Эрүүл биеэрээ гоёцгооё” аяныг төвийн хэмжээнд зохион байгуулан ажилласан. Аянаас дараах үр дүн гарсан.

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
		<ol style="list-style-type: none"> 1. Нийт 9 долоо хоногийн хугацаанд 29 удаагийн дасгал хөдөлгөөнд хамруулсан. Бүтэн хамрагдсан 27%, 10-аас дээш хамрагдсан 33%, 10-аас доош хамрагдсан 30% байна. 2. Хоол зүйчийн гаргасан цэсний дагуу хоололсон байдлаа өдөр бүр мэдээлсэн байдлыг харахад 30% бүрэн мэдээлсэн, 30% огт мэдээлээгүй, 40% бүрэн бус мэдээлэлсэн байна. 3. Нийт оролцогчдын 20% цусан дахь өөт тос илүүдэлтэй, 13%, триелицерид ихэссэн, 30% бага нягтралтай лифофротен ихэссэн, 6.6% бамбайн дааврын дутагдалтай, дааврын эм тогтмол ууж байна. 4. Нийт оролцогчдын БЖИ 32.2 (4.9) -29.7 (5.2) болж буурсан байна.
1.8.	Зөв хоололтыг дэмжих	<p>ХСҮТ-өөс хүн амын дунд зонхилон тохиолдох өвчнөөс сэргийлэх, эрүүл идэвхтэй амьдралыг сурталчлах, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгоход чиглэсэн үйл ажиллагааг 2024 оны туршид тодорхой чиглэлийн дагуу зохион байгуулан ажилласан. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Олон улсад шим тэжээлийн үнэлгээ хийдэг 15 гаруй асуумж үнэлгээний арга судлагдсан байгаа бөгөөд эдгээр тус бүрийн судлан ХСҮТ практикт хамгийн тохиромжтой, хялбар асуумжийг орчуулан, батлуулахаар ажиллаж байна. MST, Patient-led MST, NUTRISCORE, PG-SGA SF, MUST зэрэг үнэлгээний аргууд хамрагдана. - 2024 оны 2-р сард “Тэнцвэртэй хооллолт” сэдвээр сувилагч болон тусгай мэргэжилтнүүдэд 5 дахь өдрийн өглөөний яриан дээр дараах агуулгын хүрээнд сургалт зохион байгуулсан. <ul style="list-style-type: none"> - Шимт бодисын ангилал - Шимт бодисын харьцаа - 6 бүлэг хүнс - Тавгын зарчим - Биеийн жингийн индекс - 2024 оны 3-р сард “ХАВДРЫН ҮЕИЙН ОЛОН МЭРГЭЖИЛТНИЙ СЭРГЭЭН ЗАСАХ ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ” сэдэвт сургалтыг бусад эмнэлгийн эмч, ажилчдад “Хавдрын үеийн хооллолт, шим тэжээлийн үнэлгээ” сэдвээр сургалт зохион байгуулсан. <ul style="list-style-type: none"> - Хорт хавдрын эрсдэлт хүчин зүйл - Эмчилгээний хоол - Хоол шим тэжээлийн менежмент - Шимт бодис тооцох - Илчлэг хувиарлах - Хими эмчилгээний үеийн хооллолт

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
		<ul style="list-style-type: none"> - Зохистой хооллолт, дасгал хөдөлгөөнийг дэмжих замаар таргалалтыг бууруулах “Эрүүл биеээрээ гоёцгооё” аяныг төвийн хэмжээнд зохион байгуулан ажилласан. “Тэнцвэртэй хооллолт” сэдвээр хоол зүйч 2 удаагийн сургалт зохион байгуулсан. Мөн даваа гараг бүр Танита аппарат дээр хэмжилт, үнэлгээ хийсэн, 7 хоног бүр хоолны цэсийг гарган ажилласан. Хэмжилтийн үр дүнгээр 5-8 кг хассан 10 хүн, 3-5 кг хассан 15 хүн, 1-2 кг хассан 5 хүн байна. 21 хоног бүрд биеийн өөх хассан байдал, булчин нэмсэн байдал зэргийг харгалзан 5 ялагч тодруулсан. Оролцогчид өдөр бүрийн хоолны зургаа явуулж хянуулдаг. Мөн шинжилгээний хариунд тулгуурлан нэмэлт зөвлөмж, мэдээлэл өгч ажилласан. - Эрүүл зөв хооллох дадал эзэмших, хэвшүүлэх зорилгоор тус төвийн хоол зүйчийг дараах сургалтууданд тасралтгүй хамруулсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> ✓ 2024 оны 6-р сард WCRF зохион байгуулсан “Эрүүл мэндийн ажилчдад зориулсан хавдраас урьдчилан сэргийлэх” цахим сургалтанд хамрагдсан. ✓ 2024 оны 6-р сард The Nutrition Society/ Шим тэжээл судлалын нийгэмлэгээс зохион байгуулсан “Хавдар-хооллолтын нөлөө” сэдэвт цахим сургалтанд үйлчлүүлэгчийг дэмжих албаны хоол зүйч хамрагдсан. ✓ Олон улсын хавдрын байгууллагаас зохион байгуулсан хавдраас урьдчилан сэргийлэхэд амьдралын хэв маягийн нөлөө талаар цахим сургалтанд 2024 оны 9-р сард үйлчлүүлэгчийг дэмжих албаны хоол зүйч хамрагдсан. - Зохистой хооллолтын талаар гарын авлагыг шинэчлэн, өвчний зовиур бүрт авах арга хэмжээг тайлбарласан гарын авлага боловсруулан, зөвлөгөө тайлбартаа ашигласан. - Үйлчлүүлэгчдэд зохистой хооллолтыг тодорхой болгохын үүднээс зарим нэг үзүүлэнг шинэчлэн, нэмэгдүүлэн өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Мөн сахар ихтэй хүнс, хэрэглэж болох хүнсний сонголтуудыг байршуулан, үйлчлүүлэгч нарт биет үзүүлэн байдлаар бэлтгэсэн. - “Шим тэжээлийн дутагдал”-ыг /Malnutrition/ таниулах Олон улсын өдрийн хүрээнд Хавдрын үеийн шим тэжээлийн дутагдлын талаар мэдээлэл хүргэх лекц, хэлэлцүүлэг өдөрлөг 2024 оны 11-р сарын 14-ний өдөр зохион байгуулсан. Өдөрлөгт Н.Баярмаа, АУ-ны доктор, профессор, АШУҮИС-ийн



№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
		<p>Гепатологи гастроэнтерологийн тэнхимийн багш урилгаар лекц уншсан. Сургалтанд эмч, ажилчид, феллов, резидент эмч нар хамрагдсан.</p> <ul style="list-style-type: none"> - 2024 оны 11-р сард олон улсын шим тэжээлийн дутагдлыг таниулах долоо хоногийн хүрээнд “Шим тэжээл ба хавдар” гарын авлагыг орчуулан (ESPEN) бэлтгэсэн. - Хоол, хүнсний шим тэжээлийн агууламж эмчилгээний хоолны шимт бодисын зохистой харьцааг хүнсний бүлэг тус бүрээр уургийн агууламж, өөх тосны агууламж, нүүрс усны агууламж тайлбарлах сургалтанд тогооч, тасгийн эрхлэгч, эмч, ажилчид нийт 15 ажилтан хамрагдсан.
1.9.	Ээлжийн эмч, ажилтнуудын хоолны цэс, амт чанарын байдалд үнэлгээ хийж, байнга сайжруулан ажиллах	<ul style="list-style-type: none"> - Ээлжийн эмч, ажилтнуудын хоолны цэс, амт чанарын байдалд үнэлгээ хийж, байнга сайжруулан ажиллаж байна. - 2024 онд батлагдсан удирдамжийн дагуу Эмчилгээний хоол шим тэжээлийн тасагт халдварын сэргийлэлт хяналтын албанаас хяналтыг хийсэн. Илэрсэн зөрчил байхгүй. - Нийт 13 төрлийн хоолны дээжийг Стандарт хэмжил зүйн газрын нийслэлийн лаборатори, Махны судалгаа хөгжүүлэлтийн лабораторид тус тус өгч шинжлүүлсэн. - ХСҮТ-ийн гэрээт байгууллага СУ-гийн хоол үйлдвэрлэлийн хэсэгт удирдамжийн дагуу хяналт хийсэн. 38 зөрчил илэрсэн бөгөөд арилгуулахаар албан бичиг хүргүүлсэн. - ХСҮТ-д байрлан ажиллаж байгаа СУ дэлгүүрт сахар ихтэй хүнсний бүтээгдэхүүн буюу 100гр-д 22.5гр их сахар агуулсан хүнсний бүтээгдэхүүн худалдаалахгүй байх шаардлагыг 2024 оны 9-р сард хүргүүлсэн. Шаардлагыг хариуг 11-р сард авч дараагийн уулзалт төлөвлөгдөж байна. - 2024 оны 10 дугаар сард СУ-дэх ажилчдын сэт хоолны сэтгэл ханамжийн үнэлгээг хийж, зохих шаардлагыг хүргүүлсэн. Нийт 169 эмч, ажилчид (Нийт сэтгэл ханамж 2.5 оноо) хамрагдсан. (1-5 хэмжүүрт оноо) Сайжруулах шаардлагатай зүйлс: хооллох орчинг сайжруулах, бүхэл үр хүнсний ногооны хэмжээг нэмэгдүүлэх, хоолны тослогийг багасгах, порцыг нэмэгдүүлэх, олон төрлийн хачир саладтай болох гэсэн байна. Эдгээр шаардлагыг СУ гал тогоонд хүргүүлж ажилласан.
1.10.	Ажлын байрны дасгал хөдөлгөөн хийх орчин нөхцлийг бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> - “Эрүүл биеээрээ гоёцгооё” аяныг төвийн хэмжээнд зохион байгуулан ажилласан. Аяны хүрээнд олон цагаар суугаа болон зогсоо ажил, хөдөлмөр эрхэлдэг эмч, ажилтнуудад Сэргээн засах тасгаас гурван сарын аяны хүрээнд дасгал хөтөлбөрийн дагуу хөдөлгөөн засалчаар заалгуулах ажлыг 2024.03.15-с 2024.06.15 хүртэлх хугацаанд зохион байгуулсан. Нийт тасаг, албадаас 30 эмч, ажилчид оролцсон бөгөөд сэргээн засах тасгаас зохион байгуулсан дасгал хөтөлбөрт давтагдсан тоогоор 80-д удаа хамрагдсан байна. - Ажлын байрны дасгал хөдөлгөөн, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төвийн сэргээн засах тасгийн өрөөнд тохижуулалт хийсэн. Тус өрөөний ханыг засварлан, шаланд

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
		<p>зориулалтын зөөлөвчтэй авагддаг гудас, дасгал хөдөлгөөн дагаж хийхэд зориулсан дэлгэц, 1 гүйлтийн замыг авч тохижуулалт хийгдсэн.</p> <ul style="list-style-type: none"> - Олон цагаар суудлын ажил, хөдөлмөр эрхэлдэг захиргааны хэсгийн эмч, ажилтнуудад сэргээн засах тасгийн хөдөлгөөн засалчаар “Ажлын байрны дасгал хөдөлгөөн”-ийг заалгуулах ажлыг зохион байгуулсан. Үүний дагуу үргэлжлүүлэн өөрсдөө ээлжлэн хуваарь гаргаж өдөр болгон тодорхой цагт “Ажлын байрны дасгал хөдөлгөөн” хийж хэвшсэн. - Сэргээн засах тасагт 2024.11 дүгээр сарын байдлаар нийт 178 эмч, ажилчид давтагдсан тоогоор 867 удаа сэргээн засах эмчилгээнд хамрагдсан байна. Сэргээн засах эмчилгээнд хамрагдсан ажилтнуудыг ажил мэргэжлээр авч үзвэл эмч 32.5%, сувилагч 24.1%, бусад ажилтан 43.2% хамрагдсан бөгөөд насны бүтцээр авч үзвэл эмчилгээнд хамрагдагсдын 42% нь 41-50 нас, 37% нь 50-аас дээш насны эмч, ажилчид байна. Оношийн бүлгээр авч үзвэл 49,1% нь нуруу, 19,2% нь хүзүүний эмгэгтэй эмч, ажилчид сэргээн засах тасагт эмчилгээнд хамрагдаж сэргээн засахын эмч, хөдөлгөөн засалчийн зөвлөгөө өгсөн байна. - 2024 оны 04-р сард төвийн нийт эмч, ажилтнуудын дунд Байгууллагын аварга шалгаруулах спортын 5-н төрөлт тэмцээнийг зохион байгуулан аварга тамирчдаа шалгаруулсан. - 2024 оны 06-р сард Нийслэлийн биеийн тамир спортын газар, Нийслэлийн засаг даргын тамгын газар болон Монголын хэт холын марафон гүйлтийн холбоотой хамтран уламжлал болгон зохион байгуулдаг VIII дахь удаагийн "Улаанбаатар марафон - 2024" олон улсын гүйлтийн тэмцээний сонирхогчдын төрөлд төвийн эмч, ажилтнууд идэвхтэй хамрагдсан.
2. Эрүүл, аюулгүй ажлын байр бүрдүүлэх		
2.1.	В гепатитын эсрэг вакцинд хамруулан дархлаажуулалт тогтсон эсэхийг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> - Товлолт В гепатитын эсрэг дархлаажуулалтын сэргээх тунд <ul style="list-style-type: none"> - 1-р тун – 2 ажилтан - 2-р тун - 1 ажилтан - 3-р тун - 26 ажилтныг тус тус хамруулсан. - Нийт ажилчдын дархлал тогтоц 100 mIU/ml дээш 458 ажилтан буюу 87% дархлаатай байна. - 2024 онд нийт 73 ажилтан шинээр ажилд орсон бөгөөд үүнээс В вирусийн дархлаажуулалтанд <ul style="list-style-type: none"> - 1 тун - 49 ажилтан - 2 тун – 5 ажилтан - 3 тун - 19 ажилтан тус тус хамрагдсан байна.
2.2.	Элэгний В, С вирус илэрсэн ажилтнуудад	Элэгний В, С вирус илэрсэн ажилтнуудыг гепатологич /элэгний/ эмчийн хяналтанд байдаг бөгөөд жил бүр ВС вирусийн идэвжлийг тодорхойлох шинжилгээнд хамрагддаг.

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
	идэвхжлийн шинжилгээг жил тутамд хоёр удаа хийж хянах	
2.3.	Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөл, хөдөлмөрийн чадвар түр алдалт, ажлын байран дах стресс, мэргэжлээс шалтгаалсан өвчний судалгаа хийж, мэдээллийн нэгдсэн сантай болох, дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> - Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дугаар тушаалын 3 дахь заалтын дагуу төвийн захирлын 2018 оны А/23 дугаар тушаалаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийг 11-н хүний бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулж байна. - 2024 оны нийт ажилтны эрүүл мэндийн үзлэгийн мэдээлэл, эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг цахимжуулж мэдээллийн санг цаасан болон цахим халбэрээр үүсгэсэн. - Ажлын байран дээр хурц үзүүртэй, иртэй зүйлд өртсөн тохиолдол бүрийг Халдварын сэргийлэлт хяналтын албанд бүртгэн ажиллаж байна. - Өртөлтийн дараах анхны цомог, биошингэн асгарсан тохиолдолд халдваргүйжүүлэн, цэвэрлэх цомгыг тасаг бүрт бэлтгэн тавьж шаардлагатай тохиолдолд хэрэглэж байна. Иж бүрдлийн хангалт 100 хувь. Нийт 21 тасаг нэгжийг хангасан. Иж бүрдлийн талаарх мэдлэгийг үнэлэхэд эмч 95.5%, сувилагч 76.5%, үйлчлэгч 75.4% байв. Сургалтыг нийт 120 эмч, 158 сувилагч, тусгай мэргэжилтэн, 44 үйлчлэгч, 30 резидент феллов нарт зохион байгуулсан. Шинэ ажилтнуудыг гепатит В вирусийн эсрэг вакцинаар дархлаажуулж ажилд нь оруулж байна. 2024 оны 10-р сарын байдлаар зүүнд хатгуулсан 13 тохиолдол бүртгэгдсэн. Өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг шуурхай авч дархлал тогтоцыг үзэж дархлаажуулсан бөгөөд зохих зөвлөмжийг шуурхай өгч ажиллаж байна. - 2024 онд ажлын байрны осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөл 1 бүртгэгдсэн болно. - Мөн ханиад томуунаас урьдчилан сэргийлэх зорилгоор томуугийн улиралд нийт эмч, ажилтнуудад ажлын өдөр бүр 250 мл үнэ төлбөргүй аарц, жимсний шүүс олгож дархлаажуулалт хийж ажиллаж байна. - Байгууллагын шинэ ажилтаныг чиглүүлэх сургалтын хөтөлбөрийн дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн урьдчилсан, анхан болон давтан зааварчилгыг тухай бүрд нь өгч ажилласан. Ажилд орсон тухай бүрд нь халдвар хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг хүргэж, үнэлгээг хийж байна. Халдварын сэргийлэлт, хяналтын алба шинээр ажилд орсон эмч, ажилтаныг дагалдуулан суралцуулах хөтөлбөрийг батлуулж, ерөнхий 3, онолын 13, дадлага 6 чиглэлээр тус тус эмч болон бусад ажилтан төрлөөр ангилан дадлагажуулж, үнэлгээ хийж ажилладаг. Чиглүүлэх



№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
		<p>сургалтын хөтөлбөрийн дагуу сар бүр нэгдсэн онолын болон дадлага сургалтыг шинээр ажилд орж буй ажилтнуудыг хамруулан зохион байгуулан ажилладаг. 2024 оны эхний 11 сарын байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> - 1 дүгээр сар 2 - 2 дугаар сар 5 - 3 дугаар сар 4 - 4 дүгээр сард 5 - 5 дугаар сард 6 - 6 дугаар сард 10 - 7 дугаар сард 8 - 8 дугаар сард 16 - 9 дүгээр сард 9 - 10 дугаар сард 2 - 11 дүгээр сард 4 эмч, ажилтан хамрагдаад байна. <ul style="list-style-type: none"> - Сэтгэцийн эрүүл мэндийн дэлхийн өдөрт зориулж эмнэлгийн ажилчдад зориулан “ажлын байран сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалъя” гэсэн стэнд бэлдсэн. - ДЭМБ-аас жил бүрийн 10-р сарын 10-ыг “Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах Дэлхийн өдөр” хэмээн зарласан. Энэ жил энэхүү өдрийг “Ажлын байранд сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалъя” уриан дор тэмдэглэж байна. Ажлын байранд гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах, дарамт шахалт болон хөдөлмөрийн муу нөхцөл байдал нь ажилтны сэтгэцийн эрүүл мэнд, ажлын бүтээмж, амьдралын чанарт сөргөөр нөлөөлж бүйг ДЭМБ-аас онцлон анхааруулжээ. Тиймээс энэхүү өдрийн хүрээнд эмнэлгийн ажилчдын дунд урлаг заслын сургалт ыг зохион байгуулсан. - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалтыг 2024 оны 6 дугаар сард зохион байгуулсан. “Нийгмийн даатгалын тухай багц хууль”-иар Х.Булгантуяа (ХНХЯ-ны сайд), “ХАБЭА-н хууль эрх зүйн ойлголтыг өгөх, аюулгүй ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлээс эрүүл мэндээ хамгаалах, үйлдвэрлэлийн осол, судлан бүртгэх” сэдвээр Н.Нандин (АШУҮИСургуулийн багш, сургагч багш, ХНХЯ-ХАБЭА-н үндэсний хорооны гишүүн) сургалт орсон. Нийт 94 эмч, ажилтан оролцсон байна. Сургалтанд оролцсон ажилтнуудаас 2 төрлийн судалгаа, асуумж авсан,




№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
		<ul style="list-style-type: none"> - ХСҮТ-ийн ажилчдад зориулсан ажлын байрны стрессийг бууруулах, бусдын асуудал, зовлонг ойлгож мэдрэх чадвар, анхаарал төвлөрлийг сайжруулах талаар мэдлэг олгох, эерэг хандлага төлөвшүүлэх сургалтыг Дилав хутагт сантай хамтран “Танин мэдэхүйд суурилсан энэрэх сэтгэлийг хөгжүүлэх нь” (СВСТ) сэдэвт 8 модуль цуврал сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. - “Гепатиттай тэмцэх дэлхийн өдөр”-ийг 2024.08.02-ний өдөр зохион байгуулсан. Тус үйл ажиллагааг Халдвар хяналт, сэргийлэлтийн алба, Үйлчлүүлэгчийг дэмжих алба, Хими эмчилгээний тасаг, Элэг цөс нойр булчирхайн мэс заслын тасаг хамтран зохион байгууллаа. Өдөрлөгөөр Гепатит В болон С вирусийн тухай ойлголт, дамжих зам, урьдчилан сэргийлэлт, Гепатит В вирусийн эсрэг дархлаажуулалт зэрэг мэдээллийг ажилчид болон иргэд өгч ажилласан. Мөн халдвар хамгааллын дэглэм баримтлан гепатит В, С вирус илрүүлэх түргэвчилсэн оношлуураар нийт 50 хүнийг хамруулан, зөвлөгөө өгсөн. Гепатит В болон С вирусийн тухай ойлголт, дамжих зам, урьдчилан сэргийлэлт, Гепатит В вирусийн эсрэг дархлаажуулалт, халдвараас сэргийлэх хяналтын арга хэмжээний талаар нийт 5 төрлийн зурагт хуудас, зөвлөмж материал 200 ширхэгийг тараасан. - Дэлхий дахинд тамхигүй өдрийг жил бүрийн 5 дугаар сарын 31-нд тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ жил "Тамхи үйлдвэрлэлийн хөндлөнгийн оролцооноос хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалцгаая" уриан дор тэмдэглэхийг уриалж байгаа бөгөөд Монгол улс энэхүү уриалгыг бүрэн дүүрэн дэмжиж, тамхи үйлдвэрлэгчид эрүүл мэндийн бодлогод хөндлөнгөөс оролцохыг зогсоох, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, платформоор утаат болон электрон тамхи зэрэг аюултай бүтээгдэхүүнүүдийг тасралтгүй сурталчилж байгааг болиулах, үхлийн аюултай бүтээгдэхүүнээс хүүхэд залуучуудаа хамгаалах, эрүүл мэндийн байгууллага, тамхигүй орчны манлайлагч байхыг уриалж "ХУДЛАА ЯРИХАА ЗОГСОО" аяныг эхлүүлэн ажилласан. Тамхины шалтгаант өвчнийг эмчилдэг байгууллагын хувьд хамт олноо "ТАМХИГҮЙ ХАМТ ОЛОН" болох хөдөлгөөнийг нэгдэн ажилчдын дундах тамхидалтын талаарх судалгааг онлайн хэлбэрээр авсан.
2.4.	Төвийн хэмжээнд ундны усны хангалтанд хяналт үнэлгээ хийж, шаардлагатай газруудад ус шүүгч байрлуулан, ундны усны цэвэр аюулгүй байдалд хэмжилт хийлгэх	<ul style="list-style-type: none"> - Төвийн хэмжээнд ундны усны хангалтанд хяналт үнэлгээ хийж, ундны усны цэвэр аюулгүй байдлын хэмжилтийг 2024 оны 8 дугаар сарын 13-нд Стандарт хэмжил зүйн газраар хийлгэж нийслэлийн лабораторт ундны усны шинжилгээ өгсөн. Шинжилгээгээр эмгэг төрөгч илрээгүй. - Төвийн хэмжээнд ундны усны ус шүүгчээс эрүүл зүйн шинжилгээ болох арчдасны шинжилгээг авдаг бөгөөд илэрсэн зөрчил байхгүй. - Шаардлагатай газруудад 2 ус шүүгчийг байрлуулсан.

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
2.5.	Эрүүл амьдралын хэв маягыг дэмжсэн үйл ажиллагааг дэмжсэн аянг өрнүүлж, хамгийн сайн туршлага нэвтрүүлж, үйл ажиллагааг тогтмолжсон тасаг, алба хамт олныг шалгаруулах	<ul style="list-style-type: none"> - Сэргээн засах тасаг, Эмчилгээний хоол, шим тэжээлийн тасаг, Дотоод шүүрлийн эмч болон Хүний нөөц хөгжлийн албанаас санаачлан зохион байгуулсан “ЭРҮҮЛ БИЕЭРЭЭ ГОЁЦГООЁ” хөтөлбөр 11 долоо хоног явагдаж амжилттай өндөрлөсөн. Энэхүү хөтөлбөрийн онцлог дотоод шүүрлийн эмч, хоол зүйч болон хөдөлгөөн засал гээд олон мэргэжлийн багаараа эрүүл амттай өдрийн хоол, дасгал хөдөлгөөн хийх нөхцөлөөр хангаж эрүүл зан үйлээр байнгын дэмжлэг үзүүлж, хянах замаар булчингаа алдахгүйгээр өөхний масс багасгах оршсон. Хөтөлбөрт оролцогчдыг сонгохдоо ХСҮТ-ийн нийт ажилчдын группэд Google from-оор оролцох хүсэлтэй байгаа ажилчдад нээлттэй зар тавин нийт 56 ажилтнаас 30 оролцогчийг сонгон авсан. Тэдгээр ажилтнууд 11 долоо хоногийн хугацаанд нийт 165,9 кг, бэлхүүсний тойргоосоо 259,9 см хассан, цусны үзүүлэлтүүд сайжирсан үр дүнтэйгээр хөтөлбөрөө дуусгасан. Энэхүү хөтөлбөрийг дэмжиж оролцсон тасаг, албадууд: <ul style="list-style-type: none"> 1. Сэргээн засах тасаг 2. Эмчилгээний хоол, шим тэжээлийн тасаг 3. Үйлчлүүлэгчийг дэмжих алба 4. Хүний нөөц, хөгжлийн алба 5. ТХМП нөхөн сэргээх мэс заслын тасаг (Дотоод шүүрлийн эмч)
2.6.	Хорт зуршилгүй орчин бүрдүүлэх	<ul style="list-style-type: none"> - Төвийн хөдөлмөрийн дотоод журмыг баримтлан ажиллаж байгаа ба 2024 оны байдлаар архи, согтууруулах ундаа, тамхины тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй, уг зөрчлөөр ажилтнуудад арга хэмжээ авагдаагүй болно. - Төвийн хэмжээнд шинээр ажилд орж буй ажилтнуудад архи согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох талаарх төвийн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээний зүйл заалтыг тусгайлан танилцуулж хэвшсэн. - Мөн төвд хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгчдэд архи согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох тухай мэдээллийг холбогдох мэргэжилтнүүд танилцуулж хэвшсэн. - Дэлхий дахинд тамхигүй өдрийг жил бүрийн 5 дугаар сарын 31-нд тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ жил "Тамхи үйлдвэрлэлийн хөндлөнгийн оролцооноос хүүхэд, өсвөр үеийнхнийг хамгаалцгаая" уриан дор тэмдэглэхийг уриалж байгаа бөгөөд Монгол улс энэхүү уриалгыг бүрэн дүүрэн дэмжиж, тамхи үйлдвэрлэгчид эрүүл мэндийн бодлогод хөндлөнгөөс оролцохыг зогсоох, олон нийтийн мэдээллийн






№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
		хэрэгсэл, платформоор утаат болон электрон тамхи зэрэг аюултай бүтээгдэхүүнүүдийг тасралтгүй сурталчилж байгааг болиулах, үхлийн аюултай бүтээгдэхүүнээс хүүхэд залуучуудаа хамгаалах, эрүүл мэндийн байгууллага-тамхигүй орчны манлайлагч байхыг уриалж "ХУДЛАА ЯРИХАА ЗОГСОО" аяныг эхлүүлж байгаа билээ. Тамхины шалтгаант өвчнийг эмчилдэг байгууллагын хувьд хамт олноо "ТАМХИГҮЙ ХАМТ ОЛОН" болох хөдөлгөөнийг нэгдэн дэмжиж ажилласан.
2.7.	Ажлын ачаалал өндөртэй ажлын байранд ажиллаж буй эмч, ажилтнуудад зориулан алжаал тайлах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> - Ажлын ачаалал өндөртэй ажлын байранд ажиллаж буй эмч, ажилтнуудад зориулан алжаал тайлах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр ажиллаж байна. - 2024 оны 11 сарын байдлаар нийт 178 эмч, ажилчид буюу давтагдсан тоогоор 867 удаа сэргээн засах эмчилгээнд хамрагдсан байна. Сэргээн засах эмчилгээнд эмч 32.5%, сувилагч 24.1%, бусад ажилтан 43.2% хамрагдсан бөгөөд эмчилгээнд хамрагдагсдын 42% нь 41-50 нас, 37% нь 50-аас дээш насны эмч, ажилчид байна. Оношийн бүлгээр авч үзвэл 49,1% нь нуруу, 19,2% нь хүзүүны өвчлөлтэй эмч, ажилчид сэргээн засах тасагт эмчилгээнд хамрагдаж эмч, хөдөлгөөн засалчийн зөвөлгөө өгсөн байна. - Төвийн өргөтгөлийн хөгжим эмчилгээний хэсэгт долоо хоног бүрийн лхагва гариг бүр ажилчдын үдийн завсарлагааны цагаар хөгжим эмчилгээ хийж хэвшсэн. 2024 онд 40 удаа хийсэн байна.
2.8.	Стрес, бухимдлыг бууруулах зорилгоор бясалгал, лекц зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Сэтгэцийн эрүүл мэндийн дэлхийн өдрийн хүрээнд эмнэлгийн ажилчдад зориулан “Ажлын байран сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалъя” сэдэвт мэдээлэл хүргэж ажилласан. - ХСҮТ-ийн ажилчдад зориулсан ажлын байрны стрессийг бууруулах, бусдын асуудал, зовлонг ойлгож мэдрэх чадвар, анхаарал төвлөрлийг сайжруулах талаар мэдлэг олгох, эерэг хандлага төлөвшүүлэх сургалтыг Дилав хутагт сантай хамтран “Танин мэдэхүйд суурилсан энэрэх сэтгэлийг хөгжүүлэх нь” (СВСТ) сэдэвт 8 модуль цуврал сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. - 2024 оны 05 сард төвийн Байгууламжийн менежмент аюулгүй байдлын албаны ажилтнууд, цэвэрлэгээ халдваргүйтгэлийн багийн 52 ажилтанд “Стресс уур бухимдлаа удирдах” сургалт (СЭМҮТ-н эмч Г.Гантулга) явуулсан. <div data-bbox="752 1150 1910 1367" style="text-align: center;"> </div>

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
2.9.	Ажилтнуудад зориулсан “Өөрийгөө хайрлах өдөр” өдөрлөгийг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - ХСҮТ-ийн ажилчдад зориулсан ажлын байрны стрессийг бууруулах, бусдын асуудал, зовлонг ойлгож мэдрэх чадвар, анхаарал төвлөрлийг сайжруулах талаар “Өөрийгөө таних чадварыг сайжруулах”, “Өөрийгөө танин мэдэх”, “Өөрийгөө хайрлах” сэдвээр сургалтыг зохион байгуулан ажиллаж байна. - Тус төвд ажиллаж буй эрэгтэй ажилтнуудад зориулан 2024 оны 05 сард “Эрэгтэй ажилтны өдөрлөг” зохион байгуулсан. Төвийн хэмжээнд 101 эрэгтэй ажилтан ажиллаж байгаа бөгөөд эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд 99% нь хамрагдсан. Өдөрлөгийн хүрээнд эрэгтэй ажилтны дунд эрүүл мэндийн үзлэгээр илэрсэн зонхилон тохиолдож байгаа эмгэгүүдээс хэрхэн сэргийлэх, эмчлэх, хянах талаар сургалт явуулсан. - “Аз жаргалтай ажилтан” хөтөлбөрийн хүрээнд 2024 онд төвийн ажилчдын дунд зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчнөөс хэрхэн сэргийлэх, цаашдын хүндрэлийг хянах, ажлын байран дээрээ өөрийн эрүүл мэндээ хэрхэн хянах талаар Сувилахуй албатай хамтран санамж, өөрийгөө хянах хуудас гаргаж тасгуудад байрлуулсан. Уг санамж зөвлөмжийг нийт эмч, сувилагчдын яриан дээр танилцуулсан. 
2.10.	Ажилтнуудын ажлын байрны орчинг сайжруулан, өрөө тасалгаанд засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийж гүйцэтгэх	<p>Ажилтнуудын ажлын байрны орчинг сайжруулан, өрөө тасалгаанд засвар үйлчилгээг хуваарийн дагуу хийж гүйцэтгэн ажиллаж байна.</p> <ul style="list-style-type: none"> - Лабораторийн тасагт их засварын ажил. Үүнд: Агааржуулалтын системийн засварлах, Агааржуулагч /АС/ 2 ширхэг шинээр суурилуулах - Өргөтгөлийн барилгын цахилгааны хаалттай дэд өртөөнд /ABP/ автомат сэлгэн залгуур суулгах - Төвийн угаалгын хэсгийн засвар, үйлчилгээ - Элэг цөс, нойр булчирхайн мэс заслын тасгийн, мэс заслын өрөөний агааржуулалтын засварын ажил - Төвийн ариун цэврийн өрөөнүүдийн их засварын ажил - Төвийн гал тогооны таазны засвар үйлчилгээ - Туяаны тасгийн В блокын их засварын ажил, /Элэг шилжүүлэн суулгах баг/ - Өргөтгөлийн барилгын ЦТП ялтсан бойлер солих, засвар үйлчилгээ - Төвийн халаах хэрэгслүүд, /радиатор/ босоо шугамыг иж бүрэн шинэчлэх их засварын ажил - Төвийн дулаан хангамжийн салбарласан 60 метр шугамыг шинэчлэх ажил - В1 давхрын бялдаржуулах өрөө засварлах - Галын цэгүүдийн иж бүрдэл, тохижилтын ажил
2.11.	Ажилтнуудын ажлын байрны аюулгүй орчин	<p>Ажилтнуудын ажлын байрны аюулгүй орчин (гэрэлтүүлэг, дулаан, цахилгаан, дуу чимээ, агааржуулалт г.м)-г хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:</p>

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
	(гэрэлтүүлэг, дулаан, цахилгаан, дуу чимээ, агааржуулалт г.м)-г хангахад чиглэгдсэн үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Төвийн халаах хэрэгслүүд, /радиатор/ босоо шугамыг иж бүрэн шинэчлэх их засварын ажил - Эм зүйн албаны нөөцийн хэсэгт засварын ажил хийж гэрэлтүүлгийг сайжруулсан - Санхүү эдийн засгийн албаны өрөөнд засварын ажил хийж гэрэлтүүлгийг сайжруулсан - Ерөнхий мэс заслын тасгийн коридорын хэсгийн гэрэлтүүлгийг сайжруулсан - Элэг цөс, нойр булчирхайн мэс заслын тасгийн эмч нарын өрөөнд засвар үйлчилгээ хийж гэрэлтүүлгийг сайжруулсан
3. Дэмжлэгт орчныг бий болгох		
3.1.	Байгууллагын ажилтнуудыг спортоор хичээллэхэд нь дэмжих үйл ажиллагаанууд зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Ажлын байрны дасгал хөдөлгөөн, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр төвийн сэргээн засах тасгийн өрөөнд тохижуулалт хийсэн. - Хавдар судлалын төвийн захиргаа байгууллагын ажилтнуудыг эрүүл мэнд, эрүүл спортлог харилцаанд эерэг нөлөө үзүүлж биеийн тамираар хичээллэх шаардлага хангасан спорт залаар хангах, дэмжих үйл ажиллагааны дэмжин ажилладаг. Иймээс Баянзүрх дүүрэгт байрлах Чухаг спорт зааланд долоо хоног бүрийн Пүрэв гарагт тодорхой хуваарийн дагуу дуртай спортоор хичээлэх боломжоор хангах ажлуудыг зохион байгуулан ажилладаг. - Цэргийн төв эмнэлгийн Мэс заслын тасаг хогжсөний 100-н жилийн ойд зориулсан 5 төрөлт тэмцээнд багаараа амжилттай оролцох нөхцөл бололцоогоор хангасан. Волейболын эмэгтэй баг Мөнгөн медаль, Багийн ахлагч шилдэг тоглогч, Сагсны эмэгтэй баг Хүрэл медаль, Теннисны эрэгтэй төрөлд Хүрэл медаль тус тус авсан. - Ширээний теннисний ахмадын улсын аварга шалгаруулах тэмцээний 50-59 насны төрөлд Байгууламжийн менежмент, аюулгүй байдлын албаны дарга, спортын дэд мастер Б.Алтанням амжилттай оролцон хүрэл медаль авсан. - Төвийн ажилтнуудын дунд “Hiking therapy” эмнэлгийн ажилчдын эрүүл мэнд болон сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор 2024 оны 9 дүгээр сараас эхлэн явган алхалтыг сард 2 удаа бямба гарагт зохион байгуулан ажиллаж байна. - Олон цагаар суугаа болон зогсоо ажил, хөдөлмөр эрхэлдэг эмч, ажилтнуудад Сэргээн засах тасгаас дасгал хөтөлбөрийн дагуу хөдөлгөөн



№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
		<p>засалчаар ажлын байранд хийж болох дасгал хөдөлгөөний талаар 2 удаагийн сургалт хийгдсэн байна.</p>
3.2.	<p>Байгууллагын спортын арга хэмжээнд оролцох ажилчдын бэртэл бэртлээс урьдчилан сэргийлэх заавар өгөх</p>	<ul style="list-style-type: none"> - Спортын арга хэмжээнд оролцох эмч, эмнэлгийн ажилчидад зориулан тэмцээний өмнө үе хамтгаалаас, гэмтэлээс сэргийлэх tape, боолт хийх арга аргачлалын заавар, зөвлөгөө өгч шаардлагатай тохиолдолд хуучин гэмтэж байсан үеийг хамгаалах уян наалт наах зэрэг арга хэмжээнүүдийг авч ажиллаж байна. <div style="display: flex; justify-content: space-around; align-items: center;">    </div>
3.3.	<p>Чанартай хувийн хамгаалах (ариун болон нэг удаагийн бээлий, маск, нүдний шил, битүү гутал) хувцас хэрэгслэлээр хангах</p>	<ul style="list-style-type: none"> - Төвийн ерөнхий захирлын 2020 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн №А/54 тоот тушаалаар Ажилтнуудын дүрэмт хувцасны стандартыг шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна. Ажлын хувцасны жагсаалтын дагуу жил бүр нормын хувцасыг нийт ажилтнуудад олгож ажилладаг. - 2024 онд ажлын хувцасны стандартын дагуу эмнэлгийн халад 605 ширхэг, инженер техник ажилчдын гутал 80 ширхэг, сувилагч ажлын гутал 110 ширхэг, эмч ажлын гутал 350, ажлын өмд, цамц 150 ширхэг, эмнэлгийн цамц 405 ширхэг зэргийг ажилтнуудад тус тус олгосон байна. Уг ажлуудыг хийж гүйцэтгэхэд 158 гаруй сая төгрөгийн зардлыг төсвийн санхүүжилтээс гарган ажилласан. - Төв нь өөрийн угаалгын хэсэгтэй ба нийт эмч, ажилтнуудын ажлын хувцасыг дотооддоо цэвэрлэгээ үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэдэг. - Эмч, ажилтнуудад ажлын байранд дараах хамгаалах хэрэгслийг олгосон. Үүнд: - Эмч, сувилагч нарт 1 удаагийн амны хаалт, бээлий, малгай, халад, гар халдваргүйтгэлийн бодис, гарын шингэн саван, гар арчих 1 удаагийн зориулалтын цаас, шаардлагатай тохиолдолд N 95 маск, - Био шингэн, химийн бодис үсэрч болзошгүй ажлын байранд ажиллаж буй ажилтнуудад хамгаалалтын нүдний шил,

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Биелэлт
		<ul style="list-style-type: none"> - Цацрагийн нөлөөтэй ажлын байранд ажиллаж буй ажилтнуудад хамгаалалтын тугалган иж бүрэн хувцас, дозиметр, - Нийт үйлчлэгч нарт ахуйн хэрэглээний зузаан нимгэн бээлий, цонх угаах үед хамгаалалтын бүс, 00-ын үйлчлэгч нарт нүдний шил, 1 удаагийн малгай, маск, халад, - Инженер техникийн ажилтнуудад ажлын хувцас, хамгаалалтын багаж хэрэгсэл, - Нэгдсэн лабораторийн тасгийн эд, эсийн лабораторийг ламинар бокс, биопси авах ширээ, эд боловсруулах аппарат зэрэг битүүмжлэл бүхий тоног төхөөрөмжөөр хангасан, - Химийн эм найруулагч, эм зүйч нарт зориулалтын тусгай хамгаалалт бүхий комбинзон, малгай, бээлий, амны хаалт, зэрэг хамгаалах хэрэгсэл олгодог ба тусгайлан гаргасан өрөөнд ламинарбоксд найруулж байна.

**ХСҮТ-ийн Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны
2024 оны үйл ажиллагааны жилийн тайлан**

2024 оны 12 дүгээр сарын 4

№	Хэрэг-жүүлсэн үйл ажиллагаа	Биелэлт			Зарцуулсан төсөв, эх үүсвэр
1.	Хуралдаан	2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр	Хорооны 2024 оны төлөвлөгөө хэлэлцэх тухай	1.ХСҮТ-ийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2024 оны төлөвлөгөөнд хурлаас гарсан саналуудаа нэгтгэн эргэн танилцуулан эцэслэн ёс зүйн салбар хорооны даргаар батлуулахыг нарийн бичгийн дарга П.Мөнхзулд даалгахаар шийдвэрлэв.	-
		2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр	1. Эм зүйч О.Анударь, Б.Гантуяа, Б.Ганбаяр нарын гомдлыг шийдвэрлэх тухай	1.Ажилтнуудын гомдолтой холбоотой эм зүйн албаны эм зүйч Лувсанбалдан овогтой Гансүвдыг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/406 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм”-ийн 6.1, 8.9 дахь заалтуудыг зөрчсөн тул захиргаанд хүргүүлэхээр, 2.Илэрсэн зөрчилтэй холбогдуулан эм зүйн албаны эм зүйч нарын эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлага, хамт олныг нэгтгэх, багаар ажиллах чиглэлээр сургалтын төлөвлөгөө гарган батлуулж, сургалт үйл ажиллагааг зохион байгуулан 2024 оны 06 дугаар сарын 28-ны дотор багтаан ёс зүйн салбар хороонд эргэн мэдээлж, тайлагнахыг эм зүйн албаны дарга С.Отгонбилэгт үүрэг болгохоор, 3.Эм зүйн албанд зохион байгуулсан сургалтын үйл явцад хяналт тавьж, тайланг төвийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны хуралд танилцуулахыг ёс зүйн салбар хорооны орлогч дарга Л.Энхээ, Ч.Аззаяа нарт даалгахаар тус тус шийдвэрлэв.	-
		2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр	1. Үйлчлэгч Б.Пүрэвсүрэнгийн гомдлыг шийдвэрлэх тухай	1.Байгууламжийн менежмент, аюулгүй байдлын албаны цэвэрлэгээ, халдваргүйжүүлийн багийн зохион байгуулагч Дорж овогтой Хоролсүрэн, Байгууламжийн менежмент,	-

				<p>аюулгүй байдлын албаны цэвэрлэгээ, халдваргүйжүүлийн багийн үйлчлэгч Баяраа овогтой Пүрэвсүрэн нар нь Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэмжээг зөрчсөн тул захиргаанд хүргүүлэхээр,</p> <p>2.Зохион байгуулагч Д.Хоролсүрэн, үйлчлэгч Б.Пүрэвсүрэн нарыг ёс зүйн сургалтанд хамруулахыг саналыг Хавдар судлалын үндэсний төвийн захиргаанд хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.</p>		
		2024 оны 09-р сарын 18-ны өдөр	1.Ёс зүйн эрсдлийн үнэлгээ хийх тухай	1.Тус хорооны 2024 оны төлөвлөгөөний дагуу эмч, мэргэжилтнүүдийн дунд ёс зүйн эрсдлийн үнэлгээг эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн тулгуур зарчимаар хийж, Ёс зүйн асуудлууд эрдэм шинжилгээний хуралд оролцохоор шийдвэрлэв.		-
		2024 оны 09-р сарын 24-ний өдөр	2.Эм зүйн Б.Ганбаярын гомдлыг шийдвэрлэх тухай	2.Хавдар судлалын үндэсний төвийн Эм зүйн албаны эм зүйч Батнасан овогтой Ганбаярын гаргасан өргөдлийг тус хорооны гишүүн Л.Энхээ, С.Эрдэнэчимэг нарын илтгэх хуудас, саналыг үндэслэн хэрэгсэхгүй болгосугай.		-
				3.Хавдар судлалын үндэсний төвийн Эм албаны эм зүйч Б.Ганбаярын тус хороонд гаргасан өргөдлийг судлан шийдвэрлэхэд ажил үүргийн хуваарлалт тодорхой бус байдал, сахилга хариуцлага алдсан нөхцөл байдал үүссэн байж болзошгүй байдлыг харгалзан хорооны гишүүдийн саналаар Хавдар судлалын үндэсний төвийн захиргаанд зөвлөмж хүргүүлсүгэй.		-
		2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр	1.2024 оны үйл ажиллагааны тайлан хэлэлцэх тухай	1.ХСҮТ-ийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны 2024 оны үйл ажиллагааны тайланг нэгтгэхийг нарийн бичгийн дарга П.Мөнхзулд даалгахаар шийдвэрлэв		-
2	Ёс зүйн сургалтанд хамрагдсан хүний тоо	Эмч	Эмнэлгийн мэргэжилтэн	Эмнэлгийн бусад мэргэжилтэн	Иргэд үйлчлүүлэгч	-
3	Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургалт	Төвийн хэмжээнд 2024 оны турш 7 хоног бүр шинээр ажил орсон болон урт хугацааны чөлөөнөөс ажилдаа эргэн орсон эмч, эмнэлгийн ажилтнуудад				-
		<ul style="list-style-type: none"> - Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, - Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, - Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль - Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9-н зүйл, - Эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцааны хэм хэмжээний удирдамж, 				

		- Үйлчлүүлэгчтэй харилцах арга зүй гэсэн сэдвүүдээс тухай бүрд нь сурталчилан, таниулах, сургалтын ажлыг зохион байгуулсан.			
		14	52	26	-
		"Монголын уламжлалт анагаах ухаанд мөрдөж ирсэн мэргэжлийн ёс зүй" сэдвээр Анагаах ухааны доктор, профессор, МУ-ын Хүний гавъяат эмч, АШУҮИС-ийн профессор багш С.Сээсрэгдорж 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдөр төвийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд (сувилагч, эм зүйч, эм найруулагч, техникч, лаборант, хөдөлгөөн засалч, бага эмч, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүд г.м)-д сургалт хийсэн. Сургалтанд 313 ажилтан хамрагдсан.			350.0 мян.төг
		70	243	-	-
		Төвийн эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд зориулан "Ажилтан бүр хөтөч", "Үйлчлүүлэгчтэй харилцах арга зүй" сэдэвт сургалтыг 2024 оны 07 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулсан.			-
		-	29	-	-
		2024 оны 01-р сарын 12-ны өдөр "Хандлага, харилцааны ур чадвар" сэдвээр сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд төвийн ёс зүйн салбар хорооны			-
		-	80	-	-
		"Төрийн албан хаагчийн ёс зүй" сургалтыг 2024 оны 11 дүгээр сарын 13-нд зохион байгуулсан. "Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030" зэрэг бодлогын баримт бичгүүдийг танилцуулах, хүн хоорондын харилцааны ёс зүйн сэдвээрх сургалтыг ХСҮТ-ийн хүсэлтээр Монгол улсын ёс зүйн хорооны гишүүн, АШУҮИС-ийн багш, доктор, дэд профессор М.Цэрэнбат чиглүүлэн зааж, уг сургалтад тус төвийн 308 эмч, ажилтан хамрагдлаа.			-
		83	153	72	0
		Амбулаторийн тасгийн цахим бүртгэгч, хөтөч нарт зориулан "Ажилтан бүр хөтөч", "Үйлчлүүлэгчтэй харилцах арга зүй" сэдэвт сургалтыг 2024 оны 11-р сард зохион байгуулсан.			-
		-	8	-	-
4.	Хүлээн авсан өргөдөл, гомдлын тоо, шийдвэрлэсэн байдал	Иргэн	Эмнэлгийн мэргэжилтэн	Хэсгийн хороо/ ёс зүйн баг	Хяналтын хорооноос шилжүүлсэн
		-	3	-	-
5.	Эвлэрүүлэн зуучилсан тохиолдлын тоо	Эмч, үйлчлүүлэгч хооронд	Эмнэлгийн мэргэжилтэн үйлчлүүлэгч хооронд	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн хооронд	Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, удирдлагын хооронд
		-	-	-	-
6.	Ёс зүйн зөрчлөөс сэргийлэх чиглэлээр хийсэн ажил	Тус төвийн нийт эмч, ажилтнуудын мэдлэгийг үнэлэх сорил авахаар төлөвлөсний дагуу ажилтнууддаа 1 сарын өмнөөс буюу 2024 оны 04 дүгээр сард мэдээлэл хийж, уншиж судлах материалын жагсаалт (Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль)-ыг фэйсбүүк групп, тасаг, албаны дотоод групп, e-health программаар дамжуулан мэдээлсэн. Түүний дагуу 2024 оны 05 дугаар сард 3-н групп болгон нийт ажилтнуудаасаа мэдлэг сорих сорилын тест авсан. Сорилыг google form болон цаасаар гэсэн 2 төрлөөр авсан.			-
		Төвийн эмч, ажилтнуудын ажлын үр дүн, гүйцэтгэл үнэлэх үнэлгээний 1 үзүүлэлтийг төвийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос сар болгон дүгнэдэг ба 2024 онд салбар хорооны гишүүд хуваарийн дагуу нийт эмч, ажилтнуудын ажлыг дүгнэсэн.			-
		МУ-ын гавъяат багш Х.Дамдинжавын нэрэмжит "Эрүүл мэндийн салбарын ёс зүйн асуудлууд" сэдэвт онол практикийн V хуралд тус төвийн ёс зүйн салбар хорооноос зохион байгуулан ажилласан "Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн сургагч багш бэлтгэсэн туршлага"-аараа оролцож батламж авсан.			-

		Төлөвлөгөөний дагуу 2024 оны 10-р сард нийт 231 эмч, мэргэжилтнүүдийг хамруулан зөвхөн тохиолдол бүхий асуумжаар үнэлгээ хийсэн. Судалгаагаар эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ёс зүйн дүрмийн тухай ойлголт, хандлага, дадлыг дүрмийн асуулт, асуумжаар авдаг арга барилыг шинэчлэх, мөрдөх ёстой дүрмийг бүтнээр нь биш хэсэгчлэн сонгож илүү тодорхой, нарийвчилсан мэдээлэл авахыг зорьсон. Энэ удаад эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрмийн "Хувь хүнийг хүндэтгэн үзэх зарчим"-ыг сонгон эмнэлгийн ажилчдын уг зарчмын талаарх мэдлэг, хандлагын түвшинг тохиолдолд суурилсан асуумжаар үнэлгээ хийсэн. Уг асуумжийн дүгнэлтээс үндэслэн хийх ажлуудаа 2025 онд зохион байгуулахаар төлөвлөсөн. Мөн "Эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүйн эрсдэлийг тохиолдолд суурилсан асуумжаар үнэлсэн нь" гэсэн эрдэм шинжилгээний ажил болгон ёс зүйн асуудлууд эрдэм шинжилгээний хуралд материалаа хүргүүлсэн.	-
		2024 онд ХСҮТ-ийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос тасаг, албадын дунд "Нөхөрсөг уулзалт"-ыг зохион байгуулахаар төлөвлөсний дагуу эхний уулзалтыг Туяа эмчилгээний тасаг, Хорт хавдрын бүртгэл тандалт, эрт илрүүлгийн албаны ажилтнуудын дунд хийсэн. 2 дахь уулзалтыг Хагалгаа, мэдээгүйжүүлгийн нэгдсэн тасаг, Халдварын сэргийлэлт, хяналтын албаны ажилтнуудын дунд тус тус зохион байгуулсан. Уулзалтаар ажилтнууд хоорондоо илүү сайн танилцах, өөрсдийн мэргэжил, хэрэгжүүлдэг үйл ажиллагааныхаа талаар мэдээлэл солилцох, цаашид олон мэргэжилтний багийн ажиллагаа, ажлын уялдаа холбоог сайжруулах, хамт олны дундах эерэг уур амьсгалыг дэмжих зорилготойгоор амжилттай зохион байгуулав.	-
		Төвийн ёс зүйн салбар хороонд ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлын хүрээнд 2024 оны 09-р сард ХСҮТ-ийн төвийн захиргаанд зөвлөмж хүргүүлэн ажилласан.	-
		Төвийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооноос 2024 онд зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг Хавдар судлалын үндэсний төв фэйсбүүк хуудсанд тухай бүрд байршуулан ажилласан.	-
7.	Цахим хуудасны мэдээлэл баяжуулсан байдал	Төвийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны буланг ХСҮТ-ийн цахим хуудас (www.cancer-center.gov.mn) -Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо) байрлуулан гишүүдийн танилцуулга, шинээр батлагдсан дүрэм журам, үйл ажиллагааны талаарх мэдээллийг байнга шинэчлэн ажиллаж байна.	-
8.	Санал хүсэлт, өргөдөл гомдол хүлээн авч тухай бүрд шийдвэрлэх	Төвийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороонд 3 ажилтанд өргөдөл, гомдол ирж журмын дауу шийдвэрлэсэн.	-
9.	Зөрчлийн мэдээний сангийн хөтлөлт	2024 онд ёс зүйн зөрчил гаргасан эмч, ажилтанг зөрчлийн мэдээний санд бүртгэн ажилласан.	-

Тайлан гаргасан: ХСҮТ-ийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны нарийн бичгийн дарга





 П.Мөнхзул

Хянасан: ХСҮТ-ийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны дарга

 М.Минжмаа

**ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН АВЛИГЫН ЭСРЭГ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2024 ОНЫ ТАЙЛАН**

2024 оны 11 дүгээр сарын 29

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1. АТГ-аас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг <ul style="list-style-type: none"> - албан байгууллагын албан ёсны цахим хуудас - сошиал сувгууд - дотоод сүлжээ - хэвлэл мэдээллийн хэрэгсэл - мэдээлэл сурталчилгааны самбар, лед дэлгэц, - Бусад хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх 	Тус төвийн амбулаторийн тасгийн цахим бүртгэлийн хэсгийн мэдээллийн самбар, дэлгэц, төвийн албан ёсны цахим групп, дотоодын мессэнжер групп зэргээр дамжуулан АТГ-аас бэлтгэсэн шторк, нийтлэл, зурагт хуудас зэргийг төвийн байршуулан мэдээллэн ажилласан. <div style="display: flex; flex-wrap: wrap;">     </div>

Тус төвийн цахим бүртгэлийн хэсгийн мэдээллийн самбар, амбулаторийн хэсэгт байрлуулсан 3-н дэлгэц, төвийн фэйсбүүкийн цахим групп зэрэгт авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээллэн сурталчилж сар, улирлаар мэдээллийг шинэчлэн ажиллаж байна.




2024 оны 02-р сард: АТГ-ын Шударга ёс-хөгжил дэвшилд 110 гомдол мэдээлэл хүлээн авах утасны дугаар бүхий зурагт хуудсыг мэдээллийн самбарт байршуулсан.


2024 оны 04-р сард: АТГ-аас гаргасан Авлигын эсрэг хуулийн зүйл заалт бүхий 2 зурагт хуудсыг цахим бүртгэлийн хэсгийн мэдээллийн самбарт, захиргааны хэсгийн мэдээллийн самбаруудад байршуулсан.



		<p>1.3. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэх 110 дугаарыг оруулан сурталчлах,</p>	<p>Төвийн амбулатори, цахим бүртгэлийн хэсэгт АТГ-аас гаргасан тараах материалыг байршуулан олон нийт, үйлчлүүлэгчдэд мэдээллэн ажилласан.</p>  <p>Мөн төвийн тасаг, албаны удирдах ажилтнуудад АТГ-аас гаргасан тараах материалыг тараасан.</p> <p>ХСҮТ-с эмч, ажилтнууд, үйлчлүүлэгч нарт зориулан нийтийн албан тушаалтны хориглох зүйлсийн талаар эх бэлтгэн мэдээлэл гарган ажилласан.</p>	
		<p>1.4.Өөрсдийн үйл ажиллагааг авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий (шторк, зурагт хуудас, сонин нийтлэл, радио контент, цахим, хэвлэмэл ном, гарын авлага, броюшур зэргээс боломжит хэлбэрийг сонгон) сурталчилгааг хийж олон нийтэд хүргэсэн байх.</p>	<p>Төвийн хэмжээнд авлигын эрсдлээс ангид байхад чиглэсэн 2 төрлийн шторк хийн ажиллаж байна.</p> <ol style="list-style-type: none"> 1. Авлигаас ангиад байх, бэлэн мөнгө, эд зүйл өгөхийг хориглосон видео шторкийг гарган 12-р сарын эхээр олон нийтэд гаргахаар болсон. 2. АТГ-тай хамтарч “Авлигаас ангид байх, шударга байдлыг уриалсан” видео контентын зургийг авч дууссан ба 12 сард багтаан олон нийтэд хүргэхээр төлөвлөсөн болно. 	
<p>2</p>	<p>Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх</p>	<p>2.1. “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх</p> <p>2.4. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал,</p>	<p>Уг ажлын хүрээнд “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх олон нийтийн байгууллагын зарыг олон нийтэд мэдээллэсэн боловч ямар нэг санал, хүсэлтээ ирээгүй болно.</p> 	
	<p>Хорт хавдрын тусламж, үйлчилгээний хүрээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/332 дугаар тушаалын 1.5 дугаар хэсэгт</p>			

		<p>чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших</p>	<p>“Хүлээгдэл ихтэй тасаг нэгжийн тусламж, үйлчилгээг сайжруулах, оношилгоо, амбулаторын үзлэг, орны хүлээгдлийн хугацааг 30-аас багагүй хувиар бууруулах” үүрэг өгөгдсөн. Тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор үйл ажиллагааны ерөнхий болон календарчилсан төлөвлөгөөг гаргаж, түүний дагуу 7 дугаар сарын 24-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд тусламж, үйлчилгээний явцын зураглалыг шинэчлэн боловсруулж, амбулаторийн үзлэгийн төрөл, кабинетуудын онцлогоос шалтгаалан норм, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулж, хүлээгдлийг бүртгэх, мэдээлэх системийг шинэчлэн ажилласан. Үүний үр дүнд амбулаторийн эмчийн үзлэгийн хүлээгдэж буй хоногийн тоо 70 хувиар, 7-оос дээш хоног хүлээж байгаа үйлчлүүлэгчийн тоо 24.1 хувиар, оношилгооны кабинетийн хүлээгдэл 62 хувиар, эмнэлэгт хэвтэхээр 3-с дээш хоног хүлээж байгаа үйлчлүүлэгчийн тоо 32 хувиар, хэвтэх ор хүлээх дундаж хоног 53 хувиар тус тус буурсан байна.</p> <div data-bbox="1124 628 2063 1189"> </div>
<p>3</p>	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах</p>	<p>3.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>ХСҮТ-ийн эмчилгээ, үйлчилгээний шат дамжлагыг бууруулах, цахимжуулах үйл ажиллагааг шат дараатайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. 2024 оны 05-р сарны 01-нээс иргэний мэдээллийг хур системээр баталгаажуулж иргэнээс зөвшөөрөл авч ашигладаг болсон. Эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх 12 төрлийн үзлэгийн цагийг e-mongolia систем, цахим цаг захиалгын e-cancer.mn систем ашиглан цаг</p>

арга хэмжээ авах			<p>товлолтын үйлчилгээг үзүүлж байна. Мөн 72724000, 1800-0119 дугааруудаар цаг захиалгын үйлчилгээг үзүүлж байна.</p> <p>Мөн үйлчилгээний ил тод байдлыг хангах зорилгоор 2024 оны 04-р сараас 13-н үзлэгийн өрөөний гадна тухайн өдөр үйлчилгээ авах иргэдийн нэрсийн дарааллыг гаргадаг болсон.</p> <p>Иргэдийн гомдол, саналын дагуу төвийн цахим бүртгэлийн хэсгийн цаг товлалтын үйлчилгээ үзүүлж буй ажилтнуудын компьютерийг бүрэн шинэчилж үзүүлэлт сайтай нийт 40-ийг суурлуулан холболт хийн хэвийн ажиллагаанд оруулж 140 орчин сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.</p> <p>Мөн интернэтийн хурд 100 mbps байсныг 150 mbps хурдтай болгон сайжруулж 18 сая төгрөгийн санхүүжилтийг гаргасан.</p> <p>Шаардлагатай хэсгүүдийг нэмж камержуулах судалгаа, төлөвлөгөөг гарган ажиллаж байна.</p>
		<p>3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулах, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангиад байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>АТГ-аас байршуулсан санал хүсэлтийн хайрцагт ирсэн санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p>1. 2024 оны 04 дүгээр сарын байдлаар нийт 29-н гомдол, санал ирснээс:</p> <ul style="list-style-type: none"> - Талархал – 4 - Төвийн эмч, ажилтнуудтай холбоотой гомдол санал – 14 - Бусад гомдол – 12 ирснийг ирсэн. <p>2. 2024 оны 11-р сарын байдлаар нийт 38-н гомдол, санал ирснээс:</p> <ul style="list-style-type: none"> - Төвийн ажилтнуудтай холбоотой 38 ирсэн байна. <p>Эдгээр гомдол, санал гаргасан иргэдээс эргэж хариу өгөх хаяг, утасны дугаараа бичээгүй байсан. Гомдол, саналтай холбоотой зохих арга хэмжээг авч шийдвэрлэн ажиллаж байна.</p> 
		<p>3.3. Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>2024 оны 01-р сард Эрүүгийн цагдаагийн газраас тус төвийн захиргааны зөвлөлийн гишүүдэд “Эрүүл мэндийн салбарт үйлдэгдэж байгаа Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, цаашид анхаарах асуудал” сэдвээр сургалт, яриа хийсэн.</p>

			 <p>2024 оны 11-р сард АТГ-ын комиссар Балдандорж төвийн сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд “Авлигын эсрэг үйл ажиллагаа”-ны талаар мэдээлэл, сургалт хийсэн.</p> 
4	<p>Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэл, санаачилга өрнүүлэх</p>	<p>4.1. Удирдлагын зүгээс 2024 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг эхний хагас жилд, хэрэгжилт, хүрсэн үр дүнг жилийн эцсээр нийт албан хаагчдадаа танилцуулах;</p> <p>4.3 Төвийн хэмжээнд 2024 онд иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдолд чанарын хяналт хийх</p>	<p>2024 оны 12-р сард ХСҮТ-ийн үйл ажиллагааны жилийн тайлангийн хурал Авлигын эсрэг үйл ажиллагааны тайланг танилцуулахаар төлөвлөж байна.</p> <p>Өргөдөл, гомдлын тайлан Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн А/50 тоот тушаалаар батлагдсан “Иргэд, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх, хяналт тавих журам”, ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2021 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн А/12 тоот тушаалаар батлагдсан “Иргэдээс ирүүлсэн эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор 2024 оны III улирлын байдлаар нийт -277 гомдол, санал, хүсэлт, өргөдлийг хүлээн авч хуулийн хугацаанд шийдвэрлээд байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> - Санал – 30 - Гомдол – 222 - Өргөдөл – 25

			<p>“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 1-т заасны дагуу иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлт, гаргах эрхийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор санамж, зурагт хуудас, талархлыг самбар, санал хүсэлтийн хайрцгийг амбулаторийн хүлээлгийн танхим, эмчилгээний тасгууд болон төвийн цахим хуудсанд байрлуулан мөн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны утасны дугаар, цахим хаяг, өрөөний дугаар бүхий нэрийн хуудсыг сувилагчийн пост, хүлээлгийн заал, хүлээн авах зэрэг үйлчлүүлэгч олноор үйлчлүүлдэг газруудад байрлуулан ажиллаж байна.</p> <p>Тус төвийн 2024 оны III улирлын байдлаар ирсэн нийт өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.3 дахин нэмэгдсэн нь төвийн үйл ажиллагаа, тусламж үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлтийг Засгийн Газрын Иргэд олон нийттэй харилцах төв, ЭМЯ-нд хүргүүлэх цахим хаяг, утас зэрэг холбогдох мэдээллийг төвийн тасаг нэгжийн мэдээллийн самбарт байршуулсантай холбоотой. Мөн иргэдээс ирүүлэх өргөдөл гомдлыг хүлээн авах, тус төвийн чанар аюулгүй байдлын албаны утас, холбогдох цахим хаягийг мэдээллийн самбарт ил тод байршуулан, иргэдээс утсаар ирүүлсэн гомдол, саналыг бүртгэлжүүлсэнтэй холбоотой байна гэж үзэж байна. 2023 оны III улиралтай харьцуулбал тусламж үйлчилгээний чанар, хүртээмжтэй холбоотой гомдол санал 102, ажилчдын ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой гомдол санал 22-оор нэмэгдсэн, аппарат тоног төхөөрөмжийн хүрэлцээтэй холбоотой гомдол 16-аар буурсан байна. Харин өмнөх улирлын дүнтэй харьцуулж үзэхэд эмчилгээ, үйлчилгээний чанар хүртээмжтэй холбоотой гомдол 4%-иар буурсан үзүүлэлттэй байна. 2024 оны III улирлын байдлаар өргөдөл, гомдлын шийдвэрлэлт 100%-тай байна.</p>
5	Бусад	<p>5.1. Удирдах албан тушаалд шинээр томилогдсон албан хаагчдыг авлигын эсрэг сургалтад хамруулсан байх;</p> <p>5.2. Тухайн байгууллагын хариуцдаг, шууд хамаардаг, хамтран ажилладаг байгууллагад авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний</p>	<p>ХСҮТ-ийн бүтэц, орон тоо 2024 оны 05-р сарын 01-ний өдрөөс шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2 удирдах албан тушаалтан, өөр удирдах албан тушаал шилжин болон дэвшин ажиллах болсонтой холбогдуулан ХАСУМ, ХАСХОМ шинэчлэн гаргуулсны үндсэн дээр баталгаажуулан ажилласан ба тэдгээр ажигтнуудад тухай бүрд нь зөвлөгөө өгсөн.</p> <p>Манай байгууллагын хувьд ямар нэгэн тусгай зөвшөөрөл олгодоггүй бөгөөд өөрт хариуцдаг, шууд хамаардаг байгууллага байхгүй, төрийн үйлчилгээний анхан шатны нэгж байгууллага. Харин бараа, бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, үйлчилгээ авагч иргэд, хамтран ажиллагч төрийн бус байгууллагуудтай хамтран төрийн үйлчилгээн дахь авлигаас урьдчилан сэргийлэх, ил тод байдлыг сайжруулах, ёс зүйг дээшлүүлэх, үйл ажиллагааны хүнд суртлыг бууруулах чиглэсэн мэдээллийг өгч ажилласан.</p>

		<p>үр дүнг мэдээлэх сурталчлах арга хэмжээг зохион байгуулах.</p>	
		<p>Удирдах албан тушаалд томилохдоо хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газраар хянасан байдлыг харгалзан албан тушаалд томилон ажиллах</p>	<p>Жилийн хугацаанд тус төвөөс 2 албан тушаалтныг удирдах албан тушаалд томилохдоо ХАСУМ-ыг АТГ-аар хянуулахаар албан хүсэлт хүргүүлсний дагуу хариуг үндэслэн 2 албан тушаалтныг томилон ажиллуулсан.</p>
		<p>Нийтийн албан тушаалд томилогдсоноос хойш хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг урьд оны байдлаар цаасаар болон цахим хэлбэрээр гаргуулж, гарын үсэг зуруулан, бүртгэлийг тогтмол хөтлөх</p>	<p>1 удирдах албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг урьд оны байдлаар гаргуулж баталгаажуулсан. 2024 онд 11 сард ажилдаа орсон 1 удирдах албан тушаалтанд ХАСХОМ-ийн цонх нээж өгөх, 2023 оны мэдүүлгээ хэрхэн гаргах талаар зааварчилга өгч ажилласан.</p>

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:

**ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН,
ХҮНИЙ НӨӨЦ, ХӨГЖЛИЙН АЛБАНЫ ДАРГА**



Д.МӨНХТУЯА

**ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2024 ОНЫ ТӨРИЙН АЛБАН
ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ
ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

2024 оны 12 сарын 11

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхижүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1	Нийт сургалт, семинар, зөвөлгөөний тоо:	19	25	Төвийн эмч мэргэжилтнүүдийг тасралтгүй сургалтыг төлөвлөгөөний дагуу 2024 онд 25 удаа зохион байгуулж, нийт 390 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтанууд хамрагдсан. Төгсөлтийн дараах Хавдар судлал үндсэн мэргэжлийн сургалтанд 4 эмч, төрөлжсөн мэргэшлээр хавдрын хими эмчилгээ судлалаар 2 эмч, туяа эмчилгээ судлалаар 2 эмч, толгой хүзүүний мэс заслаар 1 эмч, хавдрын сувилахуй судлалаар сургалтад 8 сувилагч, хөнгөвчлөх эмчилгээний сувилахуй судлал сургалтад 2 сувилагч, Хавдрын мэс заслын мэргэжил дээшлүүлэх сургалтад 10эмч тус тус суралцсан. Мөн 9 удаагийн багц цагийн сургалт зохион байгуулж, нийт
		Үүнэ эс	Ажлын байран дахь сургалт	6	8	
			Мэргэшүүлэх сургалт	6	7	
			Туршлага солилцох арга хэмжээ	2	4	
		Бусад	5	6		
		1.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо	358	390	
		Үүнэ эс	Эмэгтэй албан хаагч	200	220	
			Эрэгтэй албан хаагч	158	170	
			Удирдах албан тушаалтан	10	10	
		Гүйцэтгэх туслах албан тушаалтан	226	240		
1.3	Албан хаагчдыг сургалтанд хамруулсан байдал: нийт албан хаагчдад эзлэх хувь	80%-иас дээш	90%			
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад сургалт	2.1	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	12	14	
		2.2	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	80	88	
		Үүнэ эс	Эмэгтэй албан хаагч	35	48	
			Эрэгтэй албан хаагч	45	40	
			Удирдах албан тушаалтан	5	8	
		Гүйцэтгэх туслах албан тушаалтан	75	80		
		2.3	Гадаад сургалтад хамруулсан байдал: нийт албан хаагчдад эзлэх хувь	20%-иос дээш	25%	

						эмч, эмч зүйч, сувилагч тусгай мэргэжлийн ажилтан хамрагдсан. 2024 онд нийт ажиллагсдын 90%--ийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулсан. 2024 онд тус төвийн 88 эмч мэргэжилтэн гадаадын өндөр хөгжилтэй орнуудад урт, богино хугацааны сургалт, семинар, туршлага судлах сургалтанд хамрагдсан байна.
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	30 сая төг	36 сая төг	Төвийн 10 их эмчийн төрөлжсөн мэргэшлийн болон мэргэжил дээшлүүлэх сургалтын төлбөр төлсөн. Гадаадад урт хугацаатай суралцаж буй 6 эмч, ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн. ХСҮТ-ийн Ерөнхий захирлын 2024 оны 03 сарын 01-ний өдрийн А/18 тоот шинэчилсэн тушаалаар батлагдсан “Сургалтын дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу дотоодын их, дээд сургуульд суралцаж, 2024 онд магистрийн зэрэг

						хамгаалсан 2 эмчид сургалтын төлбөрийн 20%-иар, 1 сувилагчид сургалтын төлбөрийн 70%-иар тооцож, нийт 2'317'280 төгрөгийн сургалтын тэтгэлэг олгосон. Энэхүү журмыг 2022 оноос хэрэгжүүлж эхэлснээр нийт 29 эмнэлгийн мэргэжилтэн (14 эмч, 13 сувилагч, 2 бусад мэргэжилтэн)-д 28'288'240 төгрөгийг олгосон нь ажилтнуудыг сурч, хөгжихөд ихээхэн дэмжлэг болсон юм. Нийт магистрын 35,8 хувийг 2022-2024 онд хамгаалсан шинэ магиструуд эзэлж байна.
		3.2	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош	11,1	Тайлант оны гүйцэтгэлээр
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	22.2	22	2024 оны 11-р сарын 27-ны өдрийн гүйцэтгэлээр 22 тэрбум төгрөг зарцуулсан
		4.2	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	5000 төг	5000 төг	Хоногт олгохоор тогтоосон дүн

5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцлийг бүрдүүлэх	5.1	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш	86,2%	Судалгаанд давхардсан тоогоор 351 ажиллагсад хамрагдсан. Судалгааг дэмжлэг удирдлага, хүний нөөцийн хөгжих боломж, эмнэлгийн мэргэжилтний ёсзүй, үйлчилгээний соёл, байгууллагын соёл, ажлын байрны аюулгүй дэмжлэгт орчин, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, ерөнхий сэтгэл ханамжийн үнэлгээ гэсэн 7 бүлэг асуумжаар судалгааг авч боловсруулсан.
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш	1	Төрөлжсөн мэргэжлийн эмчийн үзлэг болон багц шинжилгээ
		6.2	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш	96%	Сайн дураар хамрагдах
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	173.1 сая	216.2 сая	Тайлант оны гүйцэтгэлээр өмнөх оныхоос өссөн байна.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



/Н.ЭРДЭНЭХҮҮ/

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ДЭД ЗАХИРАЛ



/Ц.УРАНЧИМЭГ/

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД,
СУРГАЛТЫН ДАРГА



/Ц.БАДАМСҮРЭН/

ХҮНИЙ НӨӨЦ ХӨГЖЛИЙН АЛБАНЫ
ДАРГА



/Д.МӨНХТУЯА/

Хүснэгт 3.7

ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН-2024

2024 оны 12 –р сарын 03

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх мэдээллийн ил тод, нээлттэй байдал			
1.1	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн	<p>Эрхэм зорилго, зорилт, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг байгууллагад мэдээллийн самбар, зурагт хуудас, сурталчилгааны самбараар ил тод мэдээлдэг. Мөн дээрх мэдээллүүдийг байгууллагын цахим хуудаст ойлгомжтой байдлаар байршуулж, тухай бүр шинэчилдэг.</p> <p>Байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтэд хүргэх, мэдээлэхээс гадна ЭМЯ, НЭМҮТ, Хавдрын Үндэсний Зөвлөл, ДЭМБ, АНУ-ын Өвчний хяналтын төв зэрэг төрийн, төрийн бус, олон улсын байгууллагуудаас халдварт бус өвчнүүд тэр дундаа хорт хавдраас урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийтэд зориулан гаргасан мэдээ, мэдээллүүдийг төвийн нүүр номд байршуулж ажилласан.</p> <p>https://www.cancer-center.gov.mn/home/</p>	100%
1.2	Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг	<p>Эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдол, санал хүсэлт, төвийн удирдлага иргэдтэй уулзах уулзалтыг Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагч ерөнхий захирлын референт, тусламж үйлчилгээний чанарын мэдээллийн асуудал хариуцсан ажилтан нар хариуцан ажиллаж байна. Эдгээр албан тушаалтнуудын ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас (www.cancer-center.gov.mn) болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулж тухай бүрд нь шинэчилж байна.</p> <p>Чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт - https://www.cancer-center.gov.mn/checkout/</p> <p>-хаяг байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг https://www.cancer-center.gov.mn/home/contact-us/</p> <p>олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг –</p>	100%

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
1.3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж	<p>https://www.facebook.com/nationalcancercentermg</p> <p>Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн байдлыг тасаг, алба, нэгж тус бүрээр нээлттэй хэлэлцэн үнэлгээ хийдэг. Мөн байгууллагад хийгдсэн хяналт шинжилгээ, аудит, бусад шалгалтын тайланг байгууллагын цахим хуудас болон шилэн дансанд байршуулан ил тод мэдээлж байна.</p> <p>Монгол улсын эрүүл мэндийн сайдын А/346 дугаар тушаалын дагуу тайлан бичих журмыг баримтлан бодлогын баримт бичгийн хүрээнд, хууль тогтоомж, төсөл, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа, шилэн дансны мэдээллийг тус тус Эрүүл мэндийн яам, Засгийн газрын хэрэг эрхлэх газар тус бүр тайлагнаж цахимаар болон бичгээр илгээдэг. Тайлангийн төрлүүд болон тайлан илгээх хугацааг хавсралтаар илгээв.</p> <p>http://www.cancer-center.gov.mn/aboutus/shilendans/tusuv_quitsetgel/sankhuuaudit</p>	100%
1.4	Хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан	Гүйцэтгэх засаглалын болон эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй хууль, тогтоол, зарлиг, шийдвэрийн хэрэгжилтийн талаар дээд шатны захиргаанд жилд 2 удаа тайлагнан ажиллаж байна.	100%
1.5	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан	<p>Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан болон “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтийн тайлан, Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг Эрүүл мэндийн яаманд цахимаар болон бичгээр жилдээ 2 удаа хүргүүлдэг ба Хавдар судлалын үндэсний төвийн веб хуудасны ил тод байдал хэсэгт нээлттэй байршуулдаг.</p> <p>http://www.cancer-center.gov.mn/</p>	100%
1.6	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт	<p>Гүйцэтгэх засаглалын болон эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй хууль, тогтоол, зарлиг, шийдвэрийн хэрэгжилтийн талаар дээд шатны захиргаанд жилд 2 удаа тайлагнан ажиллаж байна.</p> <p>Түүнчлэн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудасны ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ хэсэгт хууль, УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, ЭМС-ын тушаал, Ерөнхий захирлын тушаал, журам гэсэн чиглэлээр тухай бүр шинэчлэн байршуулдаг. http://www.cancer-center.gov.mn</p>	100%


№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
1.7	Албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг	<p>Төрийн албаны зөвлөлийн 2019 оны А/03 дугаар тогтоолоор батлагдсан “АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ” журмын дагуу бүх ажиллагсдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулан ажилтан, удирдах албан тушаалтнууд баталгаажуулсан.</p> <p>Байгууллагын нийт ажиллагсдын утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг зэрэг мэдээллийг жил бүр болон шаардлагатай тохиодол бүрд шинэчлэн байгууллагын ажиллагсдын албаны цахим шуудангаар түгээдэг. Мөн шуурхай удирдлагын төвд цахим болон хэвлэмэл хэлбэрээр байршуулдаг.</p> <p>Байгууллагын ажиллагсад албан хэрэгцээнд abcd@cancer-center.gov.mn цахим шуудангийн хаягийг ашигладаг.</p>	100%
1.8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ	<p>ХСҮТ-ийн ерөнхий захирлын 2021 оны 03 сарын 11-ний өдрийн А/12 тоот “Иргэдээс ирүүлсэн эмчилгээ, үйлчилгээтэй холбоотой өргөдөл гомдлыг шийдвэрлэх журам батлах тухай” тушаалын хавсралт 1-ийн дагуу шат дамжлагатайгаар хүлээн авах, шийдвэрлэх үйл ажиллагаа тасралтгүй явагдаж байна.</p> <p>ЭМС-ын 2022 оны А/50 дугаар тушаалын хавсралтын загварын дагуу улирал бүр өргөдөл, гомдлын тайланг ЭМЯ-руу албан бичгээр гарган илгээж байна. /I, II, III улирлын тайлан илгээгдсэн болно./</p> <p>2024 оны жилийн эцсийн байдлаар өргөдөл 28, санал 38, гомдол 287 ирсэний 11-11 төвөөс 99 гомдол ирсэн бөгөөд 100% шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p>Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн агуулга, шийдвэрлэлт:</p>	100%



№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
		<p>Өргөдөл-28: Нийт өргөдлийн ихэнх хувь нь эмчилгээ, үйлчилгээ болон үйлчлүүлэгчийн талаарх мэдээлэл авах хүсэлтэй байна.</p> <p>Санал-38: Саналын ихэнх хувийг өндөр өртөгт шинжилгээний цаг захиалга, хүлээгдэл болон цахимаар цаг захиалгаа түргэн шуурхай хүртээмжтэй болгох санал эзэлж байна.</p> <p>Гомдол-287: Гомдлын ихэнх хувийг 7272-4000 утасны цаг захиалга, хүлээгдэл, шинжилгээний хэсгийн тав тух, очер дараалал болон аппарат тоног төхөөрөмжтэй холбоотой гомдол эзэлж байна.</p> <p>Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг 11-11 төв, албаны 70150437 утас, биечлэн, цаасаар, мөн шуудангаар хүлээн авч шийдвэрлэн ажиллаж байна.</p> <p>Иргэд, үйлчлүүлэгчдээс ирсэн санал хүсэлт, өргөдөл гомдлыг тухай бүрд нь тасаг албадын дарга нарт санал хүсэлт гомдол хүлээн авах хуудсаар мэдэгдэж, холбогдох арга хэмжээг аль болох түргэн шуурхай шийдвэрлэн, иргэд үйлчлүүлэгчдэд хүндрэл чирэгдэлгүй үйлчлэхээр эрмэлзэн ажиллаж байна.</p> <p>Тусламж үйлчилгээтэй холбоотой өргөдөл, гомдол санал хүсэлт тэдгээрийн шийдвэрлэлтийн тайланг төвийн цахим хуудсанд улирал тутам байршуулж мэдээлж байна. https://shorturl.at/XSxCK</p> 	

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
1.9	Хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл	<p>ХСҮТ-ийн үйл ажиллагааны статистик мэдээ, мэдээллийг ЭМС-ын 2019 он А/611 дугаар тушаалын дагуу өдөр бүр, долоо хоног, сар, улирал, хагас жил, жилд цуглуулан статистик боловсруулалт, Эмнэлгийн тусламж үйлчилгээний гүйцэтгэлийг амбулаторийн үзлэг, хэвтэн эмчлүүлсэн, яаралтай тусламж, лабораторийн болон дүрс оношилгооны шинжилгээ, эмгэг судлалын шинжилгээ гэсэн 6 төрлөөр мэдээлэл бэлтгэн улирал бүр төвийн вейб сайт дээр байршуулсан. дүн шинжилгээ хийж, долоо хоног, сар улирлаар эргэн мэдээлдэг.</p> <p>Улирал бүр, жилийн эцэст ХСҮТ-ийн үйл ажиллагааны статистик мэдээллээр ном боловсруулан түгээдэг.</p> <p>Байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээллийг төвийн цахим хуудсанд улирал, хагас, жилээр гаргаж мэдээлж байна.</p> <p>Хавдар судлалын үндэсний төвийн Хорт хавдар эрт илрүүлгийн бүртгэл тандалтын алба нь улсын хэмжээнд хорт хавдар, эрт илрүүлгийн холбогдох мэдээ тайланг гарган ЭМЯ болон Олон улсын IARC төвд мэдээлэл гарган хүргүүлж байна.</p>	 <p>100%</p>
1.10	Мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр	<ul style="list-style-type: none"> - ХСҮТ нь иргэд, олон нийтэд мэдээллийг байгууллагынхаа албан ёсны вебсайт, пэйж хуудас, хэвлэл мэдээллийн байгууллага болон нийгмийн сүлжээгээр дамжуулан түгээдэг. - ХСҮТ нь иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амд хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн ач холбогдол, амьдралын зөв дадал зуршлыг сурталчлах, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн бодитой, эерэг хандлагатай мэдээ, мэдээлэл түгээх үүргээ хэрэгжүүлэхдээ ХСҮТ-ийн Ерөнхий захирлын тушаалаар батлагдсан “Олон нийтэд зориулсан мэдээлэл сурталчилгааны ажлыг зохицуулах журам”-ыг мөрдөж ажиллаж байна. - Түгээж буй мэдээлэл нь нийтэд хамааралтай, хууль, ёс зүйд нийцсэн, үнэн зөв, албан ёсны баримтад тулгуурласан, хувь хүний нууцыг хадгалсан, 	100%

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
		<p>хүндэтгэсэн байх асуудлыг тус төвийн олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтан хариуцан ажилладаг.</p> <ul style="list-style-type: none"> - Өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг тогтмол түгээхээс гадна зонхилон тохиолдох хавдруудаас урьдчилан сэргийлэх, хавдрын эрсдэлт хүчин зүйлс, тархалт, эрт илрүүлэг зэрэг олон сэдвээр олон нийтэд зориулсан мэдээлэл сурталчилгааны ажлыг жил бүр төлөвлөн хэрэгжүүлж ажиллаж байна. - Төвийн цахим хуудас, веб сайтын мэдээллийн санг баяжуулах, шинэ мэдээлэл оруулах ажилд ХСҮТ-ийн бүх тасаг, албатай хамтран ажилладаг. - Хавдар судлалын үндэсний төв (ХСҮТ)-ийн эмч, мэргэжилтэн, албан тушаалтан нь төрийн болон албаны, байгууллагын болон үйлчлүүлэгчийн нууцад хамаарахаас бусад төвийн үйл ажиллагаатай холбоотой сэдвээр олон нийтэд нээлттэй, үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэдэг. - ХСҮТ-ийн эмч, мэргэжилтэн, албан тушаалтан нь төвийн үйл ажиллагаа, хавдрын урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэлт, оношилгоо, эмчилгээ болон цаг үеийн үйл явдлын талаар шинжлэх ухааны үндэслэлтэй, зөв мэдээ, мэдээллийг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд түгээх, сургалт, сурталчилгааны ажилд оролцохыг дэмждэг. - Хэвлэл мэдээллийн байгууллагыг төвийн үйл ажиллагааны талаарх мэдээллээр хангахыг дэмжиж ажилладаг. - Оны эхний 12 сарын байдлаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 350 гаруй мэдээллийг бэлтгэн пэйж хуудсанд байршуулж хандагчдын тоо 72000 болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 6300-аар нэмэгджээ. Олон нийтийн 40 гаруй хэвлэл мэдээллээр 200 гаруй мэдээ, ярилцлага, нийтлэл түгээгдсэн байна. 	
2.1	Ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл	<p>2024 онд Хавдар судлалын үндэсний төвд шинээр эмч, эмнэлгийн ажилтан авах тухай зарыг дараах мэдээлэл түгээх сувгуудаар зарласан.</p> <ul style="list-style-type: none"> - Төвийн www.cancer-center.gov.mn цахим хуудас, - Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим хуудас, - Төвийн олон нийтийн мэдээллийн самбар, - Төвийн олон нийтэд зориулсан facebook хуудас зэргээр 51 удаа ажлын зарын мэдээллийг гаргасан. 	100%

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
			
2.2	Албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам	<p>ХСҮТ-ийн ерөнхий захирлын 2020 оны А/27 дугаар тушаалаар шинэ ажилтныг сонгон шалгаруулалтын комиссыг шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна. Журмын дагуу сул орон тооны зарыг 4-н төрлийн мэдээллийн сувгаар дамжуулан зарласан ба зарлалын дагуу хүсэлт гаргасан 144 иргэний материалыг хүлээн авч 34 ажлын байранд дээр сонгон шалгаруулалтын журмын дагуу 41 удаагийн шалгаруулалт явуулсан.</p> <p>Төвийн албан ёсны цахим хуудсанд ажилтан сонгон шалгаруулах үйл явц, бүрдүүлэх материалын жагсаалт, холбоо барих утасны дугаар, сонгон шалгаруулалтын дүнг жилээр болон ажлын байр болгоноор гарган нийтэд ил тод мэдээлсэн.</p>	100%
2.3	Албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм	<p>Төвийн хэмжээнд Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, Төрийн албан хаагчийн эрхэмлэх 9-н зүйл зэрэг ёс зүйн дүрэм, журмыг төвийн нийт эмч, ажилтнуудад мэдээлэн сурталчилж, мөрдөн ажиллаж байна. Дээрх ёс зүйн дүрмийг төвийн цахим хуудас www.cancer-center.gov.mn сайтад төвийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хорооны хэсэгт байршуулсан.</p>	100%

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
2.4	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам	Төвийн хүний нөөцийг хөгжүүлэх бодлогыг стратеги бодлоготой уялдуулан 2000–2005 он, 2006-2008 он, 2009-2011 он, 2012-2014 он, 2015-2017 он, 2019-2020 он, 2021-2023 онуудад үе шаттай тодорхойлон хэрэгжүүлж байна. 2024-2026 онд “Хавдар судлалын үндэсний төвийн хүний нөөцийн бодлого”-ыг төлөвлөн ажиллаж дагалдах төлөвлөгөөнүүдийг боловсруулж хэрэгжүүлэн ажилласан. Төвийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөвт хүний нөөцийн удирдлага, хөгжил, ажилтнуудад үзүүлэх дэмжлэг, нийгмийн хангамжийг тусгаж ажилласан. МУ-ын Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/155 тоот тушаалаар батлагдсан Хавдар судлалын үндэсний төвийн бүтцийг төвийн цахим хуудсанд байрлуулсан.	100%
2.5	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ	<ul style="list-style-type: none"> - Шинээр ажилтныг сонгон шалгаруулж авахдаа ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан үндсэн шаардлагын дагуу зарлан цаг тухай бүрд сонгон шалгаруулалтыг явуулж холбогдох материалыг баталгаажуулж хэвшсэн. - Төвийн хэмжээнд ажлаас чөлөөлөгдөж буй ажилтнуудаас тусгайлан гаргасан асуумжийн дагуу санал асуулга авч, үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой саналыг удирдлагад танилцуулж хэвшсэн. - ХСҮТ-ийн ерөнхий захирлын 2024 оны А/30 дугаар тушаалаар шинээр батлагдсан ажлын байрны тодорхойлолт боловсруулан, тухайн ажлын байранд ажиллах ажилтанд танилцуулан ажилласан. 	100%
2.6	Албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам	<ul style="list-style-type: none"> - Монгол улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолыг үндэслэн боловсруулсан “Эрүүл мэндийн ажилтанд улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгох тухай” ХСҮТ-ийн ерөнхий захирлын 2020 оны А/42 дугаар тушаалаар шинэчлэн баталсан. - Журмын дагуу 2024 онд сар, улирал тутамд ажилтнуудын ажлыг дүгнэн 1-р улиралд 446 ажилтныг, 2-р улиралд 419 ажилтныг, 3-р улиралд 416 ажилтныг тус тус урамшуулан шагнасан. - Уг ажил дүгнэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр Хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулсны дагуу ажил дүгнэсэн албан тушаалтнаар оноог тавиулан гарын үсэг зуруулан баталгаажуулж, ажлыг нь дүгнэсэн оноог ажилтан тус бүрд танилцуулан гарын үсэг зуруулан ажиллаж байна. 	100%

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
3.1	Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл	Байгууллагын цахим хуудасны төсөв санхүүгийн ил тод байдал болон шилэн дансны нэгдсэн системд төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод нээлттэй байршуулж байна. http://www.cancer-center.gov.mn	100%
3.2	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан	Байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн системд төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод нээлттэй байршуулж байна. http://www.cancer-center.gov.mn	100%
3.3	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт.	Байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн системд төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод нээлттэй байршуулж байна. 2023 оны санхүүгийн тайланд үндэсний аудитын газар шалгаж, зөрчилгүй дүгнэлт гарсан.	100%
3.4	Хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ.	Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2022 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 49/А/118 дугаар тушаалыг үндэслэн ХСҮТ-ийн төлбөртэй тусламж үйлчилгээний журмыг шинэчлэн баталсан. Байгууллагын цахим хуудасны ил тод байдал хэсэг болон цахим бүртгэлийн хүлээлгийн танхимд ЛЭД дэлгэцээр цацаж мэдээллийг ил тод хүргэж байна.	100%
3.5	Төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар	Байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн системд төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг байгууллагын цахим хуудасны төсөв, санхүүгийн ил тод байдал хэсэгт нээлттэй байршуулж байна.	100%
3.6	Таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг	Байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн системд төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод нээлттэй байршуулж байна. http://www.cancer-center.gov.mn/about-us/shilendans/ http://www.cancer-center.gov.mn/about-us/shilendans/hplan/tendertailan/	100%
3.7	Цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт	Байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн системд төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод нээлттэй байршуулж байна. http://www.cancer-center.gov.mn/about-us/shilendans/	100%
3.8	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн	Байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн системд төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод нээлттэй байршуулж байна.	100%

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
	түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, үүсгэсэн аливаа шийдвэр	http://www.cancer-center.gov.mn/about-us/shilendans/hplan/tendertailan/	
3.9	Шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл	Байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн системд төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод нээлттэй байршуулж байна. http://www.cancer-center.gov.mn/about-us/shilendans/ http://www.cancer-center.gov.mn/about-us/shilendans/other/audit1/ https://gap1.mof.gov.mn/organization/21561?ry=2024	100%
3.10	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан	Байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн системд төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод нээлттэй байршуулж байна. http://www.cancer-center.gov.mn/%d0%b8%d0%bb-%d1%82%d0%be%d0%b4-%d0%b1%d0%b0%d0%b9%d0%b4%d0%b0%d0%bb/tenderiltod/urilga/	100%
3.11	Худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт, шалгалтын тайлан, дүгнэлт	Байгууллагын цахим хуудас болон шилэн дансны нэгдсэн системд төсөв, санхүү, худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээллийг ил тод нээлттэй байршуулж байна. http://www.cancer-center.gov.mn/about-us/shilendans/	100%
3.12	Мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, аргазүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл	Худалдан авах үйл ажиллагааны АЗ сертификат авах сургалтад ХСҮТ-ийн 23 эмч, мэргэжилтнийг хамруулж, АЗ сертификат авсан.	100%
3.13	Төсвийн хөрөнгөөр болон гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл,	Гадаадын болон дотоодын зээл тусламжаар хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн мэдээллийг www.cancer-center.gov.mn цахим хуудсанд тогтмол байршуулан ажилладаг.	100%

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
	хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн		
3.14	Мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан	Хамааралгүй 2024 онд байгууллагын захиалгаар аливаа судалгаа шинжилгээний ажил хийгдээгүй.	
4.1	Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл	Байгууллагын цахим хуудасны үйл ажиллагааны http://www.cancer-center.gov.mn/about-us/pages/services/ хэсэгт үйлчилгээний төрөл, журмын талаар, http://www.cancer-center.gov.mn/ил_тод_байдал/tushaal1/ хэсэгт төлбөртэй үйлчилгээний тушаалыг байршуулж мэдээллийг хүргэж байна. https://www.cancer-center.gov.mn/checkout/tulbur/	100%
5.1	Олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал	Тус төвд бодлогын баримт бичиг, хууль болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэр байхгүй болно.	100%
5.2	Эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт	Оюуны өмчийн эрх байхгүй	
5.3	Хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл,	Газар, барилга байгууламж, түүнд орсон өөрчлөлтийн мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулсан ба цахим хуудаст энэ төрлийн мэдээлэл оруулдаг тусгайлсан цэс үүсгэж мэдээллийг шинэчлэн мэдээлж байна. http://www.cancer-center.gov.mn/%d0%b8%d0%bb-%d1%82%d0%be%d0%b4-%d0%b1%d0%b0%d0%b9%d0%b4%d0%b0%d0%bb/hr/tushaal1/	100%
5.4	Мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл	Эзэмшил газар, газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зургийн мэдээллийг байгууллагын цахим хуудаст ил тод байршуулсан. http://www.cancer-center.gov.mn/download/ ХСҮТ-ийн эзэмшил газрын гэрчилгээ/ УБ, БЗД 18-р хороо, Нам ян жүгийн гудамж	100%
5.11	Нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл	Байгууллагын нууцаас бусад мэдээлэх шаардлагатай мэдээллийг ил тод мэдээллийг доох цахим сүлжээгээр мэдээлэн ажиллаж байна. https://www.facebook.com/nationalcancercentermgj https://www.cancer-center.gov.mn/	100%

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
5.12	Мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт	Байгууллагын зардлаар гадаад улсад суралцаж байгаа хүн байхгүй болно.	100%

ТАЙЛАН ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



/Н.ЭРДЭНЭХҮҮ/

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД,
СУРГАЛТЫН АЛБАНЫ ДАРГА



/Ц.БАДАМСҮРЭН/

ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН



/А.ЦЭНД-ӨЛЗИЙ/